



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Ýäëéí çàñäëéí áí äëí äúí øèí ýòäýë
òðñ°ëä°õ ÷ääääðúí ò°ñ°ë

Монголын ноолуурын салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн дүн ШИНЖИЛГЭЭ

2005 оны 5 дугаар сар
Улаанбаатар хот

Төсөл: Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ)
Тайлангийн нэр: *Монголын ноолуурын салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн дүн шинжилгээ*

Тайлан бичсэн: Дональд Лекро, Филип Эдлестон, Алин Мак Махон
Гэрээний дугаар: 438-С-00-03-00021-00
Байгууллага: ЭЗБШӨЧ төсөл/ Кемоникс интернэйшнл Инк., Монгол Улс,
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж,
Таван Богд Плаза

Утас, факс: (976) 11 32 13 75 Факс: (976) 11 32 78 25
Холбоо барих хүн: Фернандо Бертоли, Төслийн удирдагч
И-мэйл хаяг: fbertoli@eprc-chemonics.biz

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ

АНУОУХА	Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг
АХБ	Азийн хөгжлийн банк
БХАГ	Бизнесийн хамтын ажиллагааны гэрээ
ГХОГХА	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг
ГТХАН	Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОУВС	Олон улсын валютын сан
ОСБОТХХ	Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ	i
ГАРЧИГ	i
ХУРААНГУЙ.....	i
ХЭСЭГ I: УДИРТГАЛ	1
ХЭСЭГ II: ДЭЛХИЙН НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	3
ХЭСЭГ III: МАКРО-ЭДИЙН ЗАСАГ БА МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАР	7
ХЭСЭГ IV: МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН БҮТЭЦ.....	11
ХЭСЭГ V: МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НЭМЭГДСЭН ӨРТӨГ	19
ХЭСЭГ VI: МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРААС НООЛУУРЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД	25
ХАВСРАЛТ А: МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ЭЭРЭХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДЛЫН ҮНЭЛГЭЭ	29
ХАВСРАЛТ Б: НООЛУУРЫН ҮЙЛДВЭРИЙН САНХҮҮЖИЛТ	45
ХАВСРАЛТ В: ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ХҮМҮҮСИЙН ЖАГСААЛТ	53

ХУРААНГУЙ

Монголын ноолуурын салбарын талаар олон судалгааны ажил хийгдэж түүнээс ч олон зөвлөмжүүдийг гаргасан билээ. Түүнчлэн сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд тус салбар нэлээд хэмжээний хөрөнгө оруулалт, хөнгөлөлт, техникийн туслалцааг хүлээн авсан. Гэвч өнөөгийн байдлаар тус салбарын хоёр бүрэлдэхүүн хэсэг болох мал аж ахуйн салбар болон боловсруулах үйлдвэрлэл аль аль нь нэлээд хүнд нөхцөлд байна. Мал аж ахуйн салбарын хувьд малын тоо толгой Монголын газар нутгийн бэлчээрийн даацаас хэтэрч, цөлжилт үүсэхэд нөлөөлөхүйц хэмжээнд хэдийнэ хүрсэн байж болзошгүй боловч мал аж ахуйд төсвөөс их хэмжээний татаас өгсөөр байна. Сүүлийн найман жилийн хугацаанд нэлээд хэдэн боловсруулах үйлдвэр хаалгаа барьж, зарим нь үйлдвэрлэлийнхээ хэмжээг бууруулсан бөгөөд үйлдвэрлэгчид хүчин чадлынхаа 50 хүрэхгүй хувийг л ашиглаж чадаж байна. Монголын түүхий ноолуурын тэн хагас орчмыг нь Хятад уруу хууль бусаар гарган боловсруулж байна. Зах зээлийн хоёр сегментийн аль алинд гажуудал их байгаа бөгөөд ил далд аливаа байдлаар, ээдрээтэй механизмаар төсвөөс их хэмжээний татаас авахаас гадна нөгөө талаас хэтэрхий өндөр татвар төлөх болж байна.

Монголын ноолуурын салбар дэлхийн ноолуурын салбарын бүрэлдэхүүнд багтан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дэлхийн ноолуурын салбар нь дэлхийн хувцасны үйлдвэрлэлийн салбарын нэг хэсэг болдог. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн хувцасны үйлдвэрлэлийн салбар тун хурдацтай өөрчлөгдөж ирсэн. Тухайлбал үйлдвэрлэлийн өртөг, бүтээгдэхүүний үнэ буурч харин загвар дизайны шинэчлэлт хурдассан. Үүний үр дүнд тансаг хэрэглээний хувцасны зах зээлийн хувийн жин буурсан. Үүний зэрэгцээ нэмэгдсэн өртгийн шатачлал дахь үнэ тогтоох, хянах эрх мэдэл нь үйлдвэрлэгчид болон жижиглэнгийн худалдаачдаас брэнд эзэмшигчид рүү шилжиж, хувцасны үйлдвэрлэлийн салбарын оролцогчдын үйл ажиллагааны хүрээ нарийсч, илүү төрөлжсөн. Гэвч үүний зэрэгцээ брэнд эзэмшигчид үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхээ больж, бүтээгдэхүүнээ захиалж хийлгэх хандлага давамгайлдаг болсон.

Монгол Улс дэлхийн ноолуурын 15%-ийг бэлтгэдэг тул 75%-ийг бэлтгэдэг Хятадын дараа дэлхийд хоёрдугаарт орж, Иран, Афганистан, Өмнөд Африк, АНУ, Австрали зэрэг улсуудын өмнө ордог. Сүүлийн хэдэн арван жилийн турш Хятадын Засгийн газар ноолуурын салбартаа санхүүгийн дэмжлэг үзүүлж, бага хүүтэй зээл олгож, нийгмийн салбарт зориулсан татварыг нь хөнгөлж, саяхныг болтол экспортын урамшуулал олгож ирсэн. Гэсэн хэдий ч Хятадын нэг ч үйлдвэрлэгч олон улсын худалдааны сүлжээнд бие даан нэвтэрч чадаагүйн дээр дэлхий нийтэд нэртэй брэнд бий болгох тал дээр бүр ч учир дутагдалтай ажилласан. Гэвч 2005 онд зохион байгуулагдсан Хятадын олон улсын ноолуурын чуулганы үеэр Хятадын эрх баригчид ноолуурын салбарт хэрэгжүүлэх стратегиа ийнхүү тодорхойлсон болно: түүхий ноолуур гаднаас импортлон одоо байгаа илүүдэл хүчин чадлаа бүрэн дүүрэн ашиглан бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, өөрийн брэнд нэрээр (шинээр бий болгосон эсвэл худалдан авсан брэнд) эсвэл нийлүүлэлтийн гэрээгээр гадаадад экспортлох замаар ноолуурын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн бүхий л үе шатыг Хятад улс хяналтандаа авч, зохицуулах¹

Энэ дүн шинжилгээ Монголын ноолуурын салбарын талаар дараах хэдэн дүгнэлтийг гаргаж байгаа юм: зах зээлийн эрэлт хэрэгцээний байр сууринаас харахад Монгол Улс түүхий ноолуурынхаа чанарыг сайжруулахад тэргүүлэх ач

¹ Одоогийн байдлаар Хятадын үйлдвэрлэгчид дэлхийн нийт түүхий ноолуурын 93 хувийг хяналтандаа аваад байна. (Хятадын Дэйли сонин, 2005 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн дугаар.

холбогдол өгөх шаардлагагагүй. Учир нь "ээрсэн алт" буюу дээд зэргийн тансаг хэрэглээний ноолууран хувцасны зах зээлийн хувийн жин буурч байгаа юм. Түүнчлэн үйлдвэрлэгчдэд олон улсын хэдийнэ бүрэлдэн тогтсон бүтээгдэхүүн түгээлтийн сүлжээнд бие даан нэвтрэн орох эсвэл өөрийн брэндийг шинээр бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх хэрэггүй. Учир нь дээд зэрэглэлийн тансаг хэрэглээний зах зээлийн хувьд салбарын эдгээр хэсгүүд хэдийнэ эзлэгдсэн. Нөгөө талаас гадны үйлдвэрлэгчдийг мал аж ахуйн салбарт оролцуулах зорилгоор Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын талаарх хууль тогтоомжуудад өөрчлөлт хийх хэрэггүй. Тэд угаасаа энэ салбар луу орохгүй. Хамгийн чухал нь Монгол Улсын Засгийн газар болон ноолуурын үйлдвэрлэгчид шуурхай бөгөөд шийдвэртэй арга хэмжээ авахгүй бол Монгол Улс ердөө л түүхий ноолуурын нийлүүлэгч болон хувирч, ноолуурын үйлдвэрлэлийн салбар цаашид ч улам доройтоход хүрнэ. Нөгөө талаас өнөөдөр Хятадаас бусад орны ноолуурын үйлдвэрлэгчид Хятадын үйлдвэрлэгчдийн зүгээс нүүрлэж буй аюулын эсрэг авах хариу арга хэмжээг идэвхтэй хайж байгаа учир Монголын үйлдвэрлэгчид шалмаг хөдөлж чадвал эдгээр дэлхийн түвшний тоглогчидтой эвсэж болно.

Монголын макро-эдийн засгийн орчин ноолуурын салбарын хөгжилд төдийлөн ээлтэй биш байна. Сүүлийн таван жилийн хугацаанд доллар, юаньтай харьцах төгрөгийн бодит ханш дээшилсэн бол тухайн хугацаанд Хятадын юаний бодит ханш доллартай харьцуулахад тодорхой хэмжээгээр буурсан.² Ханшийн эдгээр өөрчлөлтүүдийн улмаас Монгол дахь үйлдвэрлэлийн зардал Хятадынхтай харьцуулахад өмнөхөөсөө ч илүү өндөр болсон. Монголын Засгийн газар нийгмийн халамжийн зардлаа (ажилгүйчүүд, малчид, тэтгэвэрийнхэнд тэтгэвэр, тэтгэмж олгохын тулд) харьцангуй өндөр тогтоосон учир Монгол шиг төсөвтэй орны хувьд ажиллах хүчний цалингийн зардал нэлээд өндөр байгаа юм. Тиймээс ч ажилгүйдэл, ажлын байрны хүрэлцээгүй байдал түгээмэл байгаа нь санамсаргүй явдал биш юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 30% (ЖДҮ-ийн хувьд 15%) болгон бууруулсан ч энэ нь харьцангуй өндөр хэвээр байна. Ялангуяа ноолуурын салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор олгодог татвараас чөлөөлөх хугацаа харьцангуй богино байдгийг харгалзан үзвэл орлогын татвар өндөр байна.³ Засгийн газрын төсвийн зарлага өндөр байгаа бөгөөд улам нэмэгдэж байна. Түүний нэлээд хэсэг нь улам бүр өргөжин тэлж буй төрийн аппарат, түүний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагддаг.⁴ Эцэст нь, хадгаламж болон зээлийн хүүгийн хоорондын ялгаа болох бодит хүүгийн хэмжээ маш өндөр байна. Зээлийн хүү өндөр байгаа нь маш бага хүүтэй зээл авах боломжтой байдаг Хятадын компаниудтай харьцуулахад Монголын компаниудын хувьд томоохон сул тал болж байгаа юм.⁵

Монголын Засгийн газрын зүгээс ноолуур боловсруулах салбарт олгох зээлийн хүүг бууруулах (ЗГ өөрөө салбарт зээл олгоно гэсэн үг биш); нийгмийн татварыг аажмаар бууруулах, бодит ханшийг тогтвортой байлгах, орлогын татварыг дахин бууруулж бүх аж ахуйн нэгжид 15 хувь болгох (татвараас чөлөөлөх хугацааг

² Төгрөгийн юаньтай харьцах бодит ханш 25%-иар дээшилсэн бол доллартай харьцах ханш 10%-иар дээшилсэн.

³ Татварын хуулийн дагуу татварын өмнөх орлогоос хурдасгасан элэгдэл хорогдлыг хасч боддоггүй, татварын тайлангийн алдагдлыг дараачийн үе рүү шилжүүлж боддоггүй, мөн бусад хасалтуудыг хийж боддоггүй юм байна. Экспортод чиглэсэн үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулагчдыг 3 жилийн хугацаагаар татвараас чөлөөлдөг (дахин 3 жил 50 хувийн хөнгөлөлт эдлүүлдэг) хөнгөлөлтийг ноолуурын үйлдвэрүүд эдэлж болно.

⁴ 1990 оноос хойш багш нар, улсын эмнэлгийн эмч нар, зэвсэгт хүчин, цагдаагийн ажилтнуудыг оруулаагүй тоогоор төрийн албан хаагчдын тоо 10 мянгаас 60 мянгад хүртэл өссөн.

⁵ Жилд 6%-ийг төлдөг Хятадуудын компаниудтай харьцуулбал Монголын компаниуд жилдээ 35 орчим %-ийг төлдөг.

байхгүй болгож, үүний зэрэгцээ хурдасгасан элэгдэл, хорогдол, алдагдлыг татварын тайланд тусгадаг болох) зэрэг арга хэмжээг авах шаардлагатай. Түүнчлэн ноолуурын салбарт гадны хөрөнгө оруулалтыг татаж, дэмжих үүднээс гадаадын хөрөнгө оруулалтын тогтолцоог улам боловсронгуй болгож, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн (ГХОГХА) чадавхийг улам бэхжүүлж, хөрөнгө оруулагчдад тулгардаг хүнд суртлын саад бэрхшээлийг багасгах шаардлагатай байна.

Ноолуурын салбар бүтцийн хувьд хэтэрхий ээдрээтэй, үйл ажиллагаа нь нэлээд доголдолтой байна. Мал аж ахуйн салбар төрөөс ихээхэн хэмжээний татаас авч байна. Тухайлбал, малчид татвар бараг төлдөггүй, эрүүл мэндийн үйлчилгээ үнэгүй, малын ундны ус үнэгүй, малын тэжээлд татаас өгдөг, мөн тэтгэвэрийн сан, эрүүл мэндийн болон тахир дутуугийн даатгалын сангуудад татвар төлдөггүй. Нөгөө талаас ямаан сүргийн тоо толгой мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэхэд шаардагдах хэмжээнээс даван гарсан байж болзошгүй бөгөөд цөлжилт үүсгэж, Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлж эхлээд байгаа. Малчид улс төрийн хувьд нөлөөтэй байж болох ч (сонгогчдын нэлээд хэсгийн бүрдүүлдэг утгаараа) эдгээр татаасуудыг халж, ямааны тоо толгойд ноогдуулж буй малын хөлийн нэр төдий татварыг нэлээд хэмжээгээр нэмэх шаардлагатай.

Монголын түүхий ноолуурын чанар сүүлийн жилүүдэд аажмаар муудсан бөгөөд энэ чиг хандлагыг зогсоох, залруулах гэсэн олон төсөл, Засгийн газарт өгсөн олон тооны зөвлөмжүүд төдийлөн тус болоогүй. Эдгээр төсөл, судалгааны ажлууд нэг чухал нөхцлийг дутуу үнэлсэн юм шиг санагддаг: ноолуурын чанар (ноолуурын ширхэгтийн голчоор хэмжигддэг) сайжрах тусам нэг ямаанаас гарах ноолуурын гарц буурдаг. Жишээ нь ширхэгтийн голч 17,5-аас 15,5 болон 2 микроноор багасхад (дундаж үзүүлэлтээс сайн хүртэл) ноолуурын гарц ойролцоогоор 24 хувиар буурдаг. Гэтэл Монголын зах зээл дээр ч, олон улсын зах зээл дээр ч чанараас хамаарсан үнийн нэмэгдэл дөнгөж 15% орчим байдаг. Тиймээс малчид өөрсдийнх нь орлогод муугаар нөлөөлөх ширхэгтийн голчийг бууруулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа нь ойлгомжтой.

Боловсруулах салбарын бүтэц ч бас хамгийн зохистой хэлбэрээс хол байна. Салбарын хамгийн том компани бөгөөд бүх шатны боловсруулалт хийдэг хамгийн том цогц үйлдвэр болох Говь төрийн өмчийнх. Засгийн газар Говь үйлдвэрийг хувьчлах талаар сүүлийн 6 жилд ярьж байна. Гэсэн ч хувьчлалыг дахин хойш тавих шийдвэрийг 2005 онд гаргалаа. Энэ хугацаанд Говь үйлдвэр жилд 2 сая ам. долларын алдагдалтай ажиллаж ирсэн. Үйлдвэр, түүний тоног төхөөрөмж ерөнхийдөө хуучирсан, засвар үйлчилгээ хангалтгүй, ажилчдын мэдлэг чадвар хангалтгүй, менежментийн чадвар сул, бүтээмж доогуур, "гарц"-ын хэмжээ нь (дамжлагад орж буй жинг гарч буй жинтэй харьцуулсан үзүүлэлт) дэлхийн шилдэг туршлагад хүрэхгүй байна. Түүнчлэн тус үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар доогуур байгаа бөгөөд энэ нь бүтээгдэхүүнийх нь үнэ олон улсын зах зээл дээр доогуур байдгаар илэрдэг. Хоёр дахь том цогц үйлдвэр болох Буян хувийн өмчийнх. Энэ үйлдвэр санхүүгийн хувьд томоохон асуудалтай байгаа бөгөөд түүхий эдээ худалдан авах эргэлтийн мөнгөөр гачигдаж байна. Энэ хоёр үйлдвэрийн хоёулангийнх нь хувь заяа салбарын хувьд асар том асуултын тэмдэг болоод байгаа бөгөөд хөрөнгө оруулагчид шинээр хөрөнгө оруулах эсвэл одоо байгаа үйлдвэрээ өргөжүүлэхээс түдгэлзэх байдалд хүргэж байна. Тиймээс Засгийн газар Говь үйлдвэрийг яаравчлан хувьчлах арга хэмжээг авах шаардлагатай бөгөөд Говьд төсвөөс урьдчилсан санхүүжилт олгох эсвэл зээл олгох хэрэггүй.

Боловсруулах салбарын бусад олон компани мөн адил хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал: үйлдвэрлэлийн бүтээмж муу, ажиллах хүчний зардал

өндөр, чанар жигд биш, загвар зохион бүтээх чадвар хангалтгүй, экспортын зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулах чадвар дутмаг байна. Тэдэнд үйлдвэрлэл, ажилчдын мэргэжил чадварыг сайжруулах сургалт, бүтээгдэхүүний чанар, дизайн, экспортын маркетинг зэрэг чиглэлээр техникийн туслалцааг тогтмол үзүүлэх шаардлагатай.

Үйлдвэрлэлийн шат дамжлага тус бүрийн нэмэгдсэн өртгийн дүн шинжилгээ хийж үзэхэд тус салбарын доторх гажуудал, доголдлууд илэрч байна. Тухайлбал ээрэхээс бусад үйлдвэрлэлийн бүх шат дамжлагад маш их илүүдэл хүчин чадал байна. (Ээрэхийн хувьд хүчин чадлын 77% ашиглагдаж байна); ноолуурын ихэнх нь нэмэгдсэн өртөг бага шингэсэн хэлбэрээр (түүхий эсвэл самнасан ноолуур, бөмбөгөн ноолуурын хэлбэрээр) экспортлогдож байна. Бүтээгдэхүүний чанар тун харилцан адилгүй байна. Энэ нь бүтээгдэхүүний үнэ харилцан адилгүй байгаагаар илэрч байна. Боловсруулах үйлдвэрүүдийн нэмэгдсэн өртгийн үе шатыг загварчлан авч үзэхэд хэрэв үйлдвэрүүд олон улсын жишигт нийцсэн хүү багатай зээл олох боломжтой бол, үйлдвэрлэлийн гарцын хэмжээг хамгийн шилдэг туршлагад хүргэж, өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадвал дээр дурдсан бэрхшээлүүдийг үл харгалзан хөрөнгө оруулагчиддаа боломжийн ашиг орлого оруулж чадна. Хэрэв үйлдвэр Монголд 37% орчим байдаг зээлийн хүүг төлөх ёстой бол ашигтай ажиллахад хүндрэлтэй. Түүхий эд боловсруулалтаас бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэлх бүх шат дамжлагыг явуулдаг үйлдвэрийн хувьд 37%-ийн зээлийн хүү төлөх тохиолдолд капиталын өртөг ажиллах хүчний зардлаас ойролцоогоор 6 дахин илүү байдаг.⁶ Иймээс үйлдвэрийг гадаадынханд хувьчлах, гаднаас зээл авах эсвэл захиалагчдаас төлбөрийг нь урьдчилан авах зэрэг арга хэмжээг авахгүй бол ийм нөхцөлд ажиллахад их хүндрэлтэй.

Монгол Улсын Засгийн газар дараах гурван сонголттой тулгараад байна: экспортын татварыг нэмж, татвар хураалтыг сайжруулж, татварын хүчинтэй байх хугацааг цаашид сунгах, боловсруулах үйлдвэрийн салбарт шууд татаас олгох эсвэл одоогийн байдлыг хэвээр хадгалах. 1997 онд Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэхдээ түүхий ноолуурын экспортын хоригоо цуцалж, оронд нь 1 кг ноолуурт 4,000 төгрөгийн экспортын татвар тогтоосон. (Тухайн үедээ энэхүү татвар ноолуурын үнийн 30 орчим хувьтай тэнцэж байсан.) Одоогийн үнэ ханшаар энэ татвар ноолуурын үнийн 12 хувьтай тэнцэж байгаа юм. Гэвч 2000 оны үеэс хууль бусаар ноолуур гаргах явдал маш их хэмжээгээр өссөн нь татварын үр ашгийг бууруулсан. Энэ татвар 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дуусгавар болно. Монголын Засгийн газар энэхүү татварыг дахин 10 жилийн хугацаатайгаар сунгаж, хураалтыг нь сайжруулахад анхаарч болох юм. Тус татварын хураалтыг сайжруулахын тулд хураасан татварын орлогын тодорхой хувьтай тэнцэх урамшууллыг гаалийн байцаагчдад олгох, эсвэл хууль бусаар хил давуулж буй ноолуурыг илрүүлсэн тохиолдолд үнийн дүнгийн тодорхой хувиар урамшуулах зэрэг арга хэрэглэж болох юм. Энэ арга хэмжээ нь мал аж ахуйн салбараас нэлээд хэмжээний татаасыг боловсруулах үйлдвэрлэлд шилжүүлж байгаа хэрэг болно. Ингэснээр энэ хоёр салбарын зэх зээл, үнийн гажуудал цаашид үргэлжлэх болно. Ийм гажуудал, буруу тогтолцоог гүнзгийрүүлэх биш харин багасгах хэрэгтэй.

⁶ Жилд 200 тонн түүхий ноолуур боловсруулж, 300,000 ширхэг сүлжмэл цамц үйлдвэрлэдэг үйлдвэр ойролцоогоор 6 сая ам. долларын үнэтэй үйлдвэр, тоног төхөөрөмжтэй байх ёстой бөгөөд дунджаар 3 сая орчим долларыг ноолуурын нийлүүлэлтдээ зарцуулах ёстой. 37%-ийн хүү төлөх тохиолдолд жилд ойролцоогоор 3.3 сая ам. доллартай тэнцэх капиталын өртөг шаардлагатай бөгөөд энэ нь 600 мянган доллартай тэнцэх ажиллах хүчний зардлаас 5 дахин их байна.

Хятадын ноолуур боловсруулах үйлдвэрүүд сүүлийн 30 жилийн хугацаанд татаас авч ирсэн бөгөөд Монголчууд тэдэнтэй өрсөлдөж чадахааргүй хүчтэй болсон. Дашрамд дурдахад Хятадын Засгийн газар экспортын татварыг ашиглан ноолуурын зах зээлдээ хэзээ ч гажуудал үүсгэж байгаагүй. Харин маш бага хүүтэй зээл олгож, ноолуурын салбарынхны төлөх нийгмийн чиглэлийн татваруудыг хөнгөлж, үйлдвэрлэлийн түвшнээс хамааран экспортын урамшууллыг төлж байсан. Онолын хувьд Монголын Засгийн газар үүнтэй төстэй хөтөлбөрийг хэрэгжүүлж болох юм. (ДХБ-ын гишүүн учир экспортын урамшуулал өгч болохгүй) Гэвч Монгол Улсын Засгийн газар иймэрхүү шууд татаас өгөх хөрөнгө байхгүй.

Эцэст нь, Монгол Улсын Засгийн газар үйлдвэрлэлийн салбартаа урамшуулал үзүүлэлгүйгээр дээр дурдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлж болох юм. Гэхдээ энэ тохиолдолд Монголын ноолуурын үйлдвэрлэлийн салбар нуран унаж болзошгүй гэдэгт бэлэн байх ёстой. Учир нь Хятад улс дэлхийн ноолуурын гол үйлдвэрлэгч болж, Монголыг зөвхөн түүхий эдийн эх үүсвэр болгох стратегийг ил тод баримталж байгаа юм. Хятад энэ бодлогоо хэрэгжүүлэх бол, Монголын Засгийн газар Хятадыг хэрхэн нэгдсэн дуу хоолойтой болж, Монголын ноолуурын үнийг буулган, өөрөө дан ганц худалдан авагч нь болох үйл ажиллагааг эхлэхийг хүлээх болно.

Монголын Засгийн газар ноолуурын салбарын хувьд иймэрхүү хүнд сонголтуудтай тулгараад байна. Энэхүү тайлангийн зорилго нь үйлдвэрлэлийн үе шат тус бүрийн нэмэгдсэн өртгийн дүн шинжилгээг хийх арга барилыг ашиглан ноолуурын салбарт дүн шинжилгээ хийх, салбарын үйлдвэрлэлийн зардал, өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг тодруулж, Монголын Засгийн газарт ноолуурын салбарынхаа талаар авч хэрэгжүүлж, болох арга хэмжээний хувилбарыг санал болгоход оршино.

ХЭСЭГ I: УДИРТГАЛ

Монгол Улсын эдийн засаг дахь ноолуурын салбарын ач холбогдол нь тодорхой билээ: энэ салбар улсын нийт хүн амын гуравны нэгээс илүү хувийг ажил болон орлогын эх үүсвэрээр хангадаг бөгөөд түүхий ноолуур, ноолууран бүтээгдэхүүн Монголын экспортын бүтээгдэхүүн дотроос гуравдугаарт ордог. Эрч хүчтэй, хөдөлгөөнтэй ноолуурын салбар нь улс орны эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэлийн салбар, мал аж ахуй болон үйлдвэрлэлийн салбарын хөдөлмөр эрхлэлт, экспорт зэргийн өсөлтөд хувь нэмэр оруулах боломжтой. Гэхдээ ноолуурын салбар нь дэлхийн зах зээл дээрх ноолуурын эрэлт хэрэгцээ, үнээс хамаараад зогсохгүй Монголын байгаль цаг уурын эрс тэс өөрчлөлтүүд⁷ болон Хятадын зүгээс нүүрлэх хатуу ширүүн өрсөлдөөнөөс хамааралтай. Энэхүү өрсөлдөөн нь Хятадын боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эд болдог түүхий ноолуурын төлөө өрсөлдөөнөөс гадна Хятадад үйлдвэрлэсэн хагас боловсруулсан болон бэлэн ноолууран бүтээгдэхүүнтэй дэлхийн зах зээл дээр өрсөлдөх өрсөлдөөн юм.

Монгол Улсад жилд гурван мянга гаруй тонн ноолуур бэлтгэдэг нь дэлхий дээр нийт бэлтгэгддэг 16 тонн ноолуурын 15% нь болдог ба Хятад улс 75%-ийг нь бэлтгэдэг. Ноолуур болон ноолууран бүтээгдэхүүний Монголын цэвэр экспорт 2004 онд 57 сая ам. доллартай тэнцүү байсан.⁸ Монголд бэлтгэгддэг түүхий ноолуурын 50 орчим хувийг хууль бусаар хил давуулан Хятад уруу гаргадаг бөгөөд бодит цэвэр экспортын нийт хэмжээ ойролцоогоор 97 сая ам. доллартай тэнцэнэ. Хэрэв Монголд бэлтгэгддэг ноолуурыг бүгдийг нь Монголд бүрэн боловсруулж сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн хийж экспортлодог байсан бол экспорт нийтдээ 206 сая ам. доллартай тэнцэж, үйлдвэрлэлийн салбар дахь ажил эрхлэлт хоёр дахин нэмэгдэж, долоон мянга орчимд хүрэх байсан.

Ноолуурын салбарыг хөгжүүлэх талаарх Монголын Засгийн газрын зорилт нь тус салбарыг улс орны эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад жинтэй хувь нэмэр оруулж чадахуйц салбар болгон хөгжүүлэхэд оршино. Энэхүү давхар зорилгод хүрэхийн тулд түүхий ноолуур өгдөг ямааг өсгөн үржүүлж буй малчдын хөгжилд болон түүхий ноолуурыг экспортлохоос өмнө өртөг нэмдэг боловсруулах салбарт Засгийн газар туслах хэрэгтэй. Засгийн газар малчдын хүүхдүүдэд үнэгүй боловсрол олгож, малчдаас татвар бараг авдаггүйн дээр (зөвхөн багахан хэмжээний малын хөлийн татвар ноогдуулдаг боловч малчид бүрэн төлөхөөс зайлсхийх нь элбэг байдаг) тэдэнд худгийн усыг үнэгүй ашиглуулж, малын тэжээлийг хөнгөлөлттэй үнээр нийлүүлдэг.

1997 оныг дуустал Засгийн газар үйлдвэрлэгчдэд зориулж түүхий (угаагаагүй) ноолуурын экспортод хориг тогтоож байсан (ингэснээр түүхий ноолуурын үнийг бууруулж, үйлдвэрлэгчдэд илүү хүртээмжтэй болгосон). Үүний үр дүнд тус салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, хамтарсан үйлдвэрүүд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Гэвч 1997 онд Монгол Улс ДХБ-д гишүүнээр элсэн ороход Засгийн газар түүхий ноолуурын экспортод тавьсан хоригоо цуцалж, оронд нь 1 кг ноолуурт 4,000 төгрөгийн экспортын татвар ноогдуулсан. Тухайн үед

⁷ Мал аж ахуйн салбарыг либеральчилснаас хойш ямаан сүргийн тоо толгой 1990 онд 5,1 сая байсан бол 1999 он гэхэд 11 сая болтлоо өссөн. Ноолуурын үнэ бага байсны улмаас мөн дараалсан гурван жил зудын аюул (ямааны төлийн 20 орчим %-ийг авч одсон) нүүрлэсний улмаас ямаан сүргийн тоо 2002 он гэхэд 9 сая болж буурсан боловч 2004 он гэхэд эргээд нэмэгдэж, 12 сая болсон.

⁸ Нийт экспортын дүн 79 сая ам. доллар байсан ч Монголд 23,5 сая долларын үнэ бүхий самнасан ноолуур, эрмэл орж ирсэн. Гэхдээ 2004 он онцгой жил байсан. Бусад онуудад 7-10 сая ам. долларын бүтээгдэхүүн импорт орж ирж байсан бөгөөд ихэнх нь эрмэл байсан.

энэхүү татвар нь түүхий ноолуурын үнийн 30 орчим хувьтай тэнцэж байсан. Түүнчлэн Засгийн газар энэхүү экспортын татварыг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчингүй болгохоор шийдсэн. Гэвч 1997 оноос хойш төгрөгийн ханш унаж, дэлхийн зах зээл дээрх ноолуурын үнэ нэмэгдэсний улмаас 4,000 төгрөг 1 кг түүхий ноолуурын 12 орчим хувьтай тэнцэж байна. Үүний зэрэгцээ 2000 оны үеэс гаалийн ажлын зохион байгуулалтад өөрчлөлт орсны улмаас түүхий ноолуурыг их хэмжээгээр хууль бусаар Хятад уруу гаргаж өндөр үнээр зарах нөхцлийг бүрдүүлснээр барахгүй бараг хөхүүлэн дэмжих болсон.

Эдгээр шалтгааны улмаас Монголын ноолуур боловсруулах үйлдвэрийн салбар хүнд бэрх цаг үетэй тулгарсан: олон компаниуд тус салбарыг орхин гарсан хэдий ч үйлдвэрлэлийн бүх үе шатанд хүчин чадлын ашиглалт хангалтгүй байгаа бөгөөд үүний улмаас салбарын олон үйлдвэр алдагдал хүлээн ажиллаж байна. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний олон талт худалдааны хэлэлцээр дуусгавар болсноор Хятад эзэнтэй хэд хэдэн компаний хувьд байдал улам дордож, нэг бол үйлдвэрээ бүхэлд нь хаах эсвэл сүлжмэлийн хэсгээ Хятад уруу буцаан татах хэрэгтэй болсон.

Ноолуур боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд дараах хоёр асуудал тулгарч байна: түүхий ноолуур нөөцөлж авахад шаардагдах эргэлтийн хөрөнгө өндөр хүүтэй бөгөөд Монголоос түүхий ноолуур худалдан авч, Хятад уруу хууль бусаар гаргадаг наймаачидтай (“ченжүүд” хэмээх) ноолуурын үнэн дээн өрсөлдөх хэрэгтэй болдог. (Монголын үйлдвэрлэгчдийн ярьж байгаагаар эдгээр “ченжүүд”-ийн ноолуур авдаг үнэ нь дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд өрсөлдөж авах, ашиг олоход хэцүү хэт өндөр үнэ байдаг ажээ.) Эдгээр асуудлаас гадна Монгол дахь ажиллах хүчний зардал Хятадын Өвөр Монголынхоос өндөр боловч хөдөлмөрийн бүтээмжийн хувьд доогуур байдаг. Цөөн хэдэн үйлдвэрийг эс тооцвол ихэнх үйлдвэрийн ажиллах хүч болон удирдлагын чадавхи доогуур, машин, тоног төхөөрөмжийн арчилгаа тааруу байгаа бөгөөд үүнтэй уялдан чанарын доголдол гарч байна. Монголын түүхий ноолуурын чанар (ширхэгтийн голчийн микроноор хэмжигддэг) муудаж байгаа нь чанарын энэхүү асуудлыг улам дордуулж байна.

Хэрэв Монголын Засгийн газар ноолуурын салбартаа туслахын тулд одоо авч буй 4,000 төгрөгийн татвараа анхных нь байдлаар ноолуурын үнийн 30%-тай тэнцэх болгон нэмж, хууль бус экспортыг багасгах зорилгоор татварын хураалтыг сайжруулж, тухайн татварын үйлчлэх хугацааг 10 жилээр сунгавал малчдын эрх ашиг хохирно. Малчдын тоо (өөрөөр хэлбэл сонгогчдын тоо) үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй ажилчдын тооноос илүү. Ийм арга хэмжээ нь Засгийн газрын зорилтуудын нэг болох Монголын ноолуурын салбарыг либеральчлахын оронд улам доройтуулна. Мөн ийм арга хэмжээ авсан ч ноолуур боловсруулах салбарт дорвитой өөрчлөлт гарахгүй. Салбар цаашид ч доройтсоор байх бөгөөд илүү олон тооны компаниуд салбарыг орхин гарч, хөдөлмөр эрхлэлт буурч, ноолуурын салбар дахь нэмэгдсэн өртөг ерөнхийдөө буурч, ноолуурын экспорт ч мөн багасна.

Монголын Засгийн газар ноолуурын салбарын хувьд иймэрхүү хүнд сонголтуудтай тулгараад байна. Энэхүү тайлангийн зорилго нь үйлдвэрлэлийн үе шат тус бүрийн нэмэгдсэн өртгийн дүн шинжилгээг хийх арга барилыг ашиглан ноолуурын салбарт дүн шинжилгээ хийх, салбарын үйлдвэрлэлийн зардал, өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг тодруулж, Монголын Засгийн газарт ноолуурын салбарынхаа талаар авч хэрэгжүүлж болох арга хэмжээний хувилбарыг санал болгоход оршино.

ХЭСЭГ II: ДЭЛХИЙН НООЛУУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

Монголын Засгийн газар ноолуурын салбарын асуудлууд, тус салбарт хэрэгжүүлэх бодлогын чанартай арга хэмжээнүүдээ авч үзэхдээ дэлхийн хувцасны болон оёмол, сүлжмэлийн салбарын чиг хандлага, тухайн салбар дахь ноолуурын үйлдвэрлэлийн салбарын байр суурь, мөн Монголын ноолуурын салбарын дэлхийн зах зээл дэх өрсөлдөх чадвар зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд ажиллах хүч хямд орнууд дахь хувцасны үйлдвэрүүдийн (сүүлийн үед ээрмэлийн болон нэхмэлийн үйлдвэрүүд нэмэгдсэн) зүгээс нүүрлэж буй өрсөлдөөний улмаас ажиллах хүч үнэтэй орнууд илүү хурдан, илүү өндөр бүтээмжтэй, илүү өндөр үнэтэй тоног төхөөрөмж ашиглан илүү өндөр чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс өөр аргагүй болсон. Энэхүү чиг хандлагын үр дүнд өндөр үнэтэй хувцасны үнэ урьдынхаасаа хямд үнэтэй болж, цалин багатай орнуудад үйлдвэрлэгдэж буй хувцас, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн. ОСБОТХХ дуусгавар болсон нь эдгээр чиг хандлагыг улам эрчимжүүлсэн.

Үүний хариуд, мөн бүтээгдэхүүний нэгжийн үнэ улам бүр буурч байгаатай холбогдуулан хувцасны үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ загвар, дизайныг шинэчлэх хугацааг богиносгож, жилд дөрвөн удаа (дөрвөн улиралд) өөрчлөхийн оронд 8 удаа эсвэл бүр сар тутам өөрчлөх замаар нэгжийн борлуулалтыг сайжруулах арга хэмжээ авч эхэлсэн. Хувцасны үйлдвэрлэлийн салбар нь жижиглэнгийн худалдааны стратегиа өөрчилж, бүтээгдэхүүний үнийг өндөр тогтоох, нэр, төрлийг нь олон байлгах (олон янзын стиль, өнгө, хэмжээтэй), мөнгөний эргэлт удаан, барааны илүүдэл ихтэй стратегиас татгалзаж, түүний оронд үнэ багатай, хязгаарлагдмал тооны стиль, өнгө, хэмжээтэй, мөнгөний эргэлт хурдантай, илүүдэл багатай систем рүү шилжсэн. Түүний зэрэгцээ үйлдвэрлэгчид болон жижиглэнгийн худалдааны дэлгүүрүүдийн эрх мэдэл багасч, өнгө, загвар, хэмжээ, эрэлт хэрэгцээ зэрэгтэй холбоотой эрсдлийг үүрдэг брэнд эзэмшигчдэд шилжсэн. Эдгээр чиг хандлагын улмаас үйлдвэрлэл, худалдааны бүхий л үйл ажиллагааг хянахад компаниудын хувь хэтэрхий хүнд болсон тул тухайн салбарт үйл ажиллагааны төрөлжилт явагдаж, нэмэгдсэн өртгийн үе шатууд дахь үйл ажиллагааг өөр өөр компаниуд эрхлэн явуулах болсон.

Жилдээ 3 мянга гаруй тонн түүхий ноолуур бэлтгэдэг Монгол улс жилд 12 орчим тонныг бэлтгэдэг Хятадын дараа дэлхийд хоёрдугаарт ордог.⁹ Орос, Иран, Афганистан улсууд Монголоос бага хэмжээний ноолуур бэлтгэдэг бөгөөд чанарын хувьд тэдний ноолуур Монголынхоос доогуур байдаг. АНУ, Австрали, Өмнөд Африкт маш бага хэмжээний ноолуур бэлтгэдэг.¹⁰ Жилд 20 сая ноолууран цамц үйлдвэрлэх хүчин чадалтай Хятад улс дэлхийн сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тэргүүлдэг. Итали улс хэдийгээр хөдөлмөрийн хөлс өндөртэй улс

⁹ Монголын ноолуурын салбарын талаарх ихэнх тоо баримтын нэгэн адилаар үйлдвэрлэлийн тоо баримтууд дараах хоёр шалтгааны улмаас гажуудуулсан, бодит бус байж болзошгүй. Түүхий ноолуурын бэлтгэлийн хэмжээг тооцохдоо бүртгэгдээд байгаа ямааны тоо толгойг нэг ямаанаас гарах ноолуурын дундаж гарцаар үржүүлж боддог. Монголын ямаан сүргийн нийт тоо нь бодит бус мэдээлэл байж болзошгүй. Учир нь Монголын Засгийн газар малын хөлийн татварыг тоогоор нь тогтоодог тул малчид малаа дутуу тоолуулах сонирхолтой байж болно. Хоёрдугаарт доор дурдсанчлан ямааны ноолуурын дундаж чанар сүүлийн жилүүдэд муудсан. (ноолуурын ширхэгтийн голчийг микроноор хэмжихэд). Ноолуур бүдүүн байх тусам нэг ямаанаас гарах гарц өндөр тул Монгол ямааны гарц 20 жилийн өмнөхөөсөө 20% орчмоор илүү байх магадлалтай.

¹⁰ Дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн талаарх өөр өөр эх сурвалжийн мэдээллүүд хоорондоо нийцэхгүй байх нь элбэг тохиолддог. Зарим эх сурвалжууд дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн хэмжээг 19 мянган тонн гэж үздэг бөгөөд үүнээс 14 мянган тонн нь Хятадад ноогддог гэж үздэг.

боловч ноолууран ээрмэл, сүлжмэл, нэхмэлийн зах зээлийн дээгүүр хэсэгт тэргүүлсэн хэвээр байна.

Хятад улсын ямааны аж ахуй, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийн салбарын дийлэнх хэсэг нь Хятадын хамгийн ядуу бүс нутгуудын нэг болох Өвөр Монголд байрладаг. 1970-аад оноос эхлэн Хятадын Засгийн газар ноолуур боловсруулах салбартаа ихээхэн хэмжээний татаас олгож эхэлсэн. Үүнд: бага хүүтэй зээл олгох, үнийн зохицуулалт хийх, ажилчдын нийгмийн халамжийн болон байр орон сууцны татвараас үйлдвэрүүдийг чөлөөлөх, экспортын орлогын тодорхой хэсэгтэй тэнцэх татварыг буцаан олгох (боловсруулалтын үе шат өндөр байх тусам хөнгөлөлтийн хувь ихэсдэг байсан) замаар экспортын урамшуулал үзүүлэх зэрэг багтаж байв. Түүнчлэн худалдаачдад зориулсан лицензийн чанга журмыг тогтоож, гадаадын ямар ч худалдаачинд зөвшөөрөл өгдөггүй байсан. Хятад улс ДХБ-д нэгдэхдээ экспортын урамшууллаа зогсоохыг зөвшөөрсөн. Түүнчлэн банкны зээлийн хүүг багасгах зорилгоор олгож байсан татаасаа зогсоохыг зөвшөөрсөн. Гэхдээ банкны зээлийн хүү Хятадад тун бага хэвээр байгаа.¹¹

Дэлхийн ноолуурын салбарт хувцасны үйлдвэрлэлийн салбарынхтай адил чиг хандлагууд ажиглагдсан. Үүнд: өртөг, үнэ буурч, дээд зэрэглэлийн бүтээгдэхүүний зах зээл ерөнхийдөө агшсан, үйл ажиллагааны төрөлжилт, хуваарилалт явагдаж, зах зээл дээрх брэнд эзэмшигчдийн давамгайлал тогтсон гэх мэт. Эдгээр чиг хандлагууд хэр эрчимтэй явагдаж байгаагийн жишээ болгон дурдахад 10 жилийн өмнө Доусон нь дэлхий дээрх хамгийн том ноолууран бүтээгдэхүүний цогц үйлдвэрлэгч байсан бөгөөд дэлхийн ноолуурын үйлдвэр, худалдааны томоохон хэсгийг эзэмшдэг байсан. Одоогийн байдлаар Доусон үйл ажиллагааны хувьд ч, газарзүйн хувьд ч төрөлжин хуваагдсан бөгөөд хуваагдсан хэсгүүдийн эзэд нь өрсөлдөөн ихтэй дэлхийн ноолуурын шинэ нөхцөлд оршин тогтнолоо хадгалах гэж нэлээд зовж байна.

Ноолууран бүтээгдэхүүний үнэ буурч, дунд болон доогуур зэрэглэлийн чанартай бүтээгдэхүүний зах зээл дэх эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа ч “ээрсэн алт” буюу тансаг хэрэглээний өндөр үнэтэй ноолууран бүтээгдэхүүний зах зээл байсаар байна. Энэ зах зээлийг Гуччи, Данхил, Ральф Лорен зэрэг дээд зэрэглэлийн брэнд эзэмшигч “үйлдвэрлэгчид”, мөн түүнчлэн Брукс Бродерс болон сүүлийн үед гарч ирсэн Жэй Крю зэрэг жижиглэнгийн худалдаачид эзэгнэж байгаа юм. Эдгээр компаниуд өөрийн гэсэн үйлдвэр байхгүй, өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, худалдааны бүх үе шатанд оролцдоггүй. Харин тэд өөрийн брэндийнхээ бүтээгдэхүүний загвар, чанар зэргийг хяналтандаа байлгахын дээр өөрийн дэлгүүрээр бүтээгдэхүүнээ борлуулах уу эсвэл их дэлгүүрүүдээр дамжуулан борлуулах уу гэдгээ шийддэг. Дараагийн бүлэгт дүн шинжилгээ хийсэнчлэн Монголын түүхий ноолуурын дундаж чанар муудсан нь чанар муутай ноолуурын хэмжээ ихэссэнтэй холбоотой болохоос биш өндөр чанартай ноолуурын хэмжээ буурсан гэсэн үг биш. Тиймээс Монгол Улс дээд зэрэглэлийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжоо алдаагүй.

Гэвч ноолуурын зах зээл дээр эрэлт хэрэгцээ нь хамгийн хурдан өсч буй хэсэг бол ноос, торго, хөвөн даавуу, магадгүй синтетик материалын хольцтой, дунд болон доогуур чанарын ноолууран бүтээгдэхүүний зах зээл юм. Ийм бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь түүхий ноолуурын эх үүсвэртэй оронд голчлон төвлөрнө. Учир нь тээвэрлэлтийн зардал хэмнэх, хямд ажиллах хүчнийг ашиглахад оршиж байгаа юм. Ийм бүтээгдэхүүн гол төлөв Вол Март, Карре зэрэг үнэ хямдтай, коллекц, стилийн

¹¹ Арилжааны зээлийн хүү нь дунджаар жилд 6 хувь бөгөөд сард 0.01%-0.1%-ийн хүүтэй хөнгөлөлттэй зээлийг одоо ч олгосоор байна.

хувьд эргэлт хурдантай дунд зэргийн жижиглэнгийн худалдааны дэлгүүрүүдэд худалдаалагдах болно. Зах зээл дээрх одоогийн эрс тэс ялгааг илэрхийлэхийн тулд нэг жишээ дурдахад 2005 онд Вол Мартад цэвэр ноолууран цамц 39,99 доллараар зарагдаж байгаа бол нэг гудамжинд ойрхон байрлах Тавдугаар Авенью Сакс дэлгүүрт Ральф Лорений цамц 900 доллараар зарагддаг. Жижиглэнгийн худалдааны чиг хандлагаас үзэхэд 39,99-ийн үнэтэй Вол Мартын цамц илүү ирээдүйтэй гэдэг нь харагдаж байна. Гэхдээ дизайнеры цамц ч бас хийгдсээр л байх болно.

2005 оны 4 дүгээр сард Хятадын Олон улсын ноолуурын чуулга уулзалт дээр Хятадын хэд хэдэн албаны хүмүүс, үйлдвэрлэгчдийн төлөөлөгчдийн хэлсэн үгнээс үзэхэд Хятад улс ноолуурын салбар дахь өөрийн стратегийг тодорхойлохдоо түүхий ноолуурын нийлүүлэлт, үнийг дэлхий даяар хянах, ноолууран бэлэн бүтээгдэхүүнийг гэрээгээр үйлдвэрлэх, олон улсын брэнд эзэмшигчидтэй хамтран ажиллах эсвэл брэнд нэрийг өөрсдөө бий болгох эсвэл худалдан авах замаар ноолуурын “дэлхийн үйлдвэр” болох зорилт тавьсан байна.¹²

Эдгээр өөрчлөлтүүд Монголын ноолуурын салбарт томоохон нөлөө үзүүлнэ:

- Брэнд эзэмшигчид болон гадны хөрөнгө оруулагчдад өөрийн гэсэн мал аж ахуйтай (өмнө гарсан зарим тайланд энэ талаар дурдсан байсан) болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаадын шууд хөрөнгө оруулалтын хууль тогтоомжид өөрчлөлт хийх шаардлагагүй
- Дээрхийн адилаар, монголын ноолуурын үйлдвэрлэгчид нэмэгдсэн өртгийн илүү өндөр үс шатанд хүрэхийн тулд шинэ брэнд бий болгох, гадаадад жижиглэнгийн худалдааны дэлгүүр нээх замаар олон улсын түгээлтийн сүлжээнд бие даан нэвтрэн орохыг оролдох аливаа үйл ажиллагаа төөрөгдөл болж болзошгүй. Өмнө гарсан зарим нэг тайлангийн дүгнэлтүүдтэй зөрчилдөх санаа хэлэхэд: Хятадын ноолуурын салбар хэмжээгээрээ том (салбар нь ч том, томоохон компаниуд нь ч хэмжээгээрээ том), илүү урт хугацааны туршлагатай, өнгөрсөн хугацаанд Засгийн газраасаа их хэмжээний татаас авдаг байсан хэдий ч Хятадын ямар ч компани олон улсын хэмжээнд нэр хүндтэй брэнд нэр бий болгох, гадаадад жижиглэнгийн худалдааны сүлжээ бий болгох чиглэлээр түгээлтийн сүлжээнд нэвтрэх чадаагүй. Монгол ингэж түгээлтийн системд нэвтрэхийг оролдохын оронд брэнд эзэмшигчид болон түгээлтийн систем дэх компаниудтай нягт, урт хугацааны хамтын ажиллагаа хөгжүүлэх хэрэгтэй.
- Монгол ноолуурын ширхэгтийн хэмжээ бүдүүрч чанар нь муудаж байгаа ч ноолуурын зах зээл дээр хамгийн дээд зэргийн чанартай ноолуураар хийсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ бус харин боломжийн чанартай цэвэр ноолууран эсвэл хольцтой бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ хамгийн их өсөх тул аз дайрсан гэж хэлж болно.
- Саяхан Хятадад болсон ноолуурын чуулган дээр Хятадын Засгийн газар, худалдааны нийгэмлэгүүд, ноолуур боловсруулах салбарын хувийн үйлдвэрүүдийн төлөөлөгчдийн хийсэн мэдэгдлүүд нь Монголын ноолуурын үйлдвэрлэгчид болон Монголын Засгийн газарт сэрүүлэг эсвэл түгшүүрийн харанга болох ёстой. Хэрэв тэд шуурхай бөгөөд шийдэмгий хөдлөхгүй бол тус салбарын ирээдүй эргэлзээтэй байдалд орно.

¹² БНХАУ-ын Хүнсний бүтээгдэхүүн, байгалийн гаралтай бүтээгдэхүүн, малын дайвар бүтээгдэхүүний импорт, экспортын худалдааны танхим, Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний импорт, экспортын Худалдааны танхимаас зохион байгуулсан Хятадын ноолуурын чуулга уулзалтын “Чуулганы баримт бичиг”-ээс үзнэ үү. 2005 оны 4 дүгээр сар.

- Хятадын ноолуурын чуулган дэлхийн бусад орны ноолуур үйлдвэрлэгчдийн хувьд ч нойрноосоо сэрэх сэрүүлэг болсон байж болзошгүй. Одоо тэд дэлхийн ноолуурын салбарт ноёрхох гэсэн Хятадын үйлдвэрлэлийн салбараас ирж буй нээлттэй заналхийлэлд хариу арга хэмжээ авахын тулд Монголтой хамтын ажиллагаа, харилцаа холбоогоо хөгжүүлэхийг илүү сонирхож байж болох юм.

Засгийн газрын анхааралд толилуулж буй арга хэмжээнүүд:

- Брэнд эзэмшигчид, гадны үйлдвэрлэгчдийг мал аж ахуйн салбарт татан оруулахын тулд гадаадын хөрөнгө оруулалтын хуулинд өөрчлөлт оруулах хэрэггүй.
- Монголын үйлдвэрлэгчдэд олон улсын түгээлтийн сүлжээнд нэвтрэн орох, өөрийн брэндийг шинээр бий болгоход зориулж Засгийн газар, доноруудын зүгээс тусламж үзүүлэх хэрэггүй.
- Монгол ноолуурын гэрчлэх тэмдгийг сурталчлах цорын ганц нөхцөл нь энэхүү тэмдгийн нэрэн доор экспортод гарч буй бүтээгдэхүүн өндөр чанартай байгааг магадлах чанарын хатуу чанд шалгалт хийгддэг байх явдал юм.
- Ноолуурын салбарт хөрөнгө оруулж болох гадны хөрөнгө оруулагчдыг Монголд татахын тулд бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй, (эдгээр арга хэмжээний талаар дараах хэсгээс дэлгэрэнгүй уншина уу), мөн түүнчлэн Монголыг хөрөнгө оруулалтын талбар хэмээн сурталчлах, хөрөнгө оруулалтыг дэмжих арга хэмжээг авах хэрэгтэй.

ХЭСЭГ III: МАКРО-ЭДИЙН ЗАСАГ БА МОНГОЛЫН НОЛУУРЫН САЛБАР

Ажиллах хүчний өртөг, татварын хэмжээ, хүүгийн хэмжээ, мөнгөний ханш гэх мэт макро-эдийн засгийн хүчин зүйлс Монголын ноолуурын салбарт томоохон нөлөө үзүүлдэг. Монголын ДНБ дэх татварын орлогын эзлэх хувь маш өндөр бөгөөд улам өссөөр байна. (2000 онд 25.6% байсан бол 2004 онд 31.8% болж өссөн).¹³

Хэдийгээр том аж ахуйн нэгжийн татварыг 30% болгон бууруулсан хэдий ч энэ нь харьцангуй өндөр хэвээр байна. Монголын татварын хууль маш олон төрлийн зардлыг татварт ноогдох орлогоос хасдаг. Мөн хурдасгасан элэгдэл хорогдол, тайлангийн алдагдыг ирээдүйд шилжүүлж тооцдоггүй. Ноолуурын салбарт хөрөнгө оруулагчдад олгодог татвараас чөлөөлөх хугацаа нь бүс нутгийн бусад орнууд тухайлбал Хятад зэрэг орнуудынхаас богино хугацаатай.¹⁴ Энэ бүгдийн улмаас татварын бодит хэмжээ өндөр болдог. Гэтэл малчид орлогын албан татвар төлдөггүй. Тэд ямааныхаа тоогоор маш бага хэмжээний малын хөлийн татварыг л төлдөг.¹⁵ Нийгмийн даатгалын татварууд (эрүүл мэндийн, тэтгэвэрийн, тахир дутуугийн, ажилгүйдлийн) ч өндөр байна. (ажилчин, албан хагчаас 10%, ажил олгогчоос 19%). Малчид бас л энэ татварыг төлдөггүй. Компаниас олгодог зүй ёсны тэтгэмжүүд (унааны мөнгө,

үйлдвэр дээрх өдрийн хоол) дээр нийгмийн татваруудыг нэмэхэд Монголын үйлдвэрийн нэг ажилтны цалингийн цэс сард 150 ам. доллартай тэнцэж байна. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ нь 600 ам. доллартай тэнцэх орны хувьд энэхүү цалингийн цэс нь өндөрт тооцогдох бөгөөд Өвөр Монголынхтой харьцуулбал нэлээд өндөр байгаа юм.¹⁶ Монголд ажилгүйдэл, ажлын байрны дутагдал нэлээд өндөр байна. Энэ нь юуг харуулж байна вэ гэвэл ажилгүйдлийг хамгийн доод

ЖИШЭЭ: КАПИТАЛЫН ЗАРДАЛ ӨНДӨР БАЙГААГИЙН НӨЛӨӨ

Монгол Улс жилдээ 3,000 орчим тонн түүхий ноолуур бэлтгэдэг бөгөөд энэ нь 2005 оны үнээр 80 сая ам. долларын үнэтэй. Түүхий ноолуурын ихэнх нь 3 дугаар сараас 6 дугаар сар хүртэлх 3 сарын хугацаанд зах зээлд нийлүүлэгддэг. Хэрэв энэ бүх ноолуурыг бүгдийг нь Монголд боловсруулна гэвэл түүхий ноолуурын нөөцийг үйлдвэрлэлийн нэг жилийн хугацаанд санхүүжүүлнэ гэсэн үг. Ойролцоогоор 40 сая ам. долларын ноолуурыг хадгална гэж үзвэл 37%-ийн хүү нь 15 сая ам. доллар болж байна. Монголд бэлтгэсэн бүх түүхий ноолуурыг боловсруулахад шаардлагатай үйлдвэр, тоног төхөөрөмж нь 100 сая орчим ам. доллар байх бөгөөд 37%-иас илүү капиталын зардалтай. Тиймээс Монголын бэлтгэх бүх түүхий ноолуурыг боловсруулахад гарах капиталын зардал нь жилд 60 сая орчим ам. доллар болж байна. (Жилд 200 тонн түүхий ноолуур боловсруулж, 300 мянган ширхэг сүлжмэл цамц үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг, Монголын бүх түүхий ноолуурыг боловсруулах зорилгоор өргөтгөсөн гэж үзсэний жишээн дээр эдгээр тоог гаргаж ирсэн. Эдгээр зардал болон хөдөлмөрийн өртгийг үйлдвэрлэлийн үе шат бүрээр хавсралтаар үзүүлсэн) Энэ дүнг түүхий ноолуурыг бэлэн хувцас болгоход шаардагдах хөдөлмөрийн зардал буюу 9,6 сая ам. доллартай харьцуулж болох юм. Харьцуулж үзэхэд Хятадын компаниудын зээлийн хүү нь жилд 6 хувь байдаг бөгөөд дээрх хэмжээний ноолуурын нөөцийг санхүүжүүлэх, үйлдвэр, тоног төхөөрөмжийн капиталын зардал нийлээд 10 саяас бага байна. Хятадын үйлдвэрлэгчид дэлхийн зах зээл дээрх ноолуурын үнийг тогтоодог бөгөөд Хятадын зээлийн хүү бага, иймээс капиталын зардал бага учир Монголын үйлдвэрлэгчид энэхүү шахагдсан нэмэгдсэн өртгийг тогтолцоонд ажиллах ёстой болно.

¹³ Тухайн хугацаанд Засгийн газрын нийт орлогын ДНБ-д эзлэх хэмжээ 34.5%-иас 38.1% болж өссөн.

¹⁴ Экспортын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 3 жилийн хугацаанд чөлөөлөгддөг бөгөөд дахин 3 жил 50%-ийн хөнгөлөлт эдэлдэг.

¹⁵ 1 ямаанд жилдээ ноогдох татварын хэмжээ аймгуудын хооронд 50-10 төгрөгийн зөрөөтэй байдаг. (0.04-0.8 ам. доллар), нэг ямааны жилийн татварын 0.25%-0.38% хувьтай тэнцэх зөрүү юм.

¹⁶ Эрүүл мэндийн даатгал, тахир дутуугийн даатгал, тэтгэвэр, ажилгүйдлийн даатгалд ажилчид цалингийнхаа 10 хувийг, ажил олгогч ажилтныхаа цалингийн 19%-тай тэнцэх татварыг төлдөг.

түвшинд хүргэдэг зах зээлийн тэнцвэрт цалингаас одоогийн цалингийн цэс илүү байгааг илэрхийлж байх шиг байна.

Монголд маш олон банк, санхүүгийн байгууллагууд байна. Зээлийн хүүг Засгийн газар эсвэл олигарх санхүүгийн салбар тогтоодог биш харин зах зээлийн хүчин зүйлс тодорхойлдог.¹⁷ Хэдийгээр санхүүгийн системийн үндсэн хөрөнгө маш хурдан өсөн нэмэгдэж байсан боловч бас ихээхэн хэмжээний бэлэн мөнгө байна. Банкны хүү Монголд өндөр байна. Гэхдээ зээлийн хүү болон хадгаламжийн хүүгийн хоорондын зөрүү ч бас өндөр байгаа бөгөөд 25% орчим байна: (жилд 37% (сард 1.2%) ба жилд 15% (2.5%/сард)). Капиталын зардал дараах хоёр шалтгааны улмаас үйлдвэрлэлийн салбарын хувьд амин чухал байдаг. Нэгдүгээрт, капиталын зардал нь тус салбарын үйлдвэрлэлийн гол зардал бөгөөд ноолуурын үйлдвэрлэлийн салбарын гол төлөөлөгч болох Хятадад энэхүү зардал маш доогуур байдаг. Энэхүү өндөр зардлын нөлөөг доорх жишээнээс харж болно.

Капиталын зардал ийм өндөр байгаагаас гадна Монголын банкууд зөвхөн богино хугацааны зээл олгодог учраас үндсэн хөрөнгө санхүүжүүлэх зээл авахад хэцүү байдаг. Түүнчлэн банкууд зээлийн барьцааны талаар хатуу бодлого баримталдаг бөгөөд ихэвчлэн тоног төхөөрөмж хатуу нөхцлөөр барьцаалж зээл олгодог бөгөөд агуулахад байгаа бараа, бараа борлуулах гэрээ болон бэлэн мөнгөний орлогын төсөвт тулгуурлан зээл олгодоггүй.

Хятад, Монголын хооронд байгаа цалин болон капиталын зардлын ялгаа нь төгрөгийн ханшаас болоод улам хол зөрүүтэй болдог. Сүүлийн 5 жилийн хугацаанд төгрөгийн ам. доллартай харьцах бодит ханш 10%-иар өссөн бол юаньтай харьцах бодит ханш 25%-иар өсчээ. Ханшны эдгээр өөрчлөлтүүдийн улмаас Монгол дахь үйлдвэрлэлийн өртөг Хятадынхтай харьцуулбал иймэрхүү хэмжээгээр өссөн.

Тоймлон хэлэхэд макро-эдийн засгийн орчин ноолуурын салбарын хувьд таагүй байснаар зогсохгүй цаашид улам муудах төлөвтэй байна. Экспортын зах зээл дээр өрсөлдөхийг хүсч буй хөгжиж буй орны хувьд хэрэгжүүлж болох хамгийн таагүй стратегийг Монгол улс хэрэгжүүлж байна. Тухайлбал: цалингийн хэмжээ өндөр, зээлийн хүү өндөр, татвар өндөр, гол өрсөлдөгч болон гол зах зээлтэйгээ харьцуулахад мөнгөний бодит ханш нэмэгдэж байгаа гэх мэт.

Засгийн газрын анхааралд толилуулах арга хэмжээ:

- Монголын Засгийн газар өөрийн нийгмийн халамжийн татварын бодлогыг эргэн хянаж, ажиллах хүчний зардлыг тус улсын төсвийн орлогын түвшинд нийцүүлэх үүднээс эдгээр татварыг бууруулах асуудлыг авч үзэж болох юм.
- Үйлдвэрлэлийн салбарынхны төлж буй нийгмийн халамжийн татваруудаар малчид болон тэтгэвэрийнхний нийгмийн халамжийн төлбөрүүдийг санхүүжүүлж байгаа бодлогоо эргэж хармаар байна.
- Зээлэх, зээлдүүлэхийн хоорондын хүүгийн ялгааг багасгах бүх талын арга замыг судлах хэрэгтэй. Ялангуяа, Монгол банкинд олгосон хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан хувийн салбарынханд дахин зээлэхдээ Монгол банкнаас ноогдуулдаг хүүг багасгах, мөн арилжааны банкнуудын дахин зээлэхдээ ноогдуулдаг хүүгийн төлбөрийг бууруулах асуудлыг авч үзэх хэрэгтэй.

¹⁷ Энэ хэсэг нь Кемоникс компаний ажилтан Алин МкМахоны хийсэн судалгаанд үндэслэж байгаа юм. Түүний тайлан энэ тайланд хавсаргалтаар орсон болно.

- KfW гэх мэт зээлдэгчид бага хүүтэй зээл олгохдоо ноолуурын салбарт тэргүүлэх ач холбогдол өгдөг байх явдлыг урамшуулах хэрэгтэй.
- Худалдааны хууль тогтоомжийн тогтолцооны ил тод байдлыг хангах санаачилгуудыг дэмжиж, зээлдүүлэгчдийн эрх ашгийг илүү сайн хамгаалах чиглэлээр илүү боловсронгуй болгох хэрэгтэй.
- Монголын Засгийн газар өөрийн орны мөнгөний бодит ханшийг өөрийн томоохон өрсөлдөгч (Хятад улс) болон голлох зах зээлийн (АНУ) валюттай харьцуулахад тогтвортой байлгах талаар арга хэмжээ авах хэрэгтэй.
- Томоохон аж ахйн нэгжүүдийн татварыг улам бууруулж 15%-25% болгож болох юм. Түүнчлэн татвараас чөлөөлөх хугацааг байхгүй болгож (Гадаадын хөрөнгө оруулалт хэмээх гарчгаас үзнэ үү) харин орлогын тайланд хурдасгасан элэгдэл хорогдлыг тооцож, тайлангийн алдагдлыг ирээдүйд шилжүүлдэг болгож, татвар үл ноогдох зардлын төрөл хэмжээг олон улсын түвшинд хүргэн нэмэгдүүлж, ингэснээр татварын бодит хэмжээг бууруулж болох юм.

ХЭСЭГ IV: МОНГОЛЫН НОЛУУРЫН САЛБАРЫН БҮТЭЦ

А. Мал аж ахуйн салбар¹⁸

Монголын нийт хүн амын гуравны нэг нь ноолуурын ямааг өсгөж үржүүлж орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлдэг. Мал аж ахуйн салбарыг 1990-ээд оны эхээр либеральчилж, мал сүргийг малчдад хувьчилснаас хойш ямаан сүргийн тоо толгой хонь, үхэр, тэмээ зэрэг бусад малтай харьцуулбал маш хурдан өссөн. 1990 онд 5 сая ямаа байсан бол 1998 онд 11 сая болтлоо өссөн. Туршлагатай малчид сүргийн тоогоо нэмэгдүүлсэн. Түүнчлэн аймаг, сумын төвүүдийн ойр суурьшсан хүмүүс шинээр малчдын эгнээнд нэгдэн орж, буурч байгаа өрхийн орлогоо нэмэгдүүлэх нэгэн эх үүсвэр болгож ямаа маллах болсон. Гэхдээ 2000-2002 оны зуднаар ямааны нийт төлийн 25 орчим хувь нь онд орж чадаагүй тул ямаан сүргийн тоо толгой нэлээд буурсан. Гэхдээ 2004 он гэхэд ямааны сүргийн тоо дахин өсч, зудын өмнөх үеийнхээсээ даван гарч, 12 гаруй саяд хүрсэн. (1 дүгээр зураг).

Малчид сайн үүлдрийн ухнаас бусад эр ямаагаа залууд нь заазалж, эм ямаагаа нас нь өтлөхөөр нь заазалдаг байсан бол ямааныхаа тоог нэмэгдүүлж ноолуурыг нь авахын тулд эр, эм ямаагаа хөгширтөл нь байлгадаг болсон. Эр ямаа, хөгшин ямааны тоо ийнхүү нэмэгдсэнийн бас нэг шалтгаан нь заазалсан ямааны мах, арьсыг ашигтайгаар борлуулах боломж хязгаарлагдмал байгаатай холбоотой.¹⁹ Сүүлийн хэдэн жилийн зуднаар ишиг их хорогдсон нь сүргийн дундаж наслалтад нөлөөлсөн. Эр ямааны ноолуур эм ямааныхыг бодвол илүү бүдүүн байдгаас гадна залуу ямааны ноолуур хөгшин ямааныхтай харьцуулбал илүү нарийн байдаг учраас ямааны тоо толгой өсч, ямаан сүргийн хүйс, насны бүтцэд өөрчлөлтүүд гарсан нь Монголын түүхий ноолуурын *äóíääæ* чанар муудсаны гол шалтгаан болсон юм.

Энд анхаарвал зохих нэг чухал зүйл нь *íîîëóóðûí äóíääæ ÷áíàð ì óóäñàí ÷ ýíý íü °íá°ð ÷áíàððàé íîîëóóðûí ðýì æýý áóóðñíí àáñ áíëñíí ðýäýá àèø ðàðèé ÷áíàð àðàé äííáóóð áíëíá÷ áíëíì æèéí íîîëóóðûí áýèðäýé °ì í°ð°ñ°° èðýññýí ðýé ðíëáíí ðìé þì*.

Дээд зэрэглэлийн ноолууран бүтээгдэхүүний жижиг бөгөөд улам бүр хумигдаж буй зах зээлийн сегментийг бүрэн хангахад хүрэлцэхүйц хэмжээний өндөр чанартай ноолуурыг Монгол Улс гаргаж чадаж байгаа. Түүнчлэн, Монголын үйлдвэрлэгчдийн зүгээс өндөр чанарын (13.5 - 15.5 микрон) ноолуур болон арай доогуур чанарын (15.5 - 17.5 микрон) ноолуурт санал болгож байгаа үнийн зөрүү одоогоор (ирээдүйд ч энэ хэвээр байх бололтой) ердөө 15% хувь байна. (3 дугаар зураг). Мөн төдий хэмжээний үнийн зөрүү Монголын ноолуур болон Хятадын самнасан ноолуурын хооронд байдаг. Монголын үйлдвэрлэгчдийн (түүнчлэн

¹⁸ Энэхүү хэсэг голчлон Дэлхийн банкны "From Goats to Coats : Institutional reform in Mongolia's cashmere sector" тайлан, 2003 он, Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн "Монгол улс дахь нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй", 2004 он, Монголын Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн "Монголын ноолуурын чанарыг сайжруулах хөтөлбөр", 1999 он, Жеймс Хамильтоны "Өмнөговь Малчин үйлдвэрлэгчдийн холбооны "ТББ-д тулгуурласан ноолуурын худалдааны өдөрлөгүүд", 2003 он, Эвентийн үнэлгээ, Говийн санаачилга, 2003, Вернон Ронинген, "Монголын түүхий ноолуурын экспортод тавьсан хоригийн үр нөлөө", Говийн Санаачилга, А.Бакей, Т.Сайполда, "Ноолуурын зах зээл: түүхий ноолуурыг боловсруулахад тавигдах шаардлага," Говийн санаачилга, 2003 он зэрэг хоёрдогч эх сурвалж болон малчидтай хийсэн уулзалт, Монголын Засгийн газрын албаны хүмүүс, Говь-2, ГТХАН, Дэлхийн банк зэрэг байгууллагын ажилтнуудтай хийсэн ярилцлагын мэдээлэлд тулгуурласан болно..

¹⁹ Зөвлөлтийн үед Монгол Улс Зөвлөлтийн армид ямааны мах худалддаг байсан. Одоо тэрхүү худалдааны суваг байхгүй.

дэлхийн зах зээлийн) санал болгож буй үнийн энэхүү зөрүү нь ноолуурын голчийг 2 микроноор бууруулахад нэг ямаанаас гарах ноолуурын жингийн алдагдлыг (20-25%) нөхөхөд хангалттай биш байна. (3 дугаар зураг).

Ямаан сүргийн чанарыг сайжруулахдаа малчдад орох орлогыг нэмэгдүүлэхийн тулд ноолуурын ширхэгтийн голчийг 2 микроноор багасгахад нэг ямаанаас гарах ноолуурын гарц 20-25%-иар буурахтай холбогдон гарах алдагдлыг нөхөн төлөх хэмжээнд дор хаяж хүргэх үүднээс ноолуурын үнийг нэмэх хэрэгтэй болно. (4 дүгээр зураг). Энэхүү чухал санааг сайн ойлгуулахын тулд дахин давтан хэлэхэд ноолуурын чанарыг сайжруулах, голчийг нарийсгах санаачилга нь нарийн ноолуурт өгөх үнийн нэмэгдэл 20-25 хувиас дээш байж чадахгүй тохиолдолд ямааны эдийн засгийн үнэлгээг бууруулж, малчдын орлогыг *ááãäñãäí à*.


Энэхүү тайлангийн зөвлөмжийн эсрэгээр ноолуурын чанарыг түүний голчийг багасгах замаар сайжруулах гэсэн санаачилга, арга хэмжээнүүд буруу чиглэлд явж байгаа (эсвэл явж байсан) гэж хэлж болно. Түүнээс гадна бусад тайлангууд Монголын ноолуурын чанар муудахад аяндаа Монголын болон Хятадын ноолуурын хоорондын үнийн зөрүү ихэснэ гэж дүгнэж байсан ч ийм зүйл болоогүй. Бас Монголын ноолуурын үнэ Иран, Афганистаны ноолуурын түвшинд очтол буурсан явдал байхгүй. (4 дүгээр зургийг үзнэ үү).

Өнгөрсөн хугацаанд зарим тайлангууд үйлдвэрлэлийн салбарынхныг ноолуурын чанарыг үл харгалзан нэгэн ижил үнэ санал болгож, малчдын бүх ноолуурыг чанарыг нь үл харгалзан худалдан авч байна гэж нэлээн ширүүн шүүмжилж байсан. Тухайн тайлангууд үүнийг тайлбарлахдаа үйлдвэрлэгчид ноолуурын чанараас хамаарсан үний өсөлт, ялгааг малчдаас нууж, эцсийн дүндээ өөрсөлдөө ашигтай дундаж үнээр ноолуураа авах гэсэн сонирхолтой байгаагаас ингэж байна гэж үзэж байсан. Харин одоо бол үйлдвэрлэгчид ноолуурын чанар, гарц, өнгөнөөс хамаарсан үнийг зөрүүг төлөх сонирхолтой байгаа бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дээрх үнийн зөрүүтэй холбоотой юм. (3 дугаар зураг). Харин тэд одоо өөрсдийнх нь төлж чадахааргүй, ашиг олохооргүй өндөр үнээр бүх ноолуурыг авч байна хэмээн Хятадын ченжүүдийг буруутгаж байна. Хятадын худалдаачдын энэ байдлын талаар боловсруулах үйлдвэрийн салбарын талаарх дараагийн хэсэгт дүн шинжилгээ хийсэн.

Удиртгал хэсэгт дурдсанчлан, Засгийн газар мал аж ахуйн салбарт олон төрлийн татаасыг олгож байна. Малчид орлогын татвар төлдөггүй, сүрэг дэх ямааныхаа тоо толгойгоор багахан хэмжээний татвар төлдөг.²⁰ Тэд хүүхдүүдээ аймаг, сумын төвийн сургуулийн дотуур байранд суулгахдаа, байр хоолны мөнгө төлдөггүй, нийгмийн даатгалын эсвэл эрүүл мэндийн даатгалын хураамж төлдөггүй, орон нутгийн засаг захиргаанаас барьж, засвар үйлчилгээг нь хариуцдаг худгаас усаа үнэгүй авдаг, малын тэжээлийг хөнгөлөлттэй үнээр авдаг. Малын тэжээлийг хямдралтай үнээр олгож байгаа нь малын тэжээлийн нөөцөд ноцтой нөлөөлж малын тэжээлийн бэлтгэл эрс багассан. (7 дугаар зураг). Түүний зэрэгцээ, орон нутгийн төсөв худаг байгуулах, засвар үйлчилгээг нь хангах ажилд шаардагдах их хэмжээний хөрөнгийг санхүүжүүлэхэд хүндрэлтэй байгаа учир худгийн тоо үлэмж буурсан. (6 дугаар зураг). Зарим нэг туршилтын төслийн үр дүнгээс үзэхэд малчид усан хангамжаа баталгаатай болгохын тулд усны мөнгө төлөхөд бэлэн байгаа нь харагдсан.

²⁰ Энэ татвар нь аймгуудаар ялгаатай байдаг бөгөөд ямааны үнийн 0,25-0,38 хувьтай тэнцдэг.

1-р зураг: Монголын ноолуурын ямааны тоо 1990-2004



Эх сурвалж: Үндэсний статистикийн газар

2-р зураг: Ямааны ноолуурын гарц ба голч нас хүйсээр

Цэвэр монгол үүлдрийн ямааны нас, хүйс	Нэг ямаанаас гарах ноолуурын гарц, граммаар	Ноолуурын голч микроноор	Ноолуурын урт см-ээр
Эр ямаа	281	16.05	35.4
Эр борлон	210	14.26	39.8
Эм ямаа	246	14.05	39.8
Эм борлон	201	13.69	45.6


Эх сурвалж: Мал аж ахуйн хүрээлэнгийн захирал Др. Ё.Загдсүрэн

3-р зураг: Ноолуурын голч, өнгөнөөс хамааран ноолуурт санал болгож буй үнэ (төгрөгөөр) (2005)

Голч	Дээд зэрэг 13.0-15.5 микрон	I зэрэг 15.51-16.8 микрон	II зэрэг 16.81-17.6 микрон	III зэрэг 17.61-19.0 микрон
Өнгө				
Цагаан	40,000	37,000	34,000	26,000
Цайвар цагаан	40,000	37,000	34,000	26,000
Цайвар	39,000	37,000	33,000	25,000
Бор	39,000	36,000	33,000	25,000

Эх сурвалж: Төслийн судалгаа

4-р зураг: Хятад, Монгол (Х-М) самнасан ноолуур болон Монгол, Иран (М-И) самнасан ноолуурын үнийн индексийн зөрүү



Эх сурвалж: G.Schneider.com дэх тоо баримтаас авав

Хүснэгт 6: Худаг усны хангамж, 1990-2000
(мянган нэгжээр)

	1990	1995	2000
Нийт	41.6	34.6	30.9
Инженерийн байгууламжтай	24.6	14.6	8.2
Энгийн цооног худаг	17	20	22.7
Бэлчээрт байрлаж байгаа	38.3	26.3	21.7
Ашиглагдаагүй	1.1	6.2	5.8
Усны нөөцлүүр, цистерн	4.1	1.9	1.0
Багтаамж 000 (куб метр)	39.4	27.7	14.9

Эх сурвалж: Дэлхийн банкны судалгаа, “Goats to Coats”, 2003.

Хүснэгт 7: Тэжээлийн үйлдвэрлэл болон түүний нийлүүлэлт, 1990-2002

	1990	'91	'92	'93	'94	'95	'96	'97	'98	'99	'00	'01	'02
Тэжээл тарьдаг талбай (000 гектар)	118	80	53	26	11	6	4	5	5	2	1	2	3
Ургац хураалт (000 тонн)	527	21 3	13 8	11 2	29	19	19	14	15	5	4	3	4
Хадлан бэлтгэл (000 тонн)	866	88 6	66 9	69 8	67 2	74 4	65 5	68 8	66 7	71 5	68 9	83 1	76 7

Эх сурвалж: Дэлхийн банкны судалгаа, “Goats to Coats”, 2003.

Мал аж ахуйд тулгарч байгаа бас нэг асуудал бол цөлжилт юм. Монголын нийт мал сүргийн бэлчээрийн даац хязгаартай. 90-д оны дундаас сүүл хүртэлх хугацаанд нийт малын тоог хонин толгойд шилжүүлэхэд бэлчээрийн даац хэтэрсэн байсан.

2000, 2001 оны зуднаар энэ тоо бэлчээрийн даацнаас багахан хэмжээгээр доошилсон тооцоо гарсан байна. 2004 он гэхэд малын тоо өсөж, эргээд бэлчээрийн даацнаас үлэмж хэмжээгээр хэтэрсэн байна. Бэлчээрийн даац хэтэрсний үр дагавар нь ноцтой асуудал болж болзошгүй. Монголд хийгдсэн нэгэн судалгааны тооцоогоор малын нядалгааны түвшин доогуур байгаа тохиолдолд (одоогийн байдлаар доогуур байгаа) малын тоо 12 саяд хүрвэл (энэ жилийн малын тоо энэ тоонд хэдийнэ хүрчихсэн байгаа) ган болж, бороо хур огт орохгүй тохиолдолд хадлан тэжээл хураах боломж үгүй болж Монгол тэр чигээрээ цөл болох аюултай гэсэн дүгнэлт гарсан байна.²¹ Хятад улсын хувьд ч адилхан аюул учирч байгаа. 1960-аад оноос эхлэн Өвөр Монголд өвсний гарц гуравны нэгээр багасч гуравны хоёр болсон байхад малын тоо өссөн байна.²²

Байдал ийм ноцтой байхад Засгийн газар энэ салбарт өндөр татаас өгч байдаг нь хачирхалтай юм. Засгийн газар эдийн засгийн албан салбарт татвар, нийгмийн даатгалын дарамтыг өндөр хэмжээгээр ноогдуулсан нь энэ салбарт ажилгүйдэл болон ажлын байрны хомсдол бий болоход хүргэжээ. Засгийн газар ямаа үржүүлж, орлогоо нэмэгдүүлэх чиг хандлагыг дэмжиж тусалснаар өөрийн бусад бодлогоос үүдэлтэй ажилгүйдлийг багасгах бодолтой ажиллаж байна. Гэвч мал аж ахуйн салбарт /ямааны тоог өсгөхөд/ татаас үргэлжлүүлэн өгсөөр байвал Монголын бэлчээрийг тэр чигээр нь цөл болгох магадлал их өндөр байна.

Засгийн газарт санал болгож буй арга хэмжээнүүд:

- Малчдад үзүүлж буй элдэв татаас, хөнгөлөлтийг арилгаж, малчид нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын хураамж, хүүхдүүдийнхээ аймаг, сумдын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, хоолны мөнгө төлж, худаг ашигласны хураамж болон орлогын татвараа төлдөг болгох. Орлогын татварыг одоо хэрэгжиж байгаа малын хөлийн татвар өсгөснөөр авч болох юм. Энэ татварын өсөлтийг нөгөө талаас мал аж ахуйн сөрөг үр дагавар болох цөлжилтийг багасгахад ашиглаж болно.
- Тухайн малчны малын тоо толгойноос хамаарч худаг ашиглалтын хөлсийг тогтоох
- Малыг тэжээл, хадлангийн үнийг чөлөөт зах зээлийн ханшаар тогтоож, татаас өгөхөө болих
- Түүхий ноолуурын зах зээлийн тогтолцоонд засгийн газар ямар нэгэн байдлаар нэвтрэн орж, үнэ тогтоож түүхий эд худалдан авах, өөрийн тогтоосон үнээр үйлдвэрлэгч нарт борлуулах үйлдлийг хийхгүй байх
- Малчдад үнийн мэдээлэл өгдөг “Market watch” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, болж өгвөл ноолуурын үнийг өнгө, зэрэглэлээр нь ялган мэдээлэх ажлыг шинээр нэвтрүүлэх

Б. Үйлдвэрлэлийн салбар

1997 онд түүхий ноолуурын экспортын хориг цуцлагдаж мөн үүний зэрэгцээ дэлхийн зах зээл дээр ноолуурын үнэ унаснаас хойш 8 жилийн туршид Монголын ноолуур боловсруулах салбар уналтанд орж байна. Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний квотын систем үгүй болсонтой холбогдуулан зарим үйлдвэрлэгч

²¹ “Монголын ноолуурын үйлдвэрлэлийн цааашдын хөгжил болон ямаан сүргийн тоо толгой” Д. Бадарч, Б. Очирбат, ШУТИС, 2002

²² Хятадын хойд хэсэгт бэлчээрийн даац дунджаар 36,1%-иар хэтэрсэн байгаа тооцоо гарсан байна.

үйл ажиллагаагаа зогсоож эсвэл үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг багасгаж байж магадгүй юм. Хэдийгээр энэ бууралт явагдаж байгаа ч үйлдвэрлэлийн шат дамжлага болгон дээр ашиглагдаагүй хүчин чадал их хэмжээгээр байна: угаах – 2004 онд хүчин чадлынхаа 40 хувийг ашигласан байна, самнах – 52%, ээрэх – 42%, сүлжих – 77%, болон нэхэх – 52%.²³ Хүчин чадлын ашиглалт ийм доогуур байхад түүхийн ноолуурын 50%-д ямар ч боловсруулалт хийгдээгүйгээр Хятад руу гардаг нь бүр хачирхалтай юм.

Говь ХК нь тус салбарт үйлдвэрлэлийн бүх шат дамжлага явуулдаг гурван компанийн хамгийн том нь бөгөөд төрийн өмчийн оролцоотой ба энэ салбарт ноёрхлоо тогтоосон билээ. Засгийн газар Говийг 2000 оноос хойш хувьчлахыг оролдсон билээ. 2005 онд тус компанийг хувьчлах тухай яригдсан боловч тодорхойгүй хугацаагаар дахин хойшлуулсан. Энэ хооронд Говь сүүлийн 4 жилийн турш жил бүр 2 сая доллар алдсаар ирсэн, тохирсон засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийгээгүйгээс болж үйлдвэрийн тоног төхөөрөмж нь муудсан байна.²⁴ Тус компанийн хөдөлмөрийн болон машин техникийн бүтээмж, гарц, бүтээгдэхүүний чанар буурсан байна. Бусад үйлдвэрлэгч нартай харьцуулахад самнасан ноолуурын гарц доогуур, ээрэхийн гарц дэлхийн жишиг болох 95% -аас доогуур байна.

Говь компанийн шинэ удирдлага үйл ажиллагаагаа сайжруулах зорилготой 5 жилийн бизнес төлөвлөгөө хийсэн билээ. Гэвч энэхүү төлөвлөгөө компанид учирч байгаа бэрхшээлүүдийг бодитой ажил хэрэгч байдлаар авч үзээгүй байна. Говь компанийн энэхүү байдал нь шийдэгдэхгүйгээр үлдвэл түүний үйл ажиллагаа болон ирээдүй нь тус салбарыг бүхэлд нь тодорхой бус байдал оруулж, ноолуурын үйлдвэрлэлд шинээр орох хүсэлтэй компаниудын сонирхлыг бууруулж магадгүй. Жишээлбэл, 2002 онд Говь үйлдвэр 7,55 тонн, 2003 онд 29,3, 2004 онд 116,1 тонн ээрмэл үйлдвэрлэсэн байна. Гэвч нэг ээлжийн үйлдвэрлэх хүчин чадал нь 75 тонн, хэрвээ тоног төхөөрөмжөө засч янзлаад ажилчдаа сайн сургаад гурван ээлжээр ажиллавал, ээрэхийн мэргэжилтний тооцоолсноор 280-300 тонн утас жилдээ үйлдвэрлэх бололцоотой байна. Үүний тулд 700 тонн түүхий эд хэрэгтэй бөгөөд энэ нь нийт түүхий эдийн бараг дөрөвний нэг ба тус салбарын сүлжих, нэхэх хэрэгцээний 80% хангах бололцоотой юм.²⁵

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРТ ГАДААДЫН ӨМЧЛӨЛИЙН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Эдгээр өмчлөлийн хэлбэр ямар асуудал үүсгэж магадгүйг хоёр жишээн дээр үзүүлбэ. Самнах үйл ажиллагаа явуулдаг хамтарсан нэгэн үйлдвэрийн менежер гадаадын хамтрагч талаа ээрэх үйлдвэрлэл рүү орох сонирхолтой байгааг хэлсэн билээ. Ээрэх үйлдвэрлэл явуулдаг Монголын компаниудаар утсаа хийлгэж болохгүй юм уу гэсэн асуултанд "Энэ асуудал манай хамтрагч талын самнасан ноолуурын хэрэгцээнээс хамаарна" гэж болгоомжлон хариулсан юм. Өөр нэг гадны хөрөнгө оруулалттай компани квотын систем үгүй болсонтой холбогдуулан өөрийн сүлжих үйл ажиллагаагаа зогсоосон байна. Урд нь энэ компани Монголд угаасан самнасан ноолуураа өөрийн эцэг компани болох компанид гадагш нийлүүлж ээрмэл хийн буцаан оруулж ирээд сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байжээ. Монголд шинээр бий болох чанар сайтай ээрмэл гаргадаг, үйлдвэрлэлийн зардлыг харьцангуй доогуур санал болгодог үйлдвэрээр өөрийн сүлжих хэрэгцээндээ зориулан утас хийлгээд сүлжих үйл ажиллагаагаа сэргээхгүй юү гэхэд " Энэ асуудал манай эцэг компанийн хүчин чадлаас хамаарна" гэж хариулав.

²³ Эдгээр тоонуудыг үйлдвэрлэгчдийн өгсөн хүчин чадал ашиглалтын мэдээллээс дунджаар тооцогдож гарсан. Хэрвээ үйлдвэрлэлийн хэмжээг хүчин чадалт нь хуваавал өөр тоо гарна. Учир нь үйлдвэрлэлийнхээ хэмжээг багасган тайлагнаж байж магадгүй.

²⁴ Гарц гэдэг нь орж гарч байгаа хэмжээний харьцаа бөгөөд самнахын гарц 50% дээш байдаг нь жишиг бөгөөд зарим компаниуд 55%-тай байхад Говь компанийх доогуур байна. Говийн самнахаас гарсан хаягдлыг Хятадын компаниуд дахин боловсруулж ноолуур гарган авч байна.

²⁵ Энэ чухал асуудалд дүн шинжилгээ өгсөн Ф.Эдлестоны ЭЗБШӨЧ төсөлд зориулан хийсэн "Ноолуурын салбарын ээрэх хүчин чадлын тухай судалгаа"-г үзнэ үү.

Тус салбарын хоёр дахь том үйлдвэрлэгч болох Буян компани сүүлийн хэдэн жил санхүүгийн бэхршээлтэй тулгарч 2004 онд түүхий эд бараг авч чадахгүй байдалд хүрсэн байна. 2004 онд тус компанийн угаах болон самнах хүчин чадал нь 1%, ээрэх хүчин чадал 10% ашиглагдсан атал тус компанийн ээрэх, сүлжих тоног төхөөрөмж нь дээд зэрэглэлийнх бөгөөд энэ салбарын гол хүчин чадал болох бүрэн бололцоотой.

Үйлдвэрлэлийн бүх шат дамжлага явуулдаг гурав дахь компани нь Санширо Говь, Буян хоёртой харьцуулахад жижиг бөгөөд тус компанийн захирал, эзний техникийн мэдлэг өндөр, шинэ бүтээгдэхүүн зохион бүтээхдээ гаргуун сайн. Иймээс бүтээгдэхүүнийх нь өртөг харьцангуй бага боловч чанар өндөр байна. Гэвч сүүлийн гурван жил агуулахад байгаа бэлэн бүтээгдэхүүний тоо нь өсч, Монголд байгаа зээлийн өндөр хүүнээс болж санхүүжилтийн зардал энэ компанийг дампууралд хүргэж болзошгүй.

Тус салбарыг тодорхойлох үзүүлэлтүүд болон ирээдүйд нөлөөлөх бас нэг хүчин зүйл бол гадаадын хөрөнгө өмч юм. 90-ээд оны дундуур тус салбарт маш олон хамтарсан компани бий болсон. Эдгээр компаниудын зорилго нь Монголын газар нутгаас халин гарч байна. Учир нь Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг эх орондоо байгаа өөрийн үйлдвэрдээ түүхий эд болгон нийлүүлж цаашид боловсруулах, урт хугацааны түншлэгч нартаа өөрийн борлуулалтын сувгаараа дамжуулан Монголд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ нийлүүлэх, мөн квотын хөнгөлөлтийг ашиглаж өөрийн эх оронд нь ногдсон квотоос ил хэмжээний бүтээгдэхүүн зарж байсан. Эдгээр компаниудын хувьд хүчин чадлын ашиглалт, борлуулалт, хөрөнгө оруулалтын хэмжээг гадаадын хөрөнгө оруулагчийн хэрэгцээ болон шийдвэрийн дагуу тогтоосон бөгөөд тухайн зах зээлийн эдийн засгийн хэрэгцээтэй уялдуулаагүй болно.

Монголын засгийн газарт санал болгож буй арга хэмжээнүүд:

- Говь компанийн байдлыг аль болох хурдан хугацаанд бүхлээр нь эсвэл хэсэгчилэн хувьчилснаар тодорхой болгох. Тэр хүртэл салбарын ихэнхи оролцогч нар хүлээнэсэн байдалд орж шинээр ямар нэгэн төлөвлөгөө хэрэгжүүлэхээс түдгэлзэнэ.
- Эргэлтийн хөрөнгө бага хүүтэй зээлээр бүрдүүлэх бололцоотой гадаадын худалдан авагч/компаниудыг Буян компанитай Бизнесийн Хамтын Ажиллагааны гэрээг байгуулахад нь дэмжиж туслах.
- Донор байгууллагууд тус салбарын компаниудад үйлдвэрлэл, чанарын хяналт, дизайн болон маркетингийн чиглэлээр урт хугацааны техникийн туслалцааг үзүүлэхийг засгийн газар дэмжих. Эдгээр компаниудын ихэнх нь бүтээмж, өртөг, гарц, чанар, маркетинг, үнийн асуудлуудаа шийдвэрлэж сайжруулахгүй бол цаашид оршин тогтнох нь эргэлзээтэй.
- Хэрвээ засгийн газар түүхий ноолуурын экспортын татварыг цаашид байлгах шийдвэр гаргавал, самнасан ноолуур болон бөмбөгөн ноолууран дээр бага хэмжээний экспортын татвар тавих талаар мөн бодолцох хэрэгтэй болов уу.

ХЭСЭГ V: МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НЭМЭГДСЭН ӨРТӨГ

Монголын ноолуурын салбарын нэмэгдсэн өртөг таван гол үе шаттай, үүнд: түүхий/боловсруулаагүй ноолуур, угаах ба самнах, будах ба ээрэх, сүлжих ба нэхэх орно. Монголын ноолуурын үйлдвэрлэл, экспорт, импортын дүнг 2004 оны байдлаар шат болгоноор харуулсан Хүснэгт 9-с үзнэ үү.

Хүснэгт 8: Үйлдвэрлэл, хүчин чадал, түүний ашиглалт

	Ноолуурын үйлдвэрлэл	Хүчин чадал	Хүчин чадлын ашиглалт ²⁶
Угаах	1,298 тонн	9,417 тонн	40%
Самнах	806 тонн	1,910 тонн	52%
Будах/Ээрэх	147 тонн	363 тонн	42%
Сүлжих	866,000 ширхэг	3,479,000 ширхэг	77%
Нэхэх	79,000 метр	163,000 метр	52%

Эх үүсвэр: Нэхмэлийн хүрээлэнгийн тус төсөлд хийж өгсөн судалгаа

Хүснэгт 9: Үйлдвэрлэл, экспорт, импорт - үйлдвэрлэлийн шат болгоноор, 2002-2004 /бүх үзүүлэлтүүд тонноор хэмжигдэнэ/

Үйлдвэрлэлийн шат	Үйлдвэрлэл	Экспорт	Импорт	Үйлдвэрлэлийн дараагийн шатны орц
Түүхий ноолуур	3,200	1,600	0	1,600
Угаах/самнах	800	616	0	184
Будах/ээрэх	147	6	180	341
Сүлжих	312	303 ²⁷	0	0
Нэхэх	30	21	0	0

Эх үүсвэр: Нэхмэлийн хүрээлэнгийн тус төсөлд хийж өгсөн судалгаа

Үйлдвэрлэлийн шат дамжлага бүрийн нэмэгдсэн өртгийн 2005 оны тооцоог Хүснэгт 10-т харуулсан болно. Эдгээр хүснэгтэд тавигдсан тооноос харахад, ноолуурын ихэнх хэсэг хамгийн бага нэмэгдсэн өртөгтэй буюу түүхий ноолуур хэвээрээ экспортлогдож байна. Үүний дараа мөн бага нэмэгдсэн өртөгтэй самнасан ноолуурын экспорт удаалж байна. Сүлжмэлийн болон нэхмэлийн ээрмэлээс гадна сүүлийн жилүүдэд экспортод зориулагдсан ээрмэлийн тоо хэмжээ өссөн байна. Экспортонд гарсан самнасан ноолуурын зарим хэсэг нь Хятад улсад боловсруулагдаж ээрмэл болон импортлогдож дотоодын сүлжих, нэхэх үйл ажиллагаанд хэрэглэгдэж байна.²⁸

²⁶ Эдгээр тоонууд хоёр шалтгаанаар хоороондоо уялдаа холбоо муутай байгаа: хүчин чадлын зарим хэсгийг ноолуураас бусад ширхэгт /хонь, тэмээний ноос/ боловсруулахад ашиглаж байгаа, мөн бусад компаниудад самнах юм уу ээрэх ажил хийж өгөхдөө түүнийгээ тайлагнадаггүй байж магадгүй

²⁷ Монгол Улс 2004 онд 500 тонн сүлжмэл цамц экспортлосон байна. Үүний ихэнх хэсгийг 2003 онд үйлдвэрлээд тухайн оны үйлдвэрлэлийн хэмжээнд тусгаагүй байна. Мөн квотын систем дуусгавар болохтой холбогдуулан компаниуд 2004 онд ачилтаа нэмэгдүүлсэн байна. Үүнээс гадна үйлдвэрлэлийн хэмжээгээ тайлагнахдаа бусдад хийж өгсөн угаах, самнах, сүлжих ажлаа оруулаагүй мөртлөө экспортны хэмжээгээ тэр хэмжээгээр нь тайлагнасан байна.

²⁸ Монголын самнасан ноолуурыг Хятад уруу гарган тэнд утас болгож байх хэрэгцээг хангах үүднээс Монголд ээрэх үйлдвэр байгуулахад хэр хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа тухай тус төслийн хийсэн өөр нэгэн судалгаанаас үзнэ үү.

Хүснэгт 10: Монголын ноолуурын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг, 2005 он²⁹

Үйлдвэрлэлийн үе шат	Гарах үнэ	Нэмэгдсэн өртөг
Түүхий ноолуур	\$24-\$30/кг	\$24-\$30
Угаах/самнах /гарц 50 хувьтай/	\$58-\$74	\$7-\$10/кг
Будах/ээрэх (гарц 95%)	\$66-\$90/кг	\$8-\$16/кг
Сүлжих	\$80-\$150/кг	\$12-\$40/кг
Нэхэх	\$80-\$95/кг	\$8-\$20/кг

Эх үүсвэр: Нэхмэлийн хүрээлэн болон төслийн ажилтнуудын хийсэн судалгаа

2004 онд ноолуурын цэвэр экспорт 57 сая ам. доллар болсон байна (нийт экспортын дүн болох 80 сая доллараас 23 сая долларын ээрмэлийн импортыг хасахад). Хууль бусаар гадагш гарсан бохир ноолуурын дүнг нэмбэл, цэвэр экспортын дүн 97 сая ам. доллар болох байсан. Хэрэвээ үйлдвэрлэлийн шат дамжлаганд орсон нийт ноолуурыг сайн чанарын сүлжмэл эдлэл болгон боловсруулж экспортлосон бол цэвэр экспортын хэмжээ 57 саяаас 103 сая ам. долларт хүрэх байсан. Хэрэв Монголын түүхий ноолуурыг хууль бусаар гаргахгүйгээр дотооддоо бүгдийг нь гүнзгий боловсруулалтанд оруулан сайн чанарын сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргавал экспортын хэмжээ ойролцоогоор 206 сая ам. доллар болох байсан. Энэ салбарын ажиллагсдын тоо одоогийн 2500–аас 7000 болтлоо өсөх байсан. Тус салбарт байгаа хүчин чадал нь ээрэхээс бусад үйлдвэр болон тоног төхөөрөмжинд нэмэлт хөрөнгө оруулалт хийхгүйгээр энэхүү хэмжээний түүхий эд боловсруулах бүрэн хангалттай байгаа юм (Хүснэгт 8).

Энэхүү дүн шинжилгээ ноолуур хууль бусаар гаргах үйл ажиллагаа яагаад ингэж их газар авсан, нэмэгдсэн өртөг багатай самнасан ноолуурын экспортоос өөр илүү их нэмэгдсэн өртөгтэй үйлдвэрлэл яагаад нэмэгдэхгүй байгаа асуудлуудыг тавьж байна. Эдгээр асуултуудын ихэнх хариуг Монголд хагас болон гүнзгий боловсруулалт хийгдсэн ноолуурын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртгийг Хятадынхтай харьцуулахад олж мэдэж болно.

Өвөр Монголын үзүүлэлтүүдтэй харьцуулахад, Монголд хөдөлмөрийн хөлс (нэмэлт тэтгэмж, тэтгэлийг оруулаад) 25 хувиар өндөр байхад хөдөлмөрийн бүтээмж Хятадынхаас 25 хувиар доогуур байна.³⁰ Мэргэжлийн өндөр зэрэглэлтэй механик инженер Монголд цөөхөн, мөн машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл байхгүй учир эвдэрсэн тоног төхөөрөмжийн сэлбэгийг Хятад юмуу Европоос оруулж ирэхэд удаан хугацаа шаардагдаж үйлдвэрлэл энэ хугацаагаар зогсоход хүрдэг байна. Хятад улс малчид, боловсруулагч, машин тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, будах болон бусад химийн бодис нийлүүлэгч, үйлдвэрлэгч, борлуулагч болон үйлчилгээ үзүүлэгч (засвар, тээвэрлэлт гэх мэт) нараас бүрдсэн үйлдвэрлэлийн бөөгнөрлийг сайн хөгжүүлж чадсан байна. (Монголын хувьд хувцасны дизайнер харьцангуй их бөгөөд цалин хөлс нь бага юм байна.) Ерөнхийдөө, нэмэгдсэн өртгийн шат дамжлага бүрт дээр Монгол дахь үйлдвэрлэлийн өртөг Хятадынхаас 30-40 хувиар өндөр байна.

²⁹ Зөвхөн Монголд явагдаж байгаа үйл ажиллагааны хүрээнд бий болж байгаа нэмэгдсэн өртгийг харуулсан бөгөөд олон улсад борлуулах, бөөний болон жижиглэнгийн худалдааны нэмэгдсэн өртгийг харуулаагүй болно.

³⁰ Үйлдвэрлэгч нарын мэдээлж өгсөн цалин хөлс, бүтээмж янз бүр, ялгаа ихтэй байсан. Эдгээр тоонуудыг Өвөр Монголд ноолуурын үйлдвэрт менежерээр ажиллаж байгаад Монголд Хятадын хөрөнгө оруулалттай үйлдвэрт менежер хийж байгаа хүн өгсөн.

Хүснэгт 11: Үйлдвэрлэлийн харьцуулсан өртөг (доллар/кг)

Үйлдвэрлэлийн шат дамжлага	Хятад	Монгол
Самнах	\$2.50-\$3.00	\$4-\$5
Ээрэх	\$6.00-\$7.00	\$6.50-\$9.50
Сүлжих	\$2.50-\$3.00	\$4.00
Нэхэх	\$1.50-\$2.00	\$3.00

Эх үүсвэр: Нэхмэлийн хүрээлэнгийн тус төсөлд хийж өгсөн судалгаа

Хэрэгцээний талаас авч үзэхэд хятадын боловсруулагч нар монголынхтой харьцуулбал хэд хэдэн давуу талтай байна. Тэдний сайн хамгаалагдсан дотоодын зах зээл дээр харьцангуй чанартай ноолууран бүтээгдэхүүнийг өндөр үнээр зарж болдог. Монголчуудын хувьд энэхүү зах зээл рүү орох боломж үгүй бөгөөд тэдний дотоод зах зээл нь багтаамж бага юм. Монголын ноолуурын ширхэг хятадынхаас арай бүдүүн боловч урт байдаг тул хятад ноолууртай холиод ээрмэл хийхэд бүтээгдэхүүний бүрсийлт нь багасдаг билээ. Монголын үйлдвэрлэгч нарт хятад түүхий ноолуур худалдан авч өөрсдийн ноолууртай хольж боловсруулах боломж байхгүй байна.

Үйлдвэрлэлийн өртгийн энэхүү зөрүү, бүтээмж доогуур, дотоодын зах зээл нь хамгаалалтгүй байгаа нь олон асуудал үүсгэдэг ч энэ нь монголын үйлдвэрлэгч нарын аминд хүрэхээр аюултай бус юм.³¹ Компани өөрийн бүтээмж, гарцаа ахиулах, өртөг зардлаа бууруулах, чанараа сайжруулах, борлуулалтын үнээ өсгөх гэх мэтийн менежментийн оновчтой замаар эдгээр асуудлуудыг шийдэх боломжтой. Харин олон үйлдвэрлэгч нарын хувьд үхлийн аюултай асуудал бол Монгол, Хятадын хооронд болон Монгол бусад орнуудын хооронд байдаг санхүүжилтийн өртгийн ялгаа юм. Хувийн жижиг/дунд зэргийн үйлдвэрлэгч нарт олдож байгаа зээлийн хүү жилийн 37 хувь (сарын 2,5 хувь) байхад Хятадад 1-6 хувь, бусад оронд 6 хувь байх жишээтэй.

КАПИТАЛЫН ӨРТГИЙН МОНГОЛ БОЛОН ХЯТАДАД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Монголд дунд зэргийн, үйлдвэрлэлийн бүх шат дамжлагатай, дэлхийн жишиг туршлага нэвтрүүлж чадсан үйлдвэрлэгч байна гэж бодоод жилд 200 тонн түүхий эдээр 300 мянган ширхэг сүлжмэл эдлэл үйлдвэрлээд 12 сая долларын орлого олно гэж тооцье. Үүний тулд газар, үйлдвэр, тоног төхөөрөмжинд 6 сая долларын хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Мөн ноолуур самнах үе 3-р сараас 6 сар үргэлжилдэг тул үйлдвэрлэгч өөрийн жилийн хэрэгцээт түүхий эдээ энэ хугацаанд авах хэрэгтэй болдог. Үүний тулд 2005 оны үнээр 6 сая доллар хэрэгтэй болно /200000кг х 30 ам доллар/. 37 хувийн хүүтэй зээл авбал түүхий ноолуур худалдан авах өртөг 1 сая гаруй доллараар нэмэгдэнэ, мөн тоног төхөөрөмж болон үйлдвэрийн зардал ойролцоо 2 сая доллар болно. Нийт хөдөлмөрийн хөлс ойролцоо 600 мянган ам доллар болно. Тэгэхэд Хятадад капиталын зардал маш бага, Өвөр Монголын үйлдвэрлэгч нарыг хөгжүүлэх үүднээс засгийн газар нь тэд нарыг жилийн нэг хувиас бага хүүтэй зээлээр тэтгэж байна. Хамгийн өндөр хүү гэхэд л 6 хувьтай байна.

Ийм бага хэмжээний санхүүжилтийн өртөг нь Хятадын компаниудад түүхий эдээ Монголын үйлдвэрлэгч нартай харьцуулахад өндөр үнээр худалдан авах боломж нээж өгч байна. Өөрөөр хэлбэл, Хятадын санхүүжүүлэлтийн бага өртөг нь Монголын нэмэгдсэн өртгийг шат дамжлага болгон дээр нь шахан дарж өгч байна. Нэмэгдсэн өртөг шахалтан доор байгаа нөхцөлд зээлийн ийм өндөр хүү төлж байгаа тохиолдолд Монголын үйлдвэрлэгч нар ашигтай ажиллаж чадахгүй билээ.³² Нөгөө талаас, Хятадад зээлийн хүү бага байгаа учраас монгол малчдын

³¹ Энэ судалгааны нэг хэсэг болох ноолуурын үйлдвэрийн модель загварыг бий болоход эдгээр өртөг, бүтээмжийн асуудлууд байсан ч сайн удирдлага доор үйлдвэр ашигтай ажиллаж болохыг моделийн тооцоо харуулсан байгаа.

³² Монголын зарим үйлдвэрлэгч нар хятадуудын бага хүүтэй зээл аваад өндөр үнээр түүхий эд худалдан авдаг нь нэмэгдсэн өртгийг шахалтанд оруулж монгол үйлдвэрлэгч нарыг бизнесээс шахан гарган ноолуурын үнийг маш доогуур тогтоох нь Хятадын засгийн газар болон үйлдвэрлэгч

үйлдвэрлэж байгаа ноолуурыг Хятадад боловсруулалтанд оруулсанаар үнэ цэнэ нь өсч байна.

Энэ судалгааны хавсралтанд Монголын санхүүгийн зах зээл маш чөлөөтэй байгаа бөгөөд зээлийн хүүгийн хэмжээ нь санхүүжилтийн эрэлт хэрэгцээнээс хамааран тогтож байгаа мөн энэ зах зээл дээр засгийн газрын хөндлөнгийн оролцоо огт байхгүй талаар дэлгэрэнгүй бичсэн байгаа. Төгрөгийн хадгаламжийн хүү жилийн ойролцоо 15 хувьтай (сарын 1,2 хувь) байхад дунд зэргийн үйлдвэрлэгч нарт олгож байгаа төгрөгийн зээлийн хүү жилийн 37 хувьтай (сарын 2,5 хувь) байна. Эдгээр хүүгийн зөрүү болох 22 хувь нь харьцуулшгүй өндөр байна.³³ Зарим гадны зээлдэгч нар, жишээлбэл KfW хатуу валютын зээлээ 10 хувиас доогуур хүүтэй зээлдүүлсэн байна. Нэгэн банк өөрийн үйлчлүүлэгчид түүхий эд авахад нь зориулж 6 сая ам долларын зээлийг ойролцоо 6 хувийн хүүтэй олгосон байна. Үйлдвэрлэгчдийн ихэнхи бүтээгдэхүүн экспортод гарч хатуу валютаар зарагддаг тул зээлээ мөн хатуу валютаар авбал өөрийгөө эрсдлээс хамгаалах юм. Монголын жижиг ба дунд үйлдвэрлэгч нарт 10-аас доош хувьтай валютын зээл олдож эхлэхээс нааш тэд хятадын компаниудтай өрсөлдөхдөө маш хүнд байдалд байна.

Excel программыг ашиглан нэмэгдсэн өртгийн энэхүү судалгааны нэг хэсэг болох тооцооны хялбаршуулсан моделийг гаргасан болно. Энэ моделийн оролтууд дараах зүйлүүдээр хийгдсэн болно, үүнд: янз бүрийн түвшний ажилчдын цалин хөлс, нийгмийн төлбөр, хураамж, ус, цахилгаан, дулаан болон бусад оролтуудын хэмжээ болон үнэ өртөг нь, үндсэн тоног төхөөрөмж, үйлдвэр болон газар ашиглалтын төлбөр /үнэ, хэмжээ, тоо/, гаралтын үнэ, болон үндсэн түүхий эд болох ноолуурын янз бүрийн гарц. Мөн уг модель руу зээлийн хүү, эздийн өмч болон зээлийн харьцааг оруулж болно. Түүнчлэн татвар, элэгдэл хорогдол, татварын тайлангийн алдагдлыг ирээдүй үед шилжүүлэх хэмжээ, татвараас чөлөөлөгдөх хугацаа, газар болон үл хөдлөх хөрөнгө болох байшин барилгад ногдох татварын хэмжээг оруулж болно. Энэ модель хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь хэмжээ болон нэмэгдсэн өртгийн тооцоог гаргаж ирдэг. Мөн ноолуурын нэмэгдсэн өртгийн янз бүрийн шат дамжлагад хөрөнгө оруулалтын өөр өөр хувилбарууд хийж өгөх боломжтой. Үүнээс гадна энэхүү моделийг ашиглаж байгаа хүнд өртөг, бүтээмж, хүчин чадал, гарцын хэмжээ болон зээлийн хүүгийн хэмжээг өөрчлөх боломж олдож байгаа. Энэ модель дараахь зүйлүүдийг тооцоолон гаргасан байгаа. Үүнд:

- а. Дэлхийн жишигт хүрсэн технологитой, бүтээмж, хүчин чадал, гарцын хэмжээ, чанар өндөр (тиймээс бүтээгдэхүүний үнэ өндөр байх бололцоотой), зээлийн хүү 10 хувиас доош байх тохиолдолд үйлдвэрлэлийн бүх шат дамжлагатай үйлдвэрлэлд эсвэл аль нэг шат дамжлагад нь хөрөнгө оруулалт хийхэд бололцоотой бөгөөд өгөөжийн хувь хэмжээ нь болохуйц байна. Өөрөөр хэлбэл, Хятадтай харьцуулахад бусад зардал, үр ашиг сайнгүй байсан хэдий ч Монголд ийм хэлбэрээр хөрөнгө оруулалт хийхэд ашигтай байж болно.
- б. Дэлхийн жишигт хүрсэн технологитой, бүтээмж, хүчин чадал, гарцын хэмжээ, чанар нь өндөр (тиймээс бүтээгдэхүүний үнэ өндөр байх бололцоотой) гэвч зээлийн хүү 37 хувьтай байх тохиолдолд, үйлдвэрлэлийн бүх шат дамжлагатай үйлдвэрлэлд эсвэл аль нэг шат дамжлагад нь хөрөнгө оруулалт хийх бололцоогүй буюу өгөөжийн хувь хэмжээ нь үл зөвшөөрөгдөх түвшинд байна. Өөрөөр хэлбэл, Хятадыхтай харьцуулсан

нарын бодлого юм гэж үзэж байна. Үүнийг батлахын тулд тэд Монголын ноос, арьс ширний салбарын хувь заяаг иш татаж байна.

³³ Хадгаламж, зээлийн хүүгийн зөрүүг инфляцийн нөлөөг үгүй болгоход ашиглаж байна.

Монголын бусад үзүүлэлтүүд хэвээрээ хэрнээ хөрөнгө оруулагч санхүүжилтэндээ 37 хувийн хүү төлөхөөр байвал энэ хөрөнгө оруулалт хийгдэхгүй.

- в. Хэрвээ боловсруулалтын гарцын хэмжээг дэлхийн жишгээс доогуур тооцоод (жишээлбэл, самнахын гарц 48-49 хувьтай, ээрхийн гарц 78-80 хувьтай байхаар) бусад үзүүлэлтүүдийг дээрхтэй ижил байлгавал, хөрөнгө оруулалт ашиггүй тул хийгдэхгүй, өгөөжийн хувь хэмжээ нь үл зөвшөөрөгдөнө. Өөрөөр хэлбэл, Хятадынхтай харьцуулсан Монголын бусад үзүүлэлтүүд хэвээрээ хэрнээ гарц ийм хэмжээнд байх юм бол хөрөнгө оруулалт хийгдэхгүй.
- г. Бүтээгдэхүүний үнийг ойролцоогоор 1 грамд 10-11 центээр гэрээлвэл (бусад үзүүлэлтүүдийг дээрхийн адил байлгасан тохиолдолд) хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь хэмжээ зөвшөөрөгдөх түвшинд хүрэхгүй тул хөрөнгө оруулалт хийгдэхгүй. Өөрөөр хэлбэл, Хятадынхтай харьцуулсан Монголын бусад үзүүлэлтүүд хэвээрээ хэрнээ чанар доогуур улмаас үнэ ийм хэмжээнд байх юм бол хөрөнгө оруулалт ашиггүй байх болно.

Эдгээр хувилбарууд хөрөнгө оруулалтыг (дэвшингүй технологи, боловсон хүчин, бүтээмж (Монголчуудын одоогийн түвшний бүтээмж, ур чадварыг тооцоод) чанар, гарцыг дэлхийн жишигт ойртуулсан үзүүлэлттэй байлгахад) олон улсад тооцогддог хүүтэй зээлийг авч чадах тохиолдолд хийж болно гэсэн тооцоог гаргасан нь сонирхолтой ололт болсон.

Эдгээр хувилбарууд нь энэ судалгааны эхний хэсэгт хийгдсэн дүгнэлтүүдийг бататгаж байгаа юм. Хүү багатай зээл олж авах нь чухал боловч энэ нь дангаараа хөрөнгө оруулалтыг өгөөжтэй байлгахад хангалтгүй юм. Монголын санхүүгийн зах зээлийн одоогийн байдлыг авч үзэхэд ойрын хугацаанд хүү багатай зээл олдоно гэдэг нь үндэслэлгүй зүйл юм. Донор орнуудаас орж ирж байгаа бага хүүтэй зээл хүрэлцээ муутай байна. Тэгэхлээр санхүүжилтийг ямар нэгэн хэлбэрээр гадны банкуудаас авах эсвэл гадны хөрөнгө оруулагчид компаниудад хөрөнгө оруулалт хийж тодорхой хэсгийг нь өмчлөх, зээл оруулж ирэх, эсвэл урт хугацаанд хамтран ажиллаж байгаа компаниуд урьчилсан төлбөр хийх маягаар санхүүжилт олох арга замуудаар хийх хэрэгтэй болж байна. Одоогийн байдлаар эдгээр санхүүжилтийн орчин ихэнх компаниудад таатай бус байна.

Өнөөдрийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалт хийх орчныг цаашид сайжруулах шаардлагатай байна. Монголд татварын хэмжээ өндөр, татвараас чөлөөлөх хугацаа богино байна.³⁴ Тухайн бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад Монголын Засгийн газрын бодлого харьцангуй сайжирсан болон зарим тохиолдолд илүү ч гэсэн, хэцүү, нээлттэй бус, өргөн хүрээтэй байх нь нийтлэг хэвээр байгаа бөгөөд хууль эрх зүйн системийг илүү хөгжингүй болох хэрэгтэй байна. Гадны хөрөнгө оруулагч, зээлдүүлэгч нарын хувьд монголчуудын эсрэг хуулийн арга хэмжээ авах тохиолдолд холбогдох хуулийн заалтууд тодорхой болоогүй байна. Олон жишээг авч үзэхэд, зээлдүүлэгч эргэн төлөгдөөгүй зээлээ олж авахаар шүүхэд хандахад төлөгдөөгүй зээлийн хүүг тооцдоггүй юм байна.

³⁴ Монголын ноолуурын салбарын хувьд, гадныхан эхний гурван жилд татвар төлөхгүй, дараагийн гурван жил 50 хувийн татвар төлөх юм байна. Ойролцоо байрлалттай бусад орнуудын хувьд экспортын баримжаатай компаниудад 10 жилийн хөнгөлөлт үзүүлдэг юм байна. Гэтэл дотоодын хөрөнгө оруулагч ямар ч хөнгөлөлтгүй байдаг нь хамгийн хачирхалтай болон бүтэшгүй зүйл юм. Өөр нэгэн чухал зүйл гэвэл, Монгол улс татварын тайлангийн алдагдлыг ирээдүй үед шилжүүлдэггүй, хурдасгасан элэгдэл хорогдлыг орлогоос хасах болон бусад зардлуудыг зардал болгон хасахыг зөвшөөрдөггүй юм байна.

Монголын Засгийн газрын анхааралд толилуулж буй арга хэмжээ:

- Засгийн газар санхүү зээл төлбөрийн тухай хуулиудыг цаашин хөгжүүлж, зээлдэгч төлбөрөө хийгээгүй тохиолдолд түүнийг нь зарлаж алдагдалаа эргүүлэн авах, үүнийг хүндрэлгүйгээр богино хугацаанд хэрэгжүүлэх нөхцлөөр ханган өгч зээлдүүлэгч нарын эрхийг илүү болгож өгөх хэрэгтэй.
- Засгийн газар Монголын боловсруулах салбарт хийгдэх шууд хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогоо цаашин хөгжүүлэх бололцоотой. Тодорхой хэлбэл, Засгийн газар (эсвэл аль нэг донор байгууллага) Хөрөнгө оруулагчийн Roadmap Study (I, II, III үе шат) судалж хөрөнгө оруулалт хийхэд учирч болзошгүй саад бэрхшээлийг багасгах ажлыг гүйцэтгэх, Монголд байгаа шууд хөрөнгө оруулалтыг илүү сайн тооцох, түүний бий болгосон ажлын орон тоо, үйлдвэрлэлийн хэмжээ, экспортонд үзүүлсэн нөлөөллийг тооцоход ашиглагдах хөрөнгө оруулагч нарыг тодруулах системийг (Investor Tracking system) хөгжүүлэх, ноолуурын салбарт үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын урамшуулалтуудыг дахин бодолцож тэдгээрийг дотоод ба гадаадын хөрөнгө оруулагч нарт адилхан хамааруулах, хөрөнгө оруулалт хийх, сурталчлахад нь үзүүлэх туслалцаа болон цаашид түүнд тавих анхаарлыг сайжруулахын тулд ГХОГХА-ийн чадавхийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй.
- Засгийн газар аливаа нэгэн боловсруулагчид зээл авахад нь баталгаа гаргахгүй байх.
- Засгийн газар эдийн засгийн албан салбар болох аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгч/ ажилчдын нийгмийн даатгалын төлбөр хураамжийг багасгаж, уг хураамжийг мал аж ахуйн салбар, ажилгүйчүүд болон тэтгэвэрийхнийг тэтгэх зориулалтаар зарцуулахаа болих хэрэгтэй.

ХЭСЭГ VI: МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗРААС НООЛУУРЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХУВИЛБАРУУД

Монголын Засгийн газар ноолуурын салбарт хэрэгжүүлэх бодлогодоо гурван үндсэн сонголт хийх асуудалтай тулгарч байна. Үүнд: экспортын татварын бодлогоо цаашид хэрэгжүүлэхдээ татвар авах хугацаагаа уртасгах, ямар нэгэн хэлбэрээр тус салбарт шууд татаас өгөх, дээр дурьдсан зүйлүүдийг хэрэгжүүлэнгээ байгаа байдлаа хадгалан үлдээх.

А. Түүхийн ноолуурын экспортын татвар

Монгол Улс түүхийн ноолуурандаа экспортын татвар тавьсан байгаа. Экспортын татвар нь 2005 оны 1 кг түүхийн ноолуурын үнийн дөнгөж 12 хувьтай тэнцүү, 2007 оны 1-р сар гэхэд дуусгавар болох бөгөөд одоо хэрэгжихгүй байгаа болон түүхий ноолуурын хууль бус экспорт газар авсан байдал ажиглагдаж байна. Тэгэхлээр хоорондоо уялдаа холбоотой 3 асуулт гарч ирж байна: экспортын татварын үйлчлэх хугацааг сунгах шаардлага байна уу? Тийм гэвэл, хэмжээг нь хэдээр тогтоох вэ? Тийм гэвэл, түүнийг яаж үр дүнтэй цуглуулах буюу хуулиа яаж хэрэгжүүлэх вэ? Эдгээр асуултнуудыг нөгөө талаас нь авч үзэхэд:

2000 он хүртэл экспортын татвар зохих ёсныхоо дагуу хураагдаж экспортонд гарсан түүхий ноолуурын хэмжээн дээр дотооддоо боловсруулалтанд орсон түүхий ноолуурын хэмжээг нэмбэл нийт түүхий ноолуурын үйлдвэрлэлийн тоонд ойролцоо очиж байсан байна, өөрөөр хэлбэл түүхий ноолуур хууль бусаар маш бага хэмжээгээр гарч байжээ. Асуудлын гол зангиа нь хэрэв хилийн боомт дээр ажилладаг гаалийн удирдлага болон ажилтнууд хуулиа хэрэгжүүлэхийг хүсвэл татварыг бүрэн хурааж болдогт оршиж байна. Харамсалтай нь сүүлийн дөрвөн жил түүхий ноолуурын хууль бус экспорт газар аван өсч түүнийг дагалдан гаалийн ажилтнуудын орлого, зарлага болон санаархал мөн өссөн байна. Энэ асуудлыг ямар нэгэн захиргааны арга хэмжээгээр засаж залруулах нь өнгөрсөн хэрэг. Гаалийн ажилтнуудын цалинг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох сонирхолтой болтол нэмэх нь мөн явцуу зүйл юм.

Тэгэхлээр энэ байдлыг тунгаан шүүгээд, гаалийн ажилтнуудад хууль бусаар гарах гэж байсан ноолуурыг илрүүлсэн тохиолдолд тэр хэмжээнд нь ногдуулсан татварын хэмжээний тодорхой хувийг (торгуулийн хамт) урамшуулал болгон өгч болох юм. Эсвэл улсын орлого болгож авсан хууль бусаар гарах гэж байсан ноолуурыг зах дээр борлуулаад олсон орлогын тодорхой хувийг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоосон гаалийн ажилтнуудад өгөх.

Экспортын татварын хэмжээг 1997 онд тогтоосон шиг 30 хувиар тогтоож болох юм.³⁵ Үүнийг богино хугацаанд ба тусламжийн байгуулагуудын зүгээс тухайн үедээ ямар нэгэн эсэргүйцэл гаргуулахгүйгээр гүйцэтгэх боломжтой. Хэрвээ санал болгосны дагуу татварын хугацааг уртасгаж түүнийг үр дүнтэй хурааж чадахгүй бол, тэртэй тэргүй энэ татварын хүчинтэй байх хугацаа нь ердөө л 18 сар үлдсэн. Энэ хамгаалах арга хэмжээ одоогийн (эсвэл ирээдүйн) үйлдвэрлэгч нарыг үйлдвэрлэлээ эрчимжүүлэх, чанараа сайжруулах эсвэл шинээр нэмж хөрөнгө оруулахад нь түлхэц үзүүлэхэд хангалттай бус. Хамгийн сайндаа гэвэл, экспортын татварыг нэмж хурааж чадвал орлого, ямар нэгэн үр ашгийг нэмэгдүүлэхгүйгээр, нийгэмд урт хугацааны өгөөж өгөхгүйгээр, малчдаас үйлдвэрлэгч нарт шилжинэ.

³⁵ Бид энэ хэмжээг яагаад хувиар нь үлдээгээгүй харин тогтмол тоогоор сольсон болохыг тайлбарлуулж чадаагүй билээ. Тооцоог хялбаршуулах үүднээс ингэсэн байж магадгүй.

Тийм учраас, хэрвээ Засгийн газар экспортын татварыг үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг хурдасгах зориулалтаар ашиглах гэж байгаа бол татварын хүчинтэй байх хугацааг нэлээн урт хугацаа буюу жишээлбэл 10 жилээр тогтоож, үйлдвэрлэлийг энэ хугацаанд хөгжүүлэхийг урамшуулах хэрэгтэй. Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орон болохдоо энэ татварыг 2007 он гэхэд үгүй болгоно гэж амласан ч, түүнийг цаашид авч үлдэх таалаар үндэслэл сайтай тайлбар өгөх боломжтой. Гэвч Засгийн газрын энэхүү авч болох арга хэмжээ нь зарим тусламжийн байгууллагуудад таагүй сэтгэгдэл төрүүлж болох юм.³⁶ Дараах хэдэн тайлбар тавьснаар эдгээр байгууллагуудын дургүйцлийг намдааж болно. Үүнд:

- Хөгжиж буй ялангуяа хуучин төвлөрсөн эдийн засагтай байсан орнуудын дунд, Монгол Улс өөрийн ардчиллын эрч хүч нээлттэй байдал, авилгалын түвшний ерөнхийдөө доогуур үзүүлэлтүүд, эдийн засгийн өсөлт, чөлөөт зах зээл рүү шилжиж байгаа эдийн засгийнхаа хувьд онцгой байр суурь эзлэж байна. Монгол Улсын эдгээр ололтууд тус улсыг Мянганы Сорилтын Корпорацийн сангаас тусламж авахад бололцоотой болгосон. Гэхдээ урт хугацааны татварын бодлого хэрэгжүүлж эхлэвэл зах зээлийн хүчин зүйлсээс ухрах алхам болох юм. Нөгөө талаар Монгол улсын үзүүлэлтүүдийг авч үзвэл экспортын татвар том ухралт гэж тооцогдохгүй байж болох юм.
- Засгийн газраас албадан өндрөөр тогтоосон нийгмийн хураамж болон зээлийн өндөр хүү үйлдвэрлэлийн салбарын хувьд хүнд ачаа болж байна. Экспортын татвар эдгээрийг нөгөө талаас нь тэнцүүлэх үйлчилгээ үзүүлнэ. Түүнчлэн, эдийн засгийн "хоёр дахь нь илүү байдаг" онол нь олон төрлийн гажилттай эдийн засгийн нэг гажилтыг арилгавал энэ нь эдийн засгийг үр ашигтай болоход заавал нөлөөлөхгүй гэдгийг харуулсан болно.
- Засгийн газар экспортын татварын бодлого хэрэгжиж чадаагүйгээс болж үйлдвэрлэл энэ хугацаанд амжиж хөгжиж чадаагүй тул нялх үйлдвэрлэлийн салбарыг хамгаалтандаа авах бодлого хэрэгжүүлэх талаар мэтгэлцэж болно. Түүнчлэн үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэхдээ ямар нэг хэлбэрийн худалдааны хамгаалалт хэрэглээгүй улс орон дэлхийд байхгүй гэдгийг Монголын Засгийн газар дурдах хэрэгтэй. Нялх салбарын талаарх маргаан АНУ-ын Ерөнхийлөгч Томас Жефферсоны засаглалын үеэс үүдэлтэй.
- Экспортын хоригийн асуудлыг ДХБ зохицуулдаггүй. Канад зэрэг зарим орон модны экспортод хориг тавьдаг. АНУ хүртэл Холбооны Засгийн газрын нутаг дэвсгэр дээрээс огтолсон модыг экспортлохыг хориглодог байна.
- Эцэст нь эдгээр тусламжийн байгууллагуудын Хятадад үзүүлж буй илүү их хэмжээний тэтгэмж, тэтгэлэг нь тухайн орны үйлдвэрлэлийн салбарыг хөгжихөд нь нөлөөлж байгаа. Тэгэхлээр Монгол улсын үйлдвэрлэгч нарт Хятадын хэмжээний бүтээмж, чанартай болохын тулд мөн адилхан хэмжээний тусламж, тэтгэлэг хэрэгтэй гэж мэтгэлцэж болох юм. Одоогоор асуудлыг тавих (тоглоомын)

³⁶ Эдгээр байгууллагуудын байр суурийг мөн ойшоохгүй байж болохгүй. Дэлхийн банкны ноолуурын салбарын талаар хийсэн судалгаанд экспортын татварыг тэглэх тайлбараа дараах логикоор хийсэн байгаа: "Муу үр дагавартай татваруудыг – ноолуурын экспортын татварыг оролцуулаад тэглэвэл хууль бус наймааг багасгаж, дотоодын үйлдвэрлэх хүчин чадалд нийлүүлэгдэх ноолуурын хэмжээ ихэснэ". (хуудас 43)

талбарын хүрээ Монголын үйлдвэрлэгч нарын хувьд хавчигдсан байдалтай байна. Экспортын татвар энэхүү талбарыг тэлж монголчуудад өрсөлдөх болон хөгжих бололцоо олгоно.

Эдгээр саналуудыг эсэргүүцэх хариу нь бас л тодорхой байгаа: Монголын микро эдийн засаг Засгийн газраас гаргасан маш олон тогтоол дүрэм журмаар гажуудуулсан байгаа. Экспортын татварыг нэмэх, түүнийг бүрэн гүйцэд хураах, хугацааг нь уртасгах ажлууд дахин нэг гажуудал үүсгэж болзошгүй тул түүхий эдийн зах зээлийн хуваарилалт төдийлөн үр ашигтай байж чадахгүй байх. Энэ бодол дараах сонголт руу хөтлөж байна.

Б. Засгийн газрын сангаас боловсруулах компаниудад шууд татаас өгөх

”Эдийн засгийн сонголт” онол нь татаас өгөхөөр бол заавал ямарваа нэгэн зүйлийг хийлгэх зориулалтаар өгөх биш харин шууд мөнгө өгсөн нь дээр гэдгийг маш тодорхой баталсан.³⁷ Эдийн засагт гажиг үүсгэдэг зүгээр нэг тэтгэлэгээс (экспортын татвар эсвэл үнийг дээд хэмжээгээр тогтоож өгөх нь тэтгэлэгт тооцогдоно) зориулалтын шууд татаас өгсөн нь дээр гэж нийгмийн хангамжийн эдийн засаг үздэг байна. Шууд татаасын хүрээ, зориулалт, хүлээн авагч нарыг амархан тодорхой болгож болно. Тиймээс шууд тэтгэлэлийг хуримтлуулахад улс төрийн хувьд хүндрэлтэй бөгөөд улс төрийн шүүмжлэлд үргэлж нээлттэй байдаг.

Гэвч бусад орнуудын засгийн газруудыг харахад шууд тэтгэлэг өгөхөөсөө зах зээл гажуудуулдаг татаас илүү өгдөг юм.

С. Санал болгосон зүйлүүдийг хэрэгжүүлэнгээ байгаа байдлаа хадгалан үлдэх буюу статус кво

Байгаа байдлаа хадгалан үлдэх нь тийм ч оновчтой сонголт болхооргүй байгаа гэдгийг энэ судалгааны тайлангийн эхнээс нь л тодорхой болгосон байгаа. Мал аж ахуй, боловсруулах салбарын аль алиных нь зүй тогтолцоо гажуудалтай байгаа: нэг нь өндөр татвараар дарамтлуулсан нөгөөх нь татаасаар тэжээлэгддэг, тиймээс зах зээл түүхий эдийг үр дүнгүй хувиарлаж байна. Үйлдвэрлэлийн салбарын хүчин чадал хэтэрсэн байхад, мал аж ахуйн хувьд үйлдвэрлэл нь бэлчээрийн даацнаасаа хэтэрсэн байна. Илүү хүчин чадал байсаар байтал түүхий ноолуурын бараг тал нь Хятад руу хууль бусаар ямар нэгэн нэмэгдсэн өртөг шингэхгүйгээр гарч байна. Үлдсэн хэсгийн ихэнх нь маш бага нэмэгдсэн өртөгтэй экспортлогдож байна.

Гэхдээ энэ судалгаанд Засгийн газарт санал болгосон авч болох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлбэл ноолуурын салбарын ихэнхи гажуудал засагдаж үйлдвэрлэл илүү үр ашигтай ажиллаж эхэлж болно. Үүгээр үйлдвэрлэлийн бууралт магадгүй үргэлжилж болох юм гэдгийг үгүйсгэхгүй ч учир шалтгаан нь гажуудуулагдсан зах зээлийн байдал бус харин Монголын харьцангуй давуу тал болно.

Судалгааны хувилбарууд салбарын зарим нэгж байгууллагуудыг өөрчлөн байгуулах шаардлагатай, эсвэл үйл ажиллагаанаасаа болж зарим нь дампуурч магадгүй дүр зурагтай байгаа ч менежментээ сайжруулаад, бага хүүтэй зээл авч чадах нөхцөлд үйлдвэрлэлийн салбар саад бэрхшээлийг даван туулж хөгжин цэцэглэх бүрэн бололцоотойг харуулсан болно.

³⁷ Гуйлгачинд нэг долларын үнэтэй хүнсний зүйл өгч байснаас нэг доллар өгөөд түүгээр яах эсэхийг өөрөөр нь шийдүүлсэн нь дээр

**ХАВСРАЛТ А: МОНГОЛЫН НООЛУУРЫН САЛБАРЫН ЭЭРЭХ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДЛЫН ҮНЭЛГЭЭ**

Хураангуй

Тус тайлан бодит байдалд хэр нийцэж байгаа нь Монголын ноолуурын салбарын гол төлөөлөгчдийн өгсөн мэдээллийн чанар, ЭЗБШӨЧ төслийн зүгээс тухайн мэдээлэлд хэр зэрэг бодитой үнэлэлт дүгнэлт өгснөөс хамаарна.

Тус тайланг бэлтгэх явцад Монголын ноолуурын үйлдвэрлэгчид маш их нээлттэй, илэн далангүй хандаж байсан. Одоогоор ээрэх үйл ажиллагаа явуулж буй бүх үйлдвэр, мөн цаашид ээрэх үйл ажиллагаа эхлүүлэх гэж буй самнах, сүлжих, нэхэх үйл ажиллагаа эрхэлдэг үйлдвэрүүд ярилцлага өгөх явцдаа тус судалгааг хийсэн багт өөрсдийн үйлдвэрийн болон салбарын байдлыг өөрсдийн ойлгосноор аль болох бодитой танилцуулах хүсэлтэй байсан. Гэхдээ экспортын зах зээлийн өвөрмөц онцлог, хэрэгцээ шаардлагыг салбарын гол удирдлагууд төдийлөн сайн ойлгохгүй байгаагийн улмаас зарим нэг учир дутагдалтай асуудлууд байсаар байна. Эдгээр асуудлыг энэхүү тайлангийн холбогдох хэсэгт тодотгож өгсөн бөгөөд тэдгээр нь цаашид хийх ажлын талаарх саналын үндэс болж байна.

Ноолууран бүтээгдэхүүн, түүнтэй ижил төрлийн буюу ноолуурын хольцтой бүтээгдэхүүн, нэхмэл хувцас, иж бүрдэл буюу сүлжмэл бүтээгдэхүүний зах зээл өргөжин тэлж байна. Үйлдвэрлэлийн шинэ технологийн хурд нэмэгдэж чанар дээшилж байгаа нь бүтээгдэхүүний өртгийг бууруулж улмаар хямд бүтээгдэхүүн илүү их үйлдвэрлэж, зах зээл нь өргөжсөөр байна.

Үүнээс гадна жижиглэнгийн борлуулалтын загвар нь хурдтай өөрчлөгдсөнөөр илүү үр ашигтай бөгөөд хувцасны загварын эрэлт хэрэгцээнд мэдрэмжтэй болж байна. Технологи, хувцасны загварын өөрчлөлтийн өсөн нэмэгдэж буй хурд, барууны улс орнуудын иргэдийн хувцасны хэв маягийн өөрчлөлт шинэчлэлт нь ноолуурыг өргөжин тэлж буй зах зээлд илүү өргөн хэмжээнд худалдан авах боломжийг бүрдүүлж байна.

*Yāāyūdeéí Ī īīāīēūī īīīēōōdūī nāēāādō ħħħēýō ħħ ī°ē°° òīāīdōīé
pī . Óōñ nāēāād īū ħēēāāyūdeēēēī āāī æēāāūī áĥō ħā øāòāīā ÷°ē°°ò
ħāō ħūyēēēī ħēē āæēēāāāīā ēēħ ħūyēòòyē āīēīō ,ñòīé.*

Ноолуурын салбар шинээр бүтээгдэхүүн бүтээж гаргах, шинэ зах зээлийг хөгжүүлэх ажилд хамрагдах ёстой.

Тус салбарын одоогийн хүчин чадал нь зах зээл, түүн рүү гарах шинэ, илүү үр ашигтай гарц хэрхэн өөрчлөгдөж байгааг сайн ойлгоход ашиглагдах ёстой.

Хэрэв салбарын одоогийн оролцогчид нь шинээр үүсч буй болон хөгжиж буй зах зээл рүү бүрэн хэмжээнд олигтой нэвтэрч чадахааргүй бол зах зээлийн эдийн засагтай улс орнуудын компани пүүсүүдийг монголын ноолуурын салбарт шинээр орохыг дэмжих хэрэгтэй.

Энэ хоёр хүчин зүйл нь тус салбарыг хөгжүүлэхэд өөрсдийн үүргийг гүйцэтгэж чадна.

Монголын ноолуурын салбарын ээрэх үйлдвэрлэлийн хүчин чадлын үнэлгээ

А. Тус салбарын үйл ажиллагааны орчинд нөлөөлөх зах зээлд гарч буй өөрчлөлт

- Сүүлийн 20 жилд технологид гарсан өөрчлөлт, өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үе шатанд үйлдвэрлэлийн хурд нэмэгдэж чанар дээшилсэн нь үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн зардлыг багасгах, чанарыг сайжруулах, хувцасны нэг бүрийн үнийг бууруулахад тус дөхөм үзүүлсэн.

- Гаднаас бараа, үйлчилгээ авсан нь үйлдвэрлэлийн зардлыг илүү бууруулахад тус дөхөм үзүүлсэн бөгөөд энэ хандлага нь Оёмол сүлжмэл бүтээгдэхүүний олон талт хэлэлцээр дуусгавар болсноор нэмэгдэх болно.
- Үүн дээр нэмж хэлэхэд брэнд эзэмшигчид нь цалин хөлс доогуур, зардал хямд улс орнуудын үйлдвэрлэгч нартай өөрсдийн нэрийн бараагаа үйлдвэрлүүлэх гэрээ хийж байна. Энэ хандлага ноолуурын салбарт эхний шатанд нэвтэрч байгаа хэдий ч цаашид жил болгон илүү идэвхтэй болно.
- Нөгөө талаас цалин хөлс доогуур улс орнуудын үйлдвэрлэгчид нь жижиглэн худалдаанд нэгдэж буюу өөрсдийн брэндийг бүтээж чадаагүй байна.
- Хувцасны компаниуд нь бүтээгдэхүүн бүрийг илүү өргөн хэмжээнд борлуулахын тулд илүү олон "улирал" бий болгож хувцасны загварын өөрчлөлтүүдийг түргэсгэж байна.
- Жижиглэнгийн борлуулалтын загвар өөрчлөгдсөн. Ер бусын өндөр ашиг нь барааны удаан эргэлт, борлогдоогүй бараа их, ажиллах хүчний зардал өндөр зэрэг хүндрэлүүдийг хаадаг тансаг хэрэглээний зах зээл нь борлогдоогүй үлдэгдэл бараа үгүй, барааны эргэлт хурдан, цөөхөн ажиллах хүчтэй, ашгийн хэмжээ багатай зах зээлийн загвараар солигдож байна.
- Шинэ загварын олох ашиг нь уламжлалт тансаг хэрэглээний барааны зах зээлийн ашгаас маш доогуур байгаа хэдий боловч энэ нь жижиглэн худалдаалагчид өөрийнх нь уламжлалт гүйлгээ сайтай сонгодог бүтээгдэхүүнээс илүү өндөр дундаж ашгийг олох хаалгыг нээж өгч байна. Иймээс энэ нь түүний бүтээгдэхүүнд илүү их ач тустай сонирхол татахуйц зүйл болж байна.

Үр нөлөө

- Нэгжийн өртөг багассанаар нэгжийн эрэлт хэрэгцээ ихсэж, ерөнхийдөө оёмол сүлжмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлого нэмэгдэж байна.
- Үнэ хямд боловч чанар сайтай хувцас нийлүүлэгдэж байгаа тул зах зээлд өндөр үнэтэй бүтээгдэхүүний эзлэх хувь буурч байна.
- Ноолуурын эрэлт цаашид нэмэгдэнэ, гэхдээ зах зээлийн тансаг хэрэглээний хэсэгт нэмэгдэхгүй.
- Мөн торго, ноос, хөвөн даавуу, нийлэг эдтэй хольсон ноолуурын эрэлт нэмэгдэх болно. Бүтээгдэхүүний ийм өөрчлөлт нь дунд зэргийн зах зээлд, цаашилбал үнэ хямд/орлого сайтай хямд зах зээлд илүү хямд үнэтэй ноолуурын олдцыг нэмэгдүүлнэ.
- Иймээс монголын ноолуурын хувьд сайхан боломж бий болж байна. Учир нь бусад чанар, хүндрэлтэй асуудлуудыг шийдэж чадахаар бол бохир ноолуурын дундаж чанарын бууралт бүтээгдэхүүний өрсөлдөх чадварт сөрөг нөлөө үзүүлэхээргүй байгаа.
- Монголын гүнзгий үйлдвэрлэл явуулдаг хоёр компани ээрмэл утас, сүлжмэл эдлэл, нэхмэл хөнжлийг үндсэндээ дотоодын зах зээлд зориулан үйлдвэрлэдэг бөгөөд цөөхөн гадаадын худалдан авагчтай.

Маркетингийн ур чадвар дутагдалтай байгаа нь экспортын зах зээлийн үйл ажиллагааг хязгаарлаж байна.

Б. Монголын ээрмэлийн салбарт үзүүлэх тодорхой үр нөлөө

Одоогийн байдлаар зах зээлийн маш тодорхой хоёр хэсэг бүрдэж байна.

- 1) Ноолуурын тансаг хэрэглээнд тооцдог өндөр хэрэглээний оёмол сүлжмэл хувцасны уламжлалт зах зээл
- 2) Чанар доогуур, зарим үед хольцтой бүтээгдэхүүн нь ноолуур, ноолуураас гаралтай эдлэлийг илүү олон хүнд хүргэж чадах хурдтай хөгжиж буй ноолуурын өргөн хэрэглээний зах зээл. Энэхүү зах зээлийн онцлог нь бүтээгдэхүүний чанар доогуур, хувцасны тухайн моод загвар богино хугацаанд моодонд байдаг учраас хувцасны загвар хурдан өөрчлөгддөг, зах зээлийн мэдрэмж сайтай, борлуулалт богино хугацаанд хийгддэгт оршиж байна.

Эдгээр хүчин зүйлтэй холбоотой монголын ээрмэлийн салбарт гарч буй хэрэгцээ шаардлага нь нэг талаас үнэ хямд учир чанар доогуур нөгөө талаас, өндөр чанар, микрон багатай жинхэнэ ноолуур үйлдвэрлэх үү гэх зөрчил үүсгэж байгаа мэт харагдаж магадгүй. Эдгээр зүйлүүд стратегийн хоёр тал, хамтад нь хэрэгжүүлэх боломжтой алхмууд юм. Тансаг хэрэглээний зах зээлд нийлүүлэгддэг өндөр чанартай ноолуур үйлдвэрлэж, түүний борлуулалтаас олсон өндөр ашгаа хольцтой шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөтөлбөр бий болгож, түүнд зах зээл олох, хөгжиж байгаа дундаж зах зээл рүү нэвтрэх гарц бий болгоход ашиглах явдал юм.

В. Тус салбарын одоогийн статус

- Одоогийн байдлаар олон улсын зах зээлийн чанарын стандартыг хангаж чадах ээрэх тоног төхөөрөмж, хүчин чадалтай зөвхөн 2 үйлдвэр байна. Энэ бол Говь корпораци, “Буян” компани юм. Ээрэх үйл ажиллагаа явуулдаг гурав дахь компани болох Санширо ХХК нь жижиг овортой, идэвхтэй ажилладаг хэдий боловч дагнасан зах зээл дээр нэг хүний хүчин зүтгэл, ур чадвараас хамаарч үйл ажиллагаа явуулдаг жижиг оролцогч юм.
- Ээрмэл ХК, Монгол ноолуур, тэмээний ноос компаниуд (МНТНК) тус салбарт ээрэх үйл ажиллагаа явуулах гэж байгаа бөгөөд олон улсын түвшинд ажиллах бололцоотой оролцогчид болох юм.

Говь корпораци

Говь корпорацийн тоног төхөөрөмж нь ноосон болон хагас нарийн зүүн ээрмэлийг хийхэд зориулагдсан бөгөөд үйлдвэрлэгдэж байгаа ээрмэл нь сүлжмэл эдлэл болон твид хэлбэрийн нэхмэл даавуу, нарийн ээрмэл нь нарийн гейжтэй сүлжмэл эсвэл хувцасны нарийн даавууны үйлдвэрлэлд ашиглагдаж байна.

Жилд 150 тонн нарийн ширхэгт утас үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд эдүгээ тус компани нь ноолуур, тэмээний ноос боловсруулж байгаа бөгөөд торго, бусад нарийн ширхэгтэй хольж боловсруулах чиглэлээр зарим ажил хийгдэж байна.

Хүчин чадлыг энэхүү хэмжээ нь ажлын зөвхөн 5 өдөр, 1 ээлжээр ажиллахаар тооцоологдсон. Үйлдвэрлэгчдээс гарч байгаа хэмжээ нь үүнээс нэлээд доогуур байна. Шалтгаанууд дараахь хүндрэлтэй асуудлаас үүдэлтэй. Үүнд:

- Зах зээлийн хомсдолтой байдал. Хэрэглэгчдийн хүрээ нь хэтэрхий хязгаарлагдмал, нэг хэрэглэгчээс маш их хамааралтай ба орлого оруулах шинэ хэрэглэгчдийг татах маркетингийн үйл ажиллагааны үр дүн бага.
- Эргэлтийн хөрөнгө хүрэлцээгүй. (Дональд Лекрогийн зөвлөмжийг үзнэ үү)
- Эргэлтийн хөрөнгийн зардал (дээрх зөвлөмжийг үзнэ үү)

- Ур чадвар сул
- Туршилт хийх, чанарын шалгалтын систем ашиглах, шинэ бүтээгдэхүүн зохион бүтээж гаргахад туслах тоног төхөөрөмж хүрэлцээгүй
- Ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ тааруу бөгөөд сэлбэг хэрэгсэл авах, засвар үйлчилгээ хийх хөтөлбөр хангалтгүй

Хэрэв эдгээр бэрхшээлийг даван туулж чадвал хүчин чадал нь ажлын гурван ээлжтэй, зургаан өдөр ажиллаж тоног төхөөрөмжийн үр ашгийг нэмэгдүүлж, сул зогсолтыг бууруулсан тохиолдолд жилд 250-300 тонноос дээш бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.

Энэхүү хүчин чадлаар ажиллах бол, ээрэхийн өмнөх шат болох угаах, самнах, холих, будах бүх шатны хүчин чадлыг мөн нэмэгдүүлж, ээрэх тоног төхөөрөмжийг бүрэн хэмжээнд ашиглана гэж үзвэл илүү олон нэр төрлийн бүтээгдэхүүн санал болгох, нэмэгдсэн өртгийн үйлдвэрлэлийн шат дамжлагын зарим хүчин чадлыг бусдад ажил хийж өгөхөөр ажиллан орлого олох, шинэ зах зээл хөгжүүлэх хөтөлбөрийг агуулсан шинэ бизнесийн загвартай болох хэрэгтэй.

Хуучирсан ч ашиглагдах боломжтой тоног төхөөрөмжийг ажиллуулах үндсэн зарчмыг “хөрөнгийн хөлсийг гаргах” гэж дүрслэх нь тун оновчтой юм. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх биш харин бүтээмжийг дээд зэрэгт хүргэж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ гэсэн үг юм. Эдгээр ажилд дэмжлэг үзүүлэхэд шинэ бүтээгдэхүүн бүтээж гаргах хөтөлбөр гаргах шаардлагатай болно. (Дараахь зүйлийг үзнэ үү)

Бүтээгдэхүүн бүтээж гаргах талаар хэрэгжүүлж болох хэд хэдэн чиглэлийг бид толилуулж байна. Эдгээр нь зөвлөхийн судалгааны явцад гарч ирсэн судалбал зохих чиглэл юм. Төслийн энэ үе шатанд үүнд батлагдсан хариу өгөх боломжгүй ч мэргэжлийн ур чадвартай эсвэл төслийн хүрээнд гаднаас сонгож авсан компаниуд судлах нь зүйтэй юм.

Дүгнэлт

Ашиглагдаж буй тоног төхөөрөмж нь тааруу, ашиглалт хангалтгүй, засвар үйлчилгээ сайн хийгдээгүй бөгөөд түүнийг илүү сайн ашиглахын тулд ямар бүтээгдэхүүн бүтээж гаргаж болох талаар тодорхой хэтийн зорилгогүй байна.

Гэхдээ олон улсын жишиг чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрэгцээтэй мэдлэг боловсролтой мэргэжлийн инженер-механикууд энэхүү тоног төхөөрөмжийг засаж янзлаад, засвар үйлчилгээг тогтмол хийвэл энэ тоног төхөөрөмжийг ашиглан дэлхийн чанарын стандартад хүрэх чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх бололцоотой.

Тоног төхөөрөмжийг засварлаад ашиглалтын дээд цэгт нь хүргэж болно.

Үйлдвэрлэл ба туршилт болон эрдэм шинжилгээний бүх түвшинд ур чадварыг хөгжүүлж болно.

Иймээс эдгээр хүчин чадлыг ашиглах хүндрэлтэй асуудал нь тоног төхөөрөмжөөс хамааралгүй харин менежменттэй холбоотой байна.

Буян

Тус компаний нөхцөл байдал нь Говийн нөхцөл байдлаас ялгаатай байна.

Орчин үеийн хамгийн сайн тоног төхөөрөмжтэй.

Говь компанийн тоног төхөөрөмжтэй холбоотой гарсан шүүмжлэл нь энэ компанид хамаарахгүй.

Үйл ажиллагаа явуулах түвшинд тоног төхөөрөмж ашиглах ур чадвар эсвэл ажиллах хүчний ур чадвар хангалтгүй байх зэрэг ижил төстэй зүйл гарч ирж байсан.

Хүчин чадал нь жилдээ 150 тонноор тооцоологдож байна.

Тоног төхөөрөмжийн чанарыг үндэслээд ажлын зургаан өдөр гурван ээлжээр ажиллавал жилд 200 тонноос илүү үйлдвэрлэх хүчин чадалтай болно.

Тоног төхөөрөмж ашиглах ур чадвар тааруу, чанарыг баталгаажуулах ажил тааруу, ялангуяа, самнах, цувилах үе шатанд тоног төхөөрөмж тохируулах ур чадвар хангалтгүй байгаагаас үүдэн утасны чанар муудах гол шалтгаан болдог гэж энэ судалгааг бичсэн зөвлөх үзэж байна.

Захиалга хангалтгүй буюу дээр дурьдсан хүндрэлтэй асуудлын улмаас үйлдвэрлэлийн хэмжээ доогуур байна.

Бүтээгдэхүүний нэр төрлийн хийц загварын чанар нь Говийнхоос илүү дээр ч гэсэн экспортын зах зээлийн эрэлт хэрэгцээний талаар ойлголт багатай байна.

Иймээс хүндрэлтэй асуудлуудыг тоног төхөөрөмж хангалтгүй асуудалтай холбож болохгүй юм. Эдгээр хүндрэлтэй асуудал нь менежменттэй холбоотой байна. Үйлдвэрлэлийн аргачлал, технологи илүү их хэрэгцээтэй, шаардлагатай байна.

Ээрмэл ба МНТНК

Энэ хоёр компани нь өөрсдийн тэмээний ноос боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж ноолуур ээрэх шинэ хүчин чадалтай болж зах зээлд орж ирэх гэж байна.

Эдгээр компаниуд улс орны хэмжээнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг жилд 200 тонноор нэмэгдүүлэх боломжтой.

Тоног төхөөрөмж нь шинэ биш ч чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.

Компаниудын ахлах менежерүүд нь шинэ хүчин чадлаар ажиллах ёстой олон улсын зах зээлийн талаар илүү сайн ойлгож байна. Гэхдээ эдгээр боловсон хүчин нь бүтээгдэхүүн хэрхэн үйлдвэрлэх тал дээр илүү туршлага суусан учир олон улсын маркетингийн талаар туршлага багатай. Загвар зохион бүтээгч, маркетингийн ажилтнуудын хувьд эдгээр компаний дэд бүтэц, санхүүгийн хөрөнгө нөөц хангалтгүй. Говь, Буянтай харьцуулахад тэдний бүтээгдэхүүнээ гаргах найдлага тавьж буй зах зээл зохих хэмжээнд судлагдаагүй байна.

Хүчин чадлын бусад асуудал

Олон улсын оёмол, сүлжмэл үйлдвэрлэлийн салбарын ерөнхий хандлага нь гаднаас бараа, үйлчилгээ авах нь зонхилж буй загвар төдийгүй онцгой загвар болохыг харуулж байна. Гэхдээ хувцасны үйлдвэр, хувцасны үйлдвэрлэлийн салбар нь ажиллах хүчин дээр илүү тулгуурласан ч гэсэн, капитал хөрөнгө их зарцуулдаг оёмол сүлжмэлийн салбараас илүү хурдтай хөгжиж байна.

Монгол Улсад Итали, Шотланд, Франц, Герман, АНУ зэрэг уламжлалт тансаг хэрэглээний бүтээгдэхүүн нийлүүлдэг улс орнуудын эзэмшил, менежмент, загвартай хэд хэдэн компани ажиллаж байна. Уламжлалт ба шинэ зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэгч эдгээр компаний эдийн засгийн хэрэгцээ нь үйлдвэрлэлийн зардал бага шаардах төвүүдэд байрлан хувцасны борлуулалтын чиг хандлагыг дагахад оршино.

Иймээс зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх сүлжээ, зам өөрчлөгдөж байна.

Нью-Йорк, Дюсселдорф, Милан, Лондон зэрэг хотууд болон брэнд эзэмшигчид, тодорхой чиглэлийн жижиглэн худалдаачид, гол загвар зохион бүтээх товчоод байрлаж буй хотуудад шийдвэр гаргах гол цэгүүд хэвээр байна. Бүтээгдэхүүн нийлүүлдэг газраар Хятад, Энэтхэг, Балкан, Зүүн Өмнөд Ази ба оёдлын үйлдвэрлэл хөгжиж буй бусад улс орнууд тодорч байна.

Ийм хүчин зүйлүүд Монгол Улсад нөлөөлөхгүй гэж бодох шалтгаан байхгүй.

Бид үйл ажиллагаа явуулж буй гадаадын үйлдвэрлэгчдийн өөрсдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг түүхий эдийн эх сурвалж, анхан шатны үйлдвэрлэлтэй орон руу нүүлгэх боломжийг бодолцсон. Өөрөөр хэлбэл, ээрэх, цаашилбал, илүү гүнзгий боловсруулалт хийх хүчин чадлыг Монгол Улс дахь угаах, самнах үйл ажиллагаан дээр нэмэх боломж. Ийм алхам нь дээр тоймлон харуулсан хүчин чадлыг цаашид нэмэгдүүлж тус улсын ноолуурын салбарыг хөгжүүлэх эх сурвалж болох боломжтой. (Үүнд хамрагдах компаний талаар илүү тодорхой мэдээлэл өгөх боломжгүй. Энэ нь мэдээллийн нууцыг хадгалах нөхцлийг зөрчсөн хэрэг болно. Гэхдээ гол үйлдвэрлэгч, санал гаргагчийн хувьд боломж байгааг тэмдэглэх ёстой.)

Судалгааны үр дүн эдгээр алхмыг авч үзэж буйг харуулах болно.

Шинээр үүсэн хөгжиж буй ноолуур, бусад хольцтой ноолуурын зах зээлийн хэрэгцээ нь эдгээр хүчин чадал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бий болгох хэрэгцээг илтгэн харуулах болно.

Ээрэх хүчин чадлын боломж, потенциал

- ❖ Нөхцөл: хүчин чадал буюу тоног төхөөрөмж сайн, санхүүгийн хүндрэлтэй асуудал байхгүй, техникийн ажилтнууд зохих түвшинд бэлтгэгдсэн, засвар, үйлчилгээ хангалттай хийгдсэн.
- ❖ Бий болгож болох хүчин чадлын талаарх зөвлөхүүдийн саналыг тусгаж тэдгээр хүчин чадлыг харуулав.

Компани	Хүчин чадал (тонн/жил)
Говь	300
Буян	200
Ээрмэл	70
МНТНК	150
Санширо	75
Нийт	795

Монголын ноолуурын салбарын нийт ээрэх хүчин чадлын боломж, потенциал нь жилд 795 орчим тонн бололтой. Монгол Улс жилд 3000 орчим тонн бохир ноолуур үйлдвэрлэж байна. Хэрэв монголын ноолуур самнадаг үйлдвэрүүд бүх ноолуурыг боловсруулах боломжтой бол тус улс нь одоогийн ээрэх өөрийн хүчин чадлаас 2 дахин илүү буюу жилд 1500 тонн ноолуур боловсруулах боломжтой. Нийлүүлэлтийн тухайд цаашид ээрэх хүчин чадлыг холих, будах илүү хүчин чадалтай хослуулах боломж байна.

Г. Монголын ноолуурын салбарын нөхцөл байдалтай уялдуулан ээрэх хүчин чадлыг дээшлүүлэх боломж

Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдийн ээрсэн бүтээгдэхүүнээ санал болгож буй байдлыг судалж үзлээ. Одоогоор үйлдвэрлэж байгаа ээрмэл нь хэрэглээний зүйл төдий, ямар нэгэн онцгойрох, ялгагдах шинж байхгүй, өөрсдийн хэрэгцээнд эсвэл хэн нэгний захиалгаар (өнгө, эрчлээ, дугаар, финишинг) хийгддэг байна. Өөрөөр хэлбэл, бараа бүтээгдэхүүний ялгарал байхгүй. Бид эдгээр

болно. Ноолуурын технологи нь бүтээгдэхүүний чанарыг бууруулахгүй буюу нэмэгдүүлэхийн сацуу илүү хурдтай үйлдвэрлэл явуулахыг эрмэлздэг ихэнх сүлжмэлийн технологиос ялгаатай. Бүтээгдэхүүний чанарт сайн нөлөө үзүүлэхгүй тул өндөр хурдаар утас ээрэх нь эрхэм зорилго биш юм. Тохирсон хурдаар чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилго нэн түрүүнд тавигдана.

Сайн бизнес төлөвлөгөө байхад орчин үеийн үйлдвэр нь чанар, ашиглалтын хугацаа, тохирсон хурдтай өсөлтийг хангах асуудалд хариу өгнө. Энэ нь мөн шинэ зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргахын тулд бүтээгдэхүүн бүтээж гаргах илүү олон сонголт хийх боломж олгоно.

Ээрмэлийн үйлдвэр байгуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа/тоног төхөөрөмжийн жагсаалт

Эдүгээ Монгол Улсад ноосон ээрмэл бөгөөд хагас нарийн зүүн ээрмэл үйлдвэрлэх хоёр төрлийн тоног төхөөрөмж байна. Ноос ээрэх тоног төхөөрөмжийг гол төлөв 8, 10 гейжийн хувцас сүлжих, твид даавуу шиг даавуу нэхэхэд ашиглаж байна. Нарийн зүүн ээрмэл нь илүү нарийн гейжтэй сүлжмэл үйлдвэрлэх болон нарийн нэхмэл хийхэд зориулагдаж байна. Чанартай хувцасны зах зээл дээр эдгээр нь өсөлтийг урт хугацаанд хангах боломжийг бүрдүүлж байна. Анхны бэлтгэл ажил нь ижил төстэй учраас бид эдгээр эрэлт хэрэгцээг та бүгдийн анхааралд толилуульж байна.

Европын компаниудын өөрсдийн үйлдвэрлэлээ үйлдвэрлэлийн өртөг багатай газар, эцсийн боловсруулалт хийдэг үйлдвэрлэл рүү оёмол деталь буюу хэсгүүдийг хооронд нь нийлүүлж оёх болон илүү гүнзгий боловсруулалт хийдэг эцсийн боловсруулагчдад ойртуулан байрлуулах туршлагаас харахад, тэд цоо шинэ үйлдвэр барьж, өөрсдийн үйлдвэрлэлийн хэв маяг, орчинд боловсон хүчин аваачиж байна. Өөрөөр хэлбэл, байгаа үйлдвэрийг өөрийнх нь хуучирсан арга барилаар ажилладаг хоцрогдсон боловсон хүчинтэй нь хамт худалдан авахын оронд шинэ залуу боловсон хүчин бүрдүүлж, тэднийг дэлхийн жишиг арга барилд сургаж авч байна.

Иймээс шинэ үйлдвэрлэл эхлэхэд тавигдах эхний шаардлага нь зориулалтын барилга байгууламжтай болох ба үүгээр аль болох ажлын урсгалд бага тасалдал гарах, гар ажиллагаа хамгийн бага шаардах боломжийг бүрдүүлэх юм.

Үйлдвэрлэлийн үе шатууд:

1. Угаах
2. Самнах
3. Бусад нарийн ширхэгтэй холих
4. Задгайгаар буюу бөөнөөр нь будах
5. Будаг найруулах
6. Кардинг (цувилах)
7. Хагас нарийн зүүн ээрмэл хийх зориулалтаар самнах
8. Ээрэх (цагираган).
9. Ээрэх (мөлхөө буюу хэвтээ). Энэ 2 нь чанар ба бүтээгдэхүүний шаардлагатай хольцоос хамааран бие биеэ орлодог.
10. Ээрэх-хагас нарийн системээр хийх
11. Утсаар будах
12. Давхарлах
13. Ороох, эрчлэх

Хүчин чадал

Үйлдвэрлэлд орж байгаа түүхий эдийн үзүүлэлтүүд болон үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл өөрчлөгддөг тул үйлдвэрлэлийн үе шат бүрт хүчин чадлыг тэнцвэржүүлэх нь бэрхшээлтэй. Гүнзгий боловсруулалт хийдэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хувьд энэ нь гол санаа зовоосон асуудал болох нь нотлогдсон бөгөөд олон улсын туршлага нь энэхүү үйлдвэрлэлийг амжилттай явуулах нь бэрхшээлтэй болохыг харуулж байна. Үйлдвэрлэлийн шат дамжлага бүрийг зах зээлийн эрэлт хэрэгцээг хангасан бүтээгдэхүүн гаргаж борлуулах чадвартай, түүхий эдээ бие даан бэлтгэдэг, ашиг орлого олдог нэгж болгох нь гүнзгий боловсруулалт хийдэг үйлдвэр оновчтой ажиллуулах хамгийн шилдэг арга барилаар тооцогдож байна.

Урьд нь тус төсөлд зориулан боловсруулж байсан үйлдвэрийн загвар нь жилд 100 тонн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай байх саналыг дэвшүүлж байсан. Үр дүнг бүрэн хэмжээнд нарийн тооцох боломжтой ч энэхүү загвар үйлдвэрийн шат дамжлага бүрийн ажлын үр дүнг тооцох аргачлал нь ажлын сайхан эхлэл юм. Энэ загварын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зарим хэсэг нь үйлдвэрлэлийн явцаас халин гарсан байгаа боловч ёрөнхий цар хүрээ, зардлын хэмжээнээс хэтрээгүй байна. Тухайлбал, эдүгээ ашиглагдаж буй хамгийн сайн угаах шат дамжлага цагт нэг тонн угаах хүчин чадалтай Шинэ Зеландад үйлдвэрлэгдсэн бөгөөд, жилд 200 тонн (түүхий эдийн орцоор) хүчин чадалтай загвар үйлдвэрт энэ угаах хүчин чадал нь ахадсан байна. Гэхдээ жижиг угаахын зардал нь хамгийн сайн тохирох угаахын зардалтай ойролцоо байдаг. Иймээс тухайн компанийг үйлдвэрлэлийн бүх үе шатанд асуудлыг шийдэж ажиллахыг шаардах энэ бизнесийн загвар нь өөрийн зорилгыг хангахын тулд шат дамжлагыг зохистой ашиглах, бусад үйлдвэрлэгчдэд комисс төлөх боломжтой, комисс нь тохирсон байх ёстой.

Шаардагдах хөрөнгийн хэмжээ нь үйлдвэрлэлийн хэмжээнд тохирсон тоног төхөөрөмжийн үнээс хамаарна.

- Mercury Corps төсөлд зориулан боловсруулсан энэхүү саналын төсөл нь 5 жилийн хугацаанд жилд 25 тонноос эхэлж цаашид 75 тонн хүртэл ээрмэл үйлдвэрлэх үйлдвэрт ойролцоогоор 2.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт ба эргэлтийн хөрөнгө шаардагдана. Энэ зардалд барилга байгууламж багтахгүй бөгөөд иймээс ээрэх тоног төхөөрөмжөө эдүгээ ашиглагдаж буй үйлдвэр буюу хэрэглэгчийн үйлдвэрт суурилуулна гэж үзэж байна. Ийм санал болгож буй үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт удаан, хэмжээ нь хэтэрхий бага бөгөөд зарцуулах хөрөнгийн хэмжээ бага байж эргэлтийн хөрөнгийн зарим хэсгийг өөрийн хүчээр бий болгоно гэж үзэж байгаа нь хүндрэлтэй асуудал болж байна. Гэхдээ тэнцүү байдлаар өрнөх загварын хувьд энэ нь үндэслэлтэй байна.
- Ашиглаж байсан ба засвар үйлчилгээ хийгдсэн тоног төхөөрөмжийг ашиглан жилд 100 орчим тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай шинэ үйлдвэр нь барилга байгууламжийг оролцуулан 4.5 орчим ам.доллар болно.
- Өөрийн угаах, самнах шат дамжлагатай эдүгээ ашиглагдаж буй аль нэг үйлдвэртэй адил том үйлдвэр байгуулахад 15-аас дээш сая ам.доллар зарцуулагдана. Гэхдээ энэхүү үйлдвэр нь тус салбарыг урьдчилсан тооцоолсон хэмжээнд өргөжүүлж чадах орчин үеийн нийлүүлэгч үйлдвэр болж чадна.
- Ийм үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийн дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулж болно. Гэхдээ үүний гол урьдчилсан нөхцөл нь зах

зээлийн үнэлгээ хийх, хэрэгжих боломжтой бизнесийн загвар боловсруулах явдал юм.

Е. Ээрмэлийн салбарын хүчин чадлыг нэмэгдүүлж болох арга зам

Е.1. Одоогийн хүчин чадлыг нээлттэй болгох

- Говийг энэ тайланд зөвлөмж болгосон загварын дагуу худалдан авах хөрөнгө оруулагчид (хөрөнгө оруулагчдад) худалдах.Төрийн оролцоотой Говь компани шиг аж ахуйн нэгж, компаниуд зах зээлийн тогтолцоонд тодорхой гажуудал үүсгэдэг гэдэг нь олон нийтэд ойлгомжтой зүйл билээ.
- Буян компанийн хүчин чадал, үйлдвэрийг зах зээлтэй ойртуулах арга замыг судлах.
- Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчдэд маркетингийн түнш/арга/гарцыг зах зээлд байршуулахад нь туслах. Энэ ажил нь томоохон үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрийн ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд өсөн нэмэгдэж буй хүчин чадлаа дээшлүүлж чадах тийм үйлдвэрийг бүрэн хэмжээнд ашиглахад тус болно.

Е.2. Шинэ хөрөнгө оруулалт

- Говьд зах зээлээр зохицуулагдах мэдрэмж сайтай бизнесийн загвар байхгүй нөхцөлд, мөн Буян үйлдвэр тоног төхөөрөмжөө хүчин чадлын хамгийн доод хэмжээгээр ажиллуулах тохиолдолд ээрмэлийн салбарт наад зах нь дахин нэг томоохон үйлдвэрлэгч орж ирэх орон зай байна. Гэхдээ энэ зах зээлд Буян бүрэн хүчин чадлаараа гарах нь илүү үр дүнтэй байж болох юм.
- Ийм хүндрэлтэй асуудал нь Патагон гэх мэт тодорхой зах зээл авчрах брэнд эзэмшигчдийн гадаад улсад байрлаж байгаа нийлүүлэлт хангамжийн төвүүдэд хамаарахгүй юм.

Жилд 75 тонн үйлдвэрлэх хүчин чадалтай ээрмэлийн үйлдвэрийн олж болох орлого.
Зарцуулах хөрөнгийн зардал 4.5 сая ам.доллар

(2005 оны 4-р сарын самнасан ноолуур, утасны дундаж үнийг харгалзаж тооцов)

Үзүүлэлт	Сая ам.доллар
Борлуулалтын орлого	8.50
Түүхий эд	4.75
Нийт орлого	3.75
Үйл ажиллагааны зардал	1.25
Санхүүгийн зардлын өмнөх ашиг	2.50
Санхүүгийн зардал	1.00
Цэвэр ашиг	1.50

Е.3. Монгол Улсын Засгийн газрын бодлогын гол чиглэл ба тус салбарын холбоод:

Эдгээр үйл ажиллагаа дараахь үр нөлөөг үзүүлэх ёстой. Үүнд:

- Наад зах нь ээрэх үе шат хүртэл, боломжтой бол эцсийн сүлжмэл хувцас үйлдвэрлэх үе шат, будсан, эцсийн боловсруулалт хийгдэхүйц нэхмэл

үйлдвэрлэх үе шат хүртэл тус салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог хөхүүлэн дэмжих орчинг бүрдүүлэх. Үүнд дараахь зүйл багтана.

- Орчин үеийн үйлдвэрт оруулах гадаадын шууд хөрөнгө оруулалт
 - Ашиглаж байсан тоног төхөөрөмжтэй шинэ үйлдвэрт оруулах гадаадын шууд хөрөнгө оруулалт
 - Хамтарсан үйлдвэр
 - Брэнд эзэмшигчдийн зах зээлд гаргадаг барааг дотоодын үйлдвэрээр үйлдвэрлүүлэх урт хугацааны гэрээ
 - Концессийн гэрээ хийх
- Үүгээр дараахь зорилтууд хангагдана. Үүнд:
 - Зах зээл
 - Зах зээлийг хөтлөх арга
 - Менежмент
 - Технологи
 - Ур чадвар
 - Хөрөнгө оруулалтын капитал
 - Гадаадад өсгөж гадаадын мөнгөн тэмдэгтээр хэмжигдэх эргэлтийн хөрөнгө
 - Зорилгодоо үнэнч байх
 - Бодлогын хоёр дахь зорилт нь боловсруулаагүй түүхий эдийн экспортыг дэмжихгүй байх, зах зээлийн өөрчлөлийн дагуу уян хатан байх асуудал илүү чухал болох үе шат хүртэл нэмэгдсэн өртгийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжихэд оршино. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн буюу хувцас үйлдвэрлэх үе шат, наад зах нь утас ээрэх үе шатын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжинэ гэсэн үг юм. Үйлдвэрлэх зардал нь өсөн нэмэгдэх тул зөвхөн самнасан ноолуурын экспорт нь Итали, ИБУИНВУ ба ЕХ-ны бусад улс орнуудын үйлдвэрлэгчдийн сонирхлыг улам бүр бага татах ёстой. Гэхдээ зах зээлд ойр байх, хурдтай хөгжиж буй хувцасны загварын зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэх хэрэгцээ шаардлага нь үйл ажиллагааны хувьд жигдэрсэн үйлдвэрлэгчдэд зах зээлд илүү ойр байршилтай газруудад бүтээгдэхүүн үйлдвэрлэх түүхий эд олж авахад тус болно гэдгийг ойлгох ёстой. Энэ бол чухамдаа Турк, Зүүн Өмнөд Европ – Балканы хойгийн улс орнууд, Румыныг хэлж байгаа хэрэг юм. Самнасан ноолуурын экспортыг хориглох буюу татварын дарамт үзүүлэх нь буруу юм. Ийм ажлыг дэмжих бодлого боловсруулах нь зүйтэй.

Ийм бодлогын логик дүгнэлт нь Монгол орныг дэлхийн ноос ноолуур боловсруулдаг болон борлуулдаг салбарын гол төлөөлөгч нарт маш идэвхтэй сурталчилж тус улсад шууд хөрөнгө оруулалтыг хийх цогц хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагаа явуулж буй гадны үйлдвэрлэгчидтэй хамтран концессийн гэрээ эсвэл Бизнесийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах, илүү гүнзгий боловсруулалт хийх үйл ажиллагааг дэмжин хөхүүлэх (төрөл бүрийн өнгөтэй ээрмэл үйлдвэрлэхийг), одоогийн улсын эзэмшилтэй үйлдвэрийг хувийн хэвшилд шилжүүлэх зэрэгт оршино.

Хагас нарийн болон ноосон ээрмэл

1. Энэ тайланг бичиж байх явцад тус улсад ноос, самнасан ноос боловсруулж нарийн утас үйлдвэрлэдэг зөвхөн нэг газар байсан. Үүнийг Говь корпораци эзэмшдэг бөгөөд энэ нь Говийн хүндрэлтэй асуудлуудтай байгаа бусад дамжлагаас хамгийн их бэрхшээл учирч байгаа хэсэг билээ.
 - Захиалга хомс учраас хүчин чадал нь дутуу ашиглагддаг

- Тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ муу хийсэн
 - Удирдан чиглүүлэх, тоног төхөөрөмж засварлах, ажиллуулах ур чадвар хангалтгүй
 - Шинэ бүтээгдэхүүн бүтээж гаргах хэрэгцээ шаардлага дутуу
 - Бүтээгдэхүүн бүтээж гаргах ур чадвар хангалтгүй
 - Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний зохион бүтээж гаргах ур чадвар хангалтгүй
2. Энэхүү технологийг сайтар ашиглан шинээр бүтээж үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрлүүд нь бүрэн хэмжээний хэв загвар (FF)-тай сүлжмэл эдлэл сүлжих, үүнтэй ижил төрлийн нарийн сүлжмэл эсгэж оёсон (C&S) хувцас үйлдвэрлэх, биеийн тамирын хувцас ба гадуур хувцсанд зориулж нэхмэл оёмол даавуу үйлдвэрлэх зорилготой. Энэ технологи нь дээрх бүх хэрэглээнд зориулсан хольцтой бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүү тохиромжтой. Эрэгтэй, эмэгтэй хослол үйлдвэрлэх хольцтой даавуу үйлдвэрлэхэд энэхүү технологийг ашиглах нь дорно зүгийн зарим үйлдвэрлэгчдийн зорилго болж ирсэн. Бид үүнийг барууны хөгжсөн зах зээлд тохиромжтой гэж үзэхгүй бөгөөд оёдлын үйлдвэрийн салбарт нэвтэрч буй зарим даавууг тодорхой бус хольцтой ба гарал үүсэл нь тодорхой бус материал гэж үздэг юм.
 3. Гол зах зээлүүд дээр нарийн гэйжтэй сүлжмэлийг үйлдвэрлэгдэж санал болгож байгаа бүтээгдэхүүний нэр төрөлд илүү их хэмжээгээр оруулж байгаа нь тодорхой болж байна. Энэ үзэгдэл загвар моодонд орж байгаа олон давхартай биенд эвтэйхэн, жилийн улирлуудын цаг агаарын онцлогт гоц тохирсон хувцасны үйлдвэрлэлийн өсөлттэй хамт явж байна. Харин арай бүдүүн гэйжтэй сүлжмэл хувцасны эрэлт хэрэгцээ багасах төлөвтэй байна.
 4. Урлаг, биеийн тамирын хувцасны зах зээлд бүтээгдэхүүн гаргадаг үйлдвэрлэгчид нь эдгээр бүтээгдэхүүнийг тэдний тавьж байгаа шаардлагад нийцэх бололцоотой гэж үзэх болсон. Шаардлага гэдэг нь жирийн хувцаснаас илүү, тухайлбал, дулаан хадгалдаг, бороо нэвтэрдэггүй, сунаж агшдаг, толбо, сэв суудаггүй гэх мэт онцлог шинжийг хэлнэ.
 5. Хятадын салбарын гол оролцогч болох Шандон Дашин ноолуурын нэхмэлийн компани нь ийм 100 хувийн ноолууран, торго, урт ширхэгтэй хөвөн, ноосны хольцтой ээрмэл утсыг санал болгож байна. Зөөлөн торгомсог ноос, торго ба хөвөнгийн хольцтой гурван төрлийн ноолууран утас.
 6. Иймээс ашиглаж буй үйлдвэр, тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, хувцасны загвартай уялдан бүтээгдэхүүний нэр төрөлд эдгээр зүйлийг нэмж оруулах хэрэгцээ шаардлага гарсан тул ээрмэлийн үйлдвэр шинээр байгуулах нь сонирхолтой байна.
 7. Монголын урт ширхэгтэй ноолуур нь ялангуяа ийм төрлийн ээрэх үйл ажиллагаанд тохиромжтой бөгөөд цагаан ба цайвар өнгөтэй ноолуурын хэмжээ бага байдаг нь хувцасны зориулалттай оёмол даавууны бизнест хүндрэлтэй асуудал үүсэхгүй. Энэ асуудлыг хольцтой топс, эсвэл будсан утас, эсвэл утсаар будах ээрмэл худалдан авч үйлдвэрлэлээ явуулахад шийдэж болно.

ХАВСРАЛТ Б: НООЛУУРЫН ҮЙЛДВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

ХАВСРАЛТ Б: НОЛУУРЫН ҮЙЛДВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

Зээл: ноолуурын нэмэгдсэн өртгийн зардлын гол хүчин зүйл

Санхүүгийн асуудал нь нэмэгдсэн өртгийн хамт ноолуурын үйлдвэрийн өртөг зардлын гол хүчин зүйлийн нэг билээ. Малчид, ченжүүд, наймаачид, ноолуур угаах, самнах, ээрэх, нэхэх үйлдвэрээс авахуулаад бэлэн хувцас экспортлогчид бүгдэд нь ихээхэн хэмжээний эргэлтийн хөрөнгийн санхүүжилт хэрэгтэй байдаг. Ихэнх үйлдвэрлэгчдэд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай байхын тулд үйлдвэр болон техник тоног төхөөрөмжөө сайжруулахад шаардагдах урт хугацааны санхүүжилт хэрэгцээтэй байдаг. Монголд арилжааны зээл олгогчдоос зээл авах нь үнэтэй тусдаг бөгөөд энэ нь бизнесийн үйл ажиллагааны зардлын ихэнх хувийг эзлэдэг. Зээлийн өртөг нь ноолуурын салбараас олон оролцогчдыг шахан зайлуулж буй бэрхшээлийн нэг бөгөөд зөвхөн өртөг зардлын хувьд авч үзвэл үйлдвэрлэгчдийг өрсөлдөх чадваргүй болоход хүргэж байна.

Түүхийн эдийн зардал, (бохир ноолуур), ноолуурын үйлдвэрийн нэмэгдсэн өртгийн зардлын хамгийн том бүрэлдэхүүн хэсэг билээ. Иймд үйлдвэрлэгчдэд учирч буй хамгийн том бэрхшээл бол малчид болон "ченжүүдээс" бохир ноолуурыг худалдан авахад шаардагдах эргэлтийн хөрөнгөтэй болох явдал юм. Шаардагдаж буй эргэлтийн хөрөнгийн хэмжээг дараахь байдлаар үлгэрчлэн гаргав. Үйлдвэр, тоног төхөөрөмжид зориулагдсан 900,000 ам. долларын өртгөөр байгуулагдсан ноолуур угаах, самнах үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулахад 9,000,000 ам. доллартай тэнцэх бохир ноолуур шаардагдах болно. (Үйлдвэрийн хүчин чадал 360.000 кг, нэг кг бохир ноолуурыг 25 ам. доллараар тооцов). Сарын 2.5% хүүтэй 9,000,000 ам. долларт тэнцэх түүхийн эдийн нөөцийн жилийн хүүгийн зардал 1,350,000 ам. доллар болно. (Жилийн нөөцийн дундаж зардал 4,500,000 ам. доллар байхаар тооцоход энэ нь анх худалдаж авсан үнийн тал юм.) Нэг сая ам. долларын нийт хөрөнгө оруулалтад түүхийн эдийн жилийн хүү 1.35 сая ам.доллар болж байна. Үйлдвэрлэгчид бүх зардлыг өөрсдөө хариуцахгүйн тулд заримдаа нийлүүлэгчдэд төлбөр хийх хугацааг сунгаж, худалдан авагчдаас төлбөрийг урьдчилж авч байгаа хэдий ч түүхий эд худалдаж авах асуудал санхүүгийн гол саад тогтор болсоор байна.

Хүүгийн хувь хэмжээ. Одоогийн зах зээлийн ханшаар Монголд нэг жилийн зээлийн хүү сард төгрөгөөр 1.8- 4% хэлбэлзэж байхад ам. доллараар 1.33- 1.6 % байна. (Хүснэгт 1-ээс үзнэ үү). Хатуу валютаар баталгаатай худалдан авах худалдан авагчидтай экспортлогчид валютын зээлийг бага хүүтэй авах боломжтой байхад жижиг үйлдвэрлэгчид зөвхөн төгрөгөөр өндөр хүүтэй зээл авч байна. Малчид, ченжүү болон наймаачид ихэвчлэн 3- 6 сарын хугацаатай сарын 2.5 - 4% хүүтэй зээл авдаг. Гэтэл үүний эсрэгээр монголын ноолуур үйлдвэрлэгчдийн гол өрсөлдөгч болох хятадын үйлдвэрлэгчид эх орондоо сарын 0.4- 0.6% хүүтэй зээл авах боломжтой. Ноолуурын үйлдвэрт шаардагдаж буй их хэмжээний эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ болон зээлийн хүүгийн зөрүү нь хятадуудад маш их давуу талыг олгож байна. Энэ давуу талын улмаас хятадууд монголын түүхийн эдийг өөрсөдөө хэрэгтэй хэмжээгээр өндөр үнээр худалдан авах боломжтой байна. Хятадууд Монголын ноолуурын түүхий эдийн гол худалдан авагчид тул зах зээлийн үнийг тэд тогтоосоор байна (хятадууд нийт түүхий эдийн 50 орчим хувийг худалдан авч байна гэсэн мэдээ бий). Иймд Монголчууд хятадуудаас 3-10 дахин илүү төлөх хэрэгтэй болдог тул монголчууд тогтоосон үнийг дагахын тулд маш хатуу шахалтанд орсоор байна.

Урт хугацааны санхүүжилтийн хомсдол. Зээлийн өндөр хүүгээс гадна дунд болон урт хугацааны зээл авах боломжгүйгээс үйлдвэрлэгчид үйлдвэрээ өргөтгөх, тоног төхөөрөмжөө шинэчлэхийн тулд маш их бэрхшээлтэй тулгарч байна. Одоогийн байдлаар нэг жилээс илүү урт хугацаагаар зээл авах боломжгүй. Цөөхөн банк нэг жилээс илүү хугацаагаар зээл олгоно гэх боловч найдвартай хэдхэн экспортлогч компанид доллараар зээл олгох сонирхолтой байна. Урт хугацааны зээл олгох сонирхол байгаа боловч урт хугацааны эрсдлийн менежментээр мэргэшсэн боловсон хүчин байхгүй байгаа нь ийм зээл олгох боломжгүй байгаагийн гол шалтгаан юм гэж хэд хэдэн банкны төлөөлөгчид ярьж байв.

Барьцаат зээлийн нөхцөл. Зээлдэгчдэд барьцаат зээлийн нөхцөл ямар байгаа нь мөн чухал байдаг. Үйлдвэрлэгчдэд ихэнх зээл олгогчид банкны баталгаа болгон барьцааны 30-70% -тай тэнцэх банк зөвхөн өөрөө үнэлсэн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрдөг. Малчид болон наймаачид өөрсдийн мал, тээврийн хэрэгсэл, эд хогшил болон орон сууцыг зээлийн хэмжээнд тохируулан барьцаалж болно. Ийм их хэмжээний барьцаа авах үндэслэлээ банкныхан одоогийн хуулинд гэрээний хууль байдаггүйгээр тайлбарлаж байна. Зээлдэгч нь төлбөрийн чадвараа алдах тохиолдолд шүүхээр өрийг барагдуулж өмчийг хураан авах маш хэцүү байдаг. Иймд банкууд зөвхөн барьцаанд авсан хөрөнгийн тодорхой хэмжээг өрөнд авах боломжтой гэж таамаглаж байна.

Үүнээс гадна ихэнх банкууд муу зээлийн өндөр хувийг төлөх болдог тул банкныхны хувьд энэ нь их хэмжээний барьцаа авах хамгийн бодит үндэслэл болдог байна. Гадаадын хөрөнгө оруулалттай эсвэл менежментийн оролцоотой цөөхөн том банк барьцаанд бараа материал, бэлэн мөнгө, экспортын гэрээ болон аккредитив тавихыг хамгийн найдвартай цөөхөн үйлчлүүлэгчдээ зөвшөөрч эхэлжээ. Мөнгөн гүйлгээг тооцож зээл олгохгүй (барьцаа авахаас илүү цаашид олж болох хөрөнгийн гүйлгээнд тулгуурласан зээл) байгаа явдлыг ихэнх банкууд мөнгөн гүйлгээнд тулгуурлан зээл олгох талаар мөн эрсдлийн менежментийн талаар туршлага дутмаг буйгаар тайлбарлаж байв.

Товчдоо, богино хугацааны өндөр хүүтэй зээл, эргэлтийн хөрөнгийн зээлийн богино хугацаа, урт хугацааны санхүүжилтийн хомс байдал мөн барьцаат зээлийн хатуу нөхцөл зэрэг нь бизнесүүдэд зээл авах боломжийг хязгаарлаж зардлыг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Монгол дахь зээлийн өндөр өртөг дотоодын бүх үйлдвэрийн өрсөлдөх чадварыг бууруулахад нөлөөлж, дотоодын хэрэглээний импорт болон экспортын үйлдвэрлэлийн эсрэг үйлчилж байна. Хүснэгт 1-д хэдэн томоохон зээл олгогчдоос авсан баримтыг үндэслэн зээлийн хүүгийн хувь хэмжээ, барьцаат зээлийн нөхцөл болон үйлчлүүлэгчдийн талаарх мэдээллийг харуулав.

Банкны нэр	Үйлчлүүлэгчид	Сарын хүү 3 сараас -1 жил	5- 7 жил	Барьцаат зээлийн нөхцөл
ХХБ	Хувцас үйлдвэрлэгчид, ноос самнах үйлдвэр	1.33- 1.6 % (ам. доллар)		Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, экспортын гэрээ, аккредитив, ХХБ дахь хадгаламж
Анод	ЖДҮ	1.5% (ам. доллар) 2.3%	үгүй	Үл хөдлөх хөрөнгө, аливаа хөрөнгийн 80%

		(төгрөг)		хүртэл үнэтэй тэнцэх зээл
Голомт	ЖДҮ	1.2 – 1.5% (ам.доллар) 1.8 -2.4% (төгрөг)	Богино хугацааны зээлийн нөхцөлтэй адил	Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, хадгаламж, аккредитив, аливаа хөрөнгийн үнийн 70%-тай үнэтэй тэнцэх зээл
ХААН	Малчид, наймаачид, ноос угаах үйлдвэр	Малчдад 6 сарын хугацаатай 3-4% Наймаачдад 3 сарын хугацаатай 2.5- 4%	5 жилийн хугацаанд богино хугацааны зээлийн нөхцлийн адил	Мал, унаа тээвэр, орон сууц, аливаа хөрөнгийн үнийн 75 хүртэлх хувьтай тэнцэх зээл
ХАС	Малчид, наймаачид	2.5- 3.5% эсвэл 1.5% баталгааны хамт	Байхгүй	Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө: Аливаа хөрөнгийн үнийн 50-70%-тай тэнцэх зээл

Зээлийн хүү өндөр, богино хугацаатай, барьцаат зээлийн нөхцөл хатуу байгаагийн шалтгаан

Монголд зээлийн зардал өндөр байгаад нөлөөлж буй олон хүчин зүйлсийн талаар уулзсан банкир, эдийн засагчид санал бодлоо илэрхийлж байв. Жишээлбэл, банкууд нэг жилийн хадгаламжинд 15 хувийн хүүг хадгаламж эзэмшигчдэд төлдөг байна. Жилийн инфляц 10 хувь байгаагаас бодит хүү нь 5 хувьтай тэнцдэг. Хадгаламжийн ийм хүүг иргэдэд "гудсан доорх" мөнгөө банкинд хадгалуулах итгэлийг төрүүлэх үүднээс тогтоосон гэж зарим хүмүүс тайлбарлаж байв. Зээлийн хэрэгцээг санхүүжүүлэх, хэвийн бус зээлийн нөөцөд шаардагдах 40 хувийг нөхөх мөн хангалттай хэмжээний хадгаламжтай байхын тулд банкууд нэлээд ширүүн өрсөлдөх хэрэгтэй болдог гэж банкныхан ярьж байлаа. (Албан ёсны баримтаар банкны салбарын зээлийн 10 хувь нь муу зээл бөгөөд бодит байдал дээр олон ажиглагчдын ажигласнаар энэ хэмжээ 20 хувь хүрдэг гэж таамаглаж байв). Үүнээс гадна банкнуудын бэлэн мөнгөний нөөцийн хамгийн бэрхшээлтэй асуудал Монголын Засгийн газрын зээл авах асуудал юм. МЗГ хамгийн хэцүү зээлдэгч, учир нь Засгийн газрын бондыг хямдаар худалддаг тул иргэд эрсдлийг бага гэж үзэн бондыг хямд хүүтэйгээр худалдаж авсанаар МЗГ дотоодын зээл олгогчдын өрсөлдөгч болдог.

Хадгаламж болон зээлийн хүүгийн 8-25 хувийн зөрүүг банкны өртөг зардал болон зээлдэгч компаний эрсдэлд тооцдог. Монголын банкны салбар нь харьцангуй залуу, өсч буй салбар бөгөөд ерөнхийдээ тогтолцоо нь сул, хүний нөөцийн хангамж хангалттай бус байгаа нь үр дүн муутай менежментийг бий болгож үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Үүнээс гадна аж ахуйн нэгж,

байгууллагын татвар өндөр байгаа нь банкуудыг цэвэр ашгаа нэмэгдүүлэхийн тулд зээлийн хүүг өндөр байлгахад хүргэдэг.

Компанийн эрсдлийн хувьд төлбөрийн чадваргүй болох эрсдэлд хэд хэдэн зүйл нөлөөлж байна гэж банкныхан үзэж байлаа. Үүнд магадгүй хамгийн сүүлийн баримт болох дотоодын ноолуурын салбарын зээлийн асуудал нөлөөлсөн байж болох юм. 2001 онд дэлхийн зах зээл дээр ноолуурын үнэ буурахад хэд хэдэн компаниуд өрөө төлж чадахгүйд хүрсэн байна. Эдгээр өр нь одоо хүртэл банкнуудын мэдээнд муу зээлэнд бүртгэгдсэн хэвээр байна. Ноолуурын үнэд дэлхийн зах зээлийн үнэ нөлөөлөх эрсдлээс гадна дэлхийн загварын стандартад нийцэх бүтээгдэхүүнийг Монголын ноолуурын салбарын цөөн үйлдвэрлэгчид үйлдвэрлэдэг бөгөөд маркетингийн туршлага дутаж байгаагаас олон улсын зах зээлд монголын ноолуур өрсөлдөх арай болоогүй гэдгийг банкныхан ойлгож байна. Эдгээр эрсдэл нь ноолуурын салбарын онцлог эрсдлүүд юм. Бусад нь монголын байгууллагуудын зээлийн ерөнхий асуудалд илүү хамааралтай юм.

Байгууллагуудад зээл авахад тулгарч буй гол бэрхшээл шаардагдах түвшинд гаргаагүй санхүүгийн тооцоо, бизнес төлөвлөгөө бөгөөд санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн олон улсын стандартын (НББСТОУС) дагуу хийгддэггүй явдал юм. Санхүүгийн мэдээ баталгаатай бус байгаан улмаас зээлийн анализыг хийх хүндрэлтэй байдаг бөгөөд мөнгөн гүйлгээг үндэслэсэн зээлийн судалгааг хийх бараг боломжгүй байна. Банкныхны ярьснаар монголын компаниуд худалдааны санхүүгийн баталгаат хэлбэр болох аккредитивыг ашиглаж хэвшээгүй учир шууд шилжүүлэгт илүү найдаж төлбөрийг шилжүүлдгээс зарим компаниуд мөнгөө авч чадахгүйд хүрдэг байна. Эрсдлийн бас нэгэн хүчин зүйл бол зээлдэгчид төлбөрийн чадваргүй болох нөхцөлд хуулийн арга хэмжээ авах заалт байхгүйтэй холбоотой. Шүүх ерөнхийдээ барьцаалагдсан хөрөнгийг банкинд шилжүүлэх банкны эрхийг хамгаалдаггүйгээс гадна хэргийг шүүхээр шийдвэрлүүлж байх хугацаанд зээлийн хүүгийн тооцоог зогсоодог байна.

Эцсийн дүнд тухайн үеийн зээлийн хүүг зах зээл тодорхойлдог тул хүүгийн хэмжээ хэдий өндөр байсан ч энэ нь тохиромжтой бус харагдахгүй байна. Хэдий тийм ч зарим зээлдэгчдийн хувьд зээлийн өндөр өртөг зардлыг өөрчлөхөд нөлөөлөх хэд хэдэн боломж бий.

Бага зардалтай зээлийн эх үүсвэрүүд

Дэлхийн банк – 2005 оны 6 дугаар сараас эхлэн Дэлхийн банк дунд үйлдвэрлэгчдийн хөгжилд зориулан хоёр үе шаттайгаар 7-10 сая ам. долларын хэмжээтэй Хувийн секторын хөгжлийн зээлийг Засгийн газраар дамжуулан олгох гэж байна. Урт хугацааны зээлийн дээд хэмжээ 500,000 ам. доллар байх бөгөөд хүүгийн хэмжээг ХХБ, Голомт, Зоос болон Монгол Шуудан банкттай тохиролцон тогтоох болно.

KFW- Германы хөгжлийн банк нь Монголын Засгийн газартай хоёр талын гэрээ байгуулж, уг гэрээг KFW зохицуулж 2005 оны 11 дүгээр сард шинэчлэн байгуулахаар тохиролцсон байна. Хамгийн сүүлд байгуулсан 2 жилийн гэрээний дагуу үйлдвэрлэлийн салбарыг санхүүжүүлэх урт хугацааны санхүүжилтэнд зориулан сонгогдсон арилжааны банкуудад зээл олгоход тус дөхөм үзүүлэх зорилгоор Монгол Төв банкинд 10 сая евро олгожээ. Зээлийн дээд хэмжээ 500,000 евро байсан бөгөөд зээлийн 25 хүртэлх хувийг эргэлтийн хөрөнгөнд ашиглаж болох юм байна. Зээлийн хугацаа 5 жил бөгөөд үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа хоёр жил байна. Зээлийн хүүг (барьцааны нөхцөл) жилийн 7.75- 10 хувийг банкны үзэмжээр тогтоожээ. Оролцогч банк бүрт урт хугацааны зээлийн зөвлөх ажиллаж урт хугацааны зээлийн үнэлгээ, менежментийн эрсдлийн талаар мэргэжилтэн

бэлтгэх талаар сургалт зохион байгуулсан байна. Монгол банкинд өгсөн 10 сая евро зарцуулагдаж дууссан тул KFW сайхан 2.5 сая еврогийн санхүүжилтийг нэмж олгож, зээл авах дээд хэмжээг 250.000 евро болгон бууруулсан байна.

KFW болон Монголын Засгийн хоорондын дараагийн гэрээнд үүнтэй ижил жижиг, дунд үйлдвэрийн зээлийн хөтөлбөр тусгагдах эсэх нь тодорхой бус байна. Учир нь Монголын ЗГ компани эзэмшигчийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх сан байгуулах, орон сууц, даатгал, лизинг зэрэг чиглэлээр KFW-ээс санхүүгийн туслалцаа үзүүлэхийг хүсчээ.

Говийн санаачилга/АНУ-ын ОУХА/Хас банк – АНУ-ын ОУХА-аас санхүүждэг Мерси Корпсын удирдаж буй Говийн санаачилга хөтөлбөр нь хөдөөгийн зээлдэгчдэд (малчид, наймаачид) Хас банкаар дамжуулан бичил зээл олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрөөр баталгаажигдсан зээл нь 6 сарын хугацаатай 1.5- 2.2% хүүтэй. Хөтөлбөрөөр баталгаажигдаагүй боловч Хас банкнаас олгож буй зээлийн хүү сард 3-5% байна. Зээлийн хэмжээ 500-5000 ам. долларт хэлбэлзэх бөгөөд зээлийн дундаж хэмжээ 1500- 2000 ам. доллар байна.

АНУ-ын ОУХА/ ЭЗБШӨЧ төслийн Компани эзэмшигчийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх сан (хэлэлцэгдэж буй) – Энэхүү хөрөнгө оруулалтын сан нь банкны зээлийн адил дунд болон урт хугацааны санхүүжилтийг олгоно. ЭЗБШӨЧ төслөөс ийм сан байгуулах боломжийг судлаж, санд хамрагдах боломжтой монголын хэд хэдэн компаниудын үйл ажиллагаанд үнэлгээ өгөв. Гэвч одоогийн байдлаар нэг ч компани боломжит компаниар шалгараагүй байна.

АХБ (хэлэлцэгдэж буй) – АХБ нь компани эзэмшигчийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх сан байгуулах талаар хамтран ажиллах тухай ЭЗБШӨЧ төслийнхэнтэй ярилцаж байна.

JBIC (хэлэлцэгдэж буй) – JBIC нь жижиг дунд үйлдвэрийн зээлийг дэмжих хөтөлбөрийн талаар арилжааны банкуудтай шууд ярилцаж байна. Энэхүү зээлийн хэмжээ 10 сая евро байж магадгүй гэсэн яриа байна.

Санхүүгийн зардлыг багасгахад нөлөөлж болох бусад санал:

АНУ-ын ОУХА (ЭЗБШӨЧ төслийн хэрэгжүүлж буй төсөл) – Сонгогдсон хэдэн арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагуудад баталгаа өгөх зээлийн баталгаат байгууллага олон банк бүхий Хөгжлийн зээлийн газрыг (ХЗГ) байгуулах. Санхүүгийн байгууллагууд нь зээлийг урт хугацаатайгаар баталгааг үндэслэн олгож барьцаат зээлийн нөхцлийг таатай болгохоос гадна ЖДҮ хэрэгцээнд нийцэх санхүүгийн өөр бүтээгдэхүүнийг санал болгоно.

ХЗГ нь хувийн зээл олгогчдод зээлийн тодорхой хэсэгт баталгаа гаргахыг АНУ-ын ОУХА-аас зөвшөөрсөн хуулийн нэгж юм. Эдгээр баталгаа нь төслийг дотоодын хөрөнгөөр санхүүжүүлэх боломжийг олгоно. Зээл олгогчийн 50 хүртэлх хувийн зээлд баталгааг ганц болон олон зээлдэгчид санал болгосноор ХЗГ нь санхүүгийн зээлийн үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэхэд хувийн зээл олгогчдыг дэмжих зорилготой юм. Үүнээс гадна эдгээр зээл олгогчдод урт хугацааны зээл олгож барьцаат зээлийн нөхцлийг таатай болгоход тус дөхөм үзүүлэх болно. ХЗГ нь янз бүрийн нөхцөл байдалд зээлийн үйлчилгээг эрчимжүүлэх 4 янзын хувилбартай. Доор санал болгож буй зээлийн баталгааны эхний хоёр хувилбар нь ноолуурын салбар болон ЖДҮ -ийн бусад салбарт зээл олгоход илүү тохиромжтой юм.

- **Бүлэг зээлд гаргах баталгаа гээж** ”Зээлдэгч” гэдэгт зөвхөн тодорхой нэг төрлийн зээл бус өөр хэд хэдэн төрлийн зээл авдаг зээлдэгчдийг хэлнэ.

Баталгааг хэд хэдэн төрлийн зээл эсхүл зээл авсан бүлэг зээлдэгчдийн зээлийн 50 хүртэлх хувьд гаргахыг хэлнэ.

- **Зээлийн баталгаа** гэж зээлдүүлэгч болон зээлдэгчийг хоёуланг нь тодорхойлж төлбөрийг нэг мөр төлөх эсвэл хэсэгчлэн төлөх хувилбарыг санал болгодог бөгөөд үндсэн зээлийн 50 хүртэлх хувьд баталгаа гаргахыг хэлнэ.
- **Зөөврийн баталгаа** гэж зээлдэгчид хамгийн тохиромжтой нөхцөлтэй зээлийг хайж олох боломжийг бүрдүүлж, үндсэн зээлийн 50 хүртэлх хувьд баталгаа гаргахыг хэлнэ.
- **Бондын баталгаа** нь хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгод хүчтэй нөлөөлөх аргыг санал болгохоос гадна бондын зэрэглэлийг дээшлүүлж боломжит бонд худалдан авагчдын үндсэн бондын хэмжээний 50 хүртэлх хувьд баталгаа гаргахыг хэлнэ.

ХАВСРАЛТ В: ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ХҮМҮҮСИЙН ЖАГСААЛТ

ХАВСРАЛТ В: ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН ХҮМҮҮСИЙН ЖАГСААЛТ

Ноолуурын үйлдвэрүүд:

- Р. Лэм, Монгол ноолуур, тэмээний ноосны компаний Гүйцэтгэх захирал
- Д. Буянаа, Монитал ноолуурын (Шнайдер групп) Захирал
- Р. Борхүү, Сан Широ компаний Захирал
- Э. Энхсайхан, Эзио Форадори компаний Ерөнхий менежер
- Др.П. Бат-Очир, Оушн компаний Захирал
- М. Эрдэнэтуяа, Сор кашмир компаний Захирал
- А. Буяндэлгэр, Лоро Пьяна Монгол компаний Гүйцэтгэх захирал
- Ч. Энхтогтох, Буян Холдинг компаний Орлогч захирал
- Е. Голзио, Кашмир Файн компаний Захирал
- Ёнг Пин Хао, Монгол Викшен текстайлз компаний Ерөнхий менежер
- Б. Баяраа, Алтай кашмир компаний Захирал
- Р. Шмидт, Ээрмэл ХК-ий Зөвлөх
- Ц. Сэвдэнчиг, Говь корпорацийн Гүйцэтгэх захирал
- Ч. Түмэнбаяр, Говь корпорацийн Орлогч захирал
- Цогбаяр, Говь -2 үйлдвэрийн дарга
- Л. Сундуймижид, Ти энд Ай компаний Захирал

Холбоод:

- Г. Ёндонсамбуу, Ноос ноолуурын холбооны дэд ерөнхийлөгч
- Д. Алтанцэцэг, Ноос ноолуурын холбооны Захирал
- Б. Түмэнбаяр, МХАҮХТ-ын Ерөнхий менежер

Засгийн газар

- Доктор Б. Чимэдцэрэн, ҮХЯ-ны ахлах мэргэжилтэн
- Е. Отгонтуяа, ГХГХГ-ын мэргэжилтэн

УИХ

- Батжаргалын Батбаяр, УИХ-ын гишүүн

Хандивлагчид:

- Бэрри Хичкок, АХБ-ны Суурин төлөөлөгч
- Саха Дхеван Мейанатан, Дэлхийн банкны Суурин төлөөлөгч
- Ш. Алтанцэцэг, Дэлхий банк, эдийн засагч
- Дон Рим, Олон улсын валютын сан Суурин төлөөлөгч,
- А.Баттүшиг, KFW Bankengruppe (Германы Санхүүгийн байгууллага), Оффис менежер,

Стив Зимэрман, Говийн санаачилга (Мерси Корпс)

Шон Гренвилрос, DCOP, Говийн санаачилга (Мерси Корпс)

Алберт Гиренд, ГТХАН-ийн Экспортод чиглэсэн аж үйлдвэр, худалдааны бодлогын төслийн зохицуулагч, Л.Хулан, төслийн менежер

Бусад:

Доктор Ё. Загдсүрэн, Мал аж ахуйн хүрээлэнгийн захирал

Доктор Д. Алимаа, Нэхмэлийн хүрээлэн

Банк:

Д.Дарьбазар, Байгууллагын банкны газрын захирал, Анод банк

Мөнхтөр Дагва, Голомт банкны Аж ахуйн нэгжийн зээлийн хэлтсийн дэд захирал,

Б.Эрдэнэцэцэг, Худалдаа хөгжлийн банкны Байгууллагын банкны газрын данс хариуцсан ахлах ажилтан, Н.Туул, данс хариуцсан ажилтан

Мишгэл Ванде Велде, Худалдаа хөгжлийн банкны тусгай төслийн захирал

Деннис Опеншо, Худалдаа хөгжлийн банкны Үйл ажиллагаа хариуцсан гүйцэтгэх захирал

Нил Исбранцен, Елла Биверс, ХААН банк, DAI/EBRD зөвлөх

Жим Андерсон, Хас банкны ахлах зөвлөх